ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2017 №03 (61)
15 дахь жилдээ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батбуян БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Насанжаргал ГАНБАДРАЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Ганбат ЭРДЭНЭБАТ
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ШАДАР ЗӨВЛӨХ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D)

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Гарчиг

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төлөв байдал, чиг хандлага.....Д.Зүмбэрэллхам
- Монгол Улс дахь гэмт үзэгдлийн төлөв байдал, чиг хандлага.....Б.Мөнхдорж, Б.Мөнхсэргэлэн
- Нуугдмал гэмт хэргийг обьектив болон субьектив аргачлалаар тооцоолох арга зүй.....Б.Соронзонбаатар, Б.Энхболд
- Мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүй, боловсронгуй болгох зарим асуудал.....Б.Намсрай
- Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн бүртгэл-статистик.....Д.Зүмбэрэллхам, М.Цэдэвсүрэн
- Гэмт хэргийн статистик судалгаанд кластер шинжилгээг ашиглах нь.....П.Мөнхтуяа, Ш.Баярдулам
- Үндэсний аюулгүй байдлыг хангахад бүс нутгийн гамшгийн эрсдэлийг харгалзах нь.....Д.Сэржмядаг
- Кибер орчин ба террорист үйл ажиллагаа.....Д.Сумъяацэрэн, Л.Цогтбаяр
- Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал.....Ц.Бат-Эрдэнэ

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Ял тэнсэх институтын шинэлэг зохицуулалт, үр нөлөөг дээшлүүлэх арга зам.....Ц.Цэлмэг

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Цагдаагийн байгууллагын эрх зүйн актын системчлэлийн талаар судлагдсан байдлын тойм .....Д.Эрдэнэбаатар
- Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйл.....Б.Баянмөнх
- Эрүүгийн хэргийн талаарх мэдээллийн сангаас иргэдэд нээлттэй болгох мэдээллийг тодорхойлох нь: судалгааны үр дүн..... Б.Мөнхдорж, Д.Сумъяацэрэн, Б.Мөнхсэргэлэн

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

МОНГОЛ УЛСЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА[1]

Д.Зүмбэрэллхам
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
хууль зүйн доктор, профессор

Хураангуй: Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, чиг хандлагыг тодорхойлон, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах хэрэгцээ, шаардлагын талаар дурдсан.

Түлхүүр үг: Гэмт хэрэг, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа.

Нэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үзэл баримтлал

Манай улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүтэц, тогтолцоо эхлэн бүрдсэн цаг хугацаа нь социализмын үед таарсан учраас тэрхүү бүтэц, тогтолцоо нь коммунист үзэл суртлын үүднээс гэмт хэрэг ба түүний өрнөл хөдөлгөөнийг үнэлж үздэг үзэл суртлын агуулгыг илэрхийлсэн байдлаар хэлбэржиж, үйл ажиллагаа нь ч мөн тийм байдлаар явагдаж 1990-ээд онтой золгосон юм. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг нийгмийн мөнхийн үзэгдэл биш бөгөөд коммунизмын үзэл сурталд суурилсан нийгмийн нөлөө ба хувь хүний хүмүүжлийн үр дүнд аажмаар мөхөж үгүй болох жамтай гэсэн баримтлалыг мөрдлөг болгож байсан билээ. Төр, нийгмийг бүхэлд нь удирдаж байсан МАХН-ын 1960-аад оны үеийн баримт бичигт "*тус улсын эдийн засагт үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх социалист өмч дангаар ноёрхох болсноор гэмт хэрэг гарах нийгэм-эдийн засгийн үндэс устсан, одоо үед гарч байгаа гэмт хэргүүд нь гагцхүү хүмүүсийн үзэл санаа, дадал заншил дахь хуучин нийгмийн үлдэгдлийн хурц илрэл юм....*" гэж зааж байв.[2]

Социалист нийгэмд өөрт нь гэмт хэрэг үйлдэх шалтгаан ба нөхцөл байхгүй, харин гэмт хэрэг гарч байгаагийн учир шалтгаан нь өмнөх нийгмийн хоцрогдсон сэтгэлгээний үлдэгдэл, капиталист ниймийн хүрээллийн гаж буруу нөлөөл байгаатай холбож үздэг байсныг дээрх баримтаас харж болно. Энэ хоёр гол нөлөөллийн хүчин зүйл дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэтийн бодлого төвлөрч байсан гэж үзэж болно. Ийм ч учраас гэмт хэргийн түвшин ба гаралтыг бууруулах, бүр гаргахгүй байх явдлыг хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, социалист уралдааны шалгаруулалтын гол үзүүлэлт болгож байлаа. 1980-аад оны дундуур Баян-Өлгий, Ховд аймгуудын зарим суманд нэг ч гэмт хэрэг гараагүй тул үүнийг жишиг болгон "Гэмт хэргийг устгах тухай" Ардын депутатуудын их хурлын тогтоол гарч байсан нь үүний бодит жишээ юм.[3] Гэхдээ тэр үед гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа эрчимтэй явагдаж зарим үр дүнд хүрч байсан, энэ талаар одоо ч хэрэглэхэд ач холбогдлоо алдаагүй ажлын сайн арга барилууд байсныг үүгээр үгүйсгэхгүй гэдгээ тэмдэглэхийг хүсч байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохион байгуулалттай үйл ажиллагааны энэхүү социалист уламжлалыг сэтгэлгээний болон бодлого, үйл ажиллагааны түвшинд өөрчилж гэмт явдын шалтгаан нөхцлийг оршин буй нийгмийнхээ өөрийнх нь мөн чанар, хөгжил хөдөлгөөний байдалтай холбож үзэж түүнтэй тэмцэх арга барилаа шинээр тодорхойлох зорилт 1990-ээд оны ардчилсан өөрчлөлтийн дараа бидний өмнө тулгарсан юм. Үүнийг шийдвэрлэх суурь үзэл санааг 1992 оны шинэ Үндсэн хуулиндаа " ...нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үндсэн үүрэг мөн", "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна."[4] гэж тусгасан.

1990-ээд оны дараа нийгмийн шилжилтийн ид үед гэмт хэргийн гаралт огцом өсч түүний шинж чанарт ихээхэн өөрчлөлт гарч байгаа нь илт мэдэгдэж байсан боловч энэ өөрчлөлтийн хэмийг гүйцэхүйц хурдаар урьдчилан сэргийлэх ажлын арга барил шинэчлэгдэж амжаагүй, амжих боломж ч тааруу байсан гэдгийг хаана хаанаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байх. Энэ нь гэмт явдлын үзэгдлийг нийгмийнх нь талбар дээр бодитойгоор харж, түүний өөрчлөлтийн байдалд нийцүүлэн ажиллах үзэл хандлага гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг боловсруулах, түүнийг нь гардан зохион байгуулах аль ч хүрээнд шинэчлэгдэн төлөвших явц тийм ч амар хялбар байгаагүйтэй холбоотой. Дээр нь энэхүү нарийн үзэгдлийг шинжлэх ухааны үүднээс дагнан судлах суурь болон хавсрага судалгааны боломж тогтолцоо өнөө хэр бүрэлдээгүй л байна. Бүх шатны сургалтын агуулгыг ч гэсэн энэхүү үзэл баримтлалын ялгааны үүднээс хянаж цэгцлэх асуудал бүрэн хийгдсэн гэж үзэхээргүй байгаа.

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны эрх зүйн үндэс

---

[1] 2017-07-28-ны өдөр Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран зохион байгуулсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онол, практик" олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл

[2] МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1960 оны 170 дугаар тогтоол

[3] Г.Оюунболд. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй" УБ хот, 2017 он, 6 дахь тал

[4] Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

Төрийн бодлогын хэмжээнд энэ талаар авсан хамгийн том арга хэмжээ бол 1997 онд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" хуулийг УИХ-аас батлан мөрдүүлсэн явдал юм. Тус хуульд "Энэ хуулийн зорилт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, үндсэн чиглэл, төрөл, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино." хэмээн заасан бөгөөд ".Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн." гэж уг ажиллагааны агуулгыг тодорхойлсон байна. Хэдийгээр шууд томъёолоогүй боловч урьдчилан сэргийлэх ажлыг явуулахдаа үзэл суртлаас ангид байж, гэмт явдлын бодит нөхцөл байдалд нийцүүлэн хэрэгжүүлэх санаа энэ хуульд агуулагдсан гэж үзэж болохоор байгаа юм. Мөн "Авлигын эсрэг хууль"-ийг 2006 онд баталж энэ хуульд авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг тусгайлан тусгаж, түүнд байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үүрэг хариуцлагыг тусгасан бөгөөд энэ хуулийн дагуу Авлигатай тэмцэх газрыг байгуулж авлигын гэмт явдалтай тэмцэх ажлыг түүнд харьяалуулсан. Үүний дараа 2012 онд "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийг шинээр батлан гаргаж, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг шинэчлэн баталж энэ дагуу мэдүүлэг гаргуулан Авлигатай тэмцэх газарт хянадаг, мөн энэ чиглэлээр урьдчилан сэргийлэх ажил жич явуулах болсон. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг 2002 онд, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийг 2004 онд, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг 2012 онд, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг 2015 онд /шинэчлэн найруулсан/ тус тус батлан мөрдүүлж байна. Хамгийн сүүлд 2017 онд "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль"-ийг батлан мөрдүүлж эхлээд байна. "Энэ хуулийн зорилт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино." хэмээн тус хуульд заасан. 2017 онд батлан мөрдүүлж эхэлсэн "Зөрчлийн тухай хууль" ч мөн өөртөө урьдчилан сэргийлэх агуулгыг хадгалж байгаа. Дээр нь энэ ажлыг гардан гүйцэтгэдэг гол байгууллага болох Цагдаагийн байгууллагын тухай хуулийг 2017 онд шинэчлэн найруулж баталснаар энэ чиглэлээр тус байгууллагын чиг үүргийг илүү тодорхой болгосон. Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг мөн 1017 онд шинэчилсэн баталлаа.

Эдгээр хуулиудын заалтуудад онол, практикийн зүгээс үнэлгээ дүгнэлт хийлгүй зөвхөн байгаа байдлаар нь авч үзэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрх зүйн үүнднээс хэлбэржүүлэн зохицуулах талаар төрөөс шат дараатай, үргэлжилсэн арга хэмжээ авч ирсэн нь харагдаж байна. Бодлогын бусад баримт бичгүүдийг оролцуулахгүйгээр хуулиудын хүрээнд л гэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн үндэс ба зохицуулалт боломжийн хэмжээнд бүрдсэн гэж үзэхээр байгаа юм. Гагцхүү эдгээр хуулиудын хэрэгжилтийг нэгдмэл үр дүнд чиглүүлж нэгтгэн зохицуулж зохион байгуулах бүтэц зохион байгуулалт, хоорондоо сайтар уялдсан цогц үйл ажиллагаа хэрэгтэй.

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүтэц, зохион байгуулалт

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүргийг Засгийн газар, түүний дотор Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн байгууллага, Шүүх, Прокурор, бүх шатны засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хүлээсэн байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалтын төв нь Хууль зүй, дотоод хэргийн яам байх нь тодорхой. Хэдийгээр Цагдаагийн байгууллага гол үүрэг гүйцэтгэдэг боловч түүний үйл ажиллагааг хуулиар үүрэг хүлээсэн бусад байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулж, нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах үүргийг гүйцэтгэх ажил чиглэлийн Төрийн захиргааны төв байгууллагад төвлөрөх зайлшгүй шаардлага бий. Ийм чиг үүрэг бүхий "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл" гэдэг бүтэц ХЗДХЯ-нд байсныг хэсэг хугацаанд татан буулгасан байсныг 2016 онд сэргээн байгуулсан[5] нь зүйтэй алхам болсныг тэмдэглэхийн зэрэгцээ яамны энэхүү бүтцийн хэрхэн ажиллахаас улсын хэмжээний урьдчилан сэргийлэх ажил хамаарахаар хэмжээнд гол үүрэгтэй байх талаас нь бодож цаашид бэхжүүлэх шаардлагатайг бас хэлмээр байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль батлагдсантай холбогдуулан 1998 онд Цагдаагийн ерөнхий газрын Хэв журмын хэлтсийн бүтцэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасаг байгуулж 1999 оноос Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс болгон өргөжүүлж байсан байна. Гэвч 2003 оноос түүнийг Олон нийттэй харилцах хэлтэс нэртэй болгон өөрчилж 2010 оноос урьдчилан сэргийлэх чиг үүрэг Нийтийн хэв журам хамгаалах газрын Бодлого зохицуулалтын хэлтэст, 2014 оноос тус газрын Мэргэжил арга зүйн хэлтэст шилжүүлжээ. Улмаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд зааснаар урьдчилан сэргийлэх ажлыг "Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл" зохицуулан ажиллахаар болсон байна. Харин 14 жилийн дараа буюу 2017 оны 2 дугаар сараас ЦЕГ-ын бүтцэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлсийг сэргээн байгуулсан нь чухал алхам болжээ.[6]

Өнгөрсөн хугацаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд гол үүрэг гүйцэтгэх зохион байгуулалтын бүтцүүдийг яам, агентлагийн түвшинд тогтвортой, тууштай ажиллуулах нөхцлийг нь тэр бүр хангахгүй дээрх байдлаар байнгын шинжтэй өөрчлөн зохион байгуулж ирсэн нь урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөнд сөргөөр нөлөөлсөн байх өндөр магадлалтай. Учир нь дээр дурдсан олон хуулиудын хэрэгжилтийг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах, харилцан уялдуулж нэгдмэл үр дүнд чиглүүлэх, тэрхүү үр дүнг нь нэгдсэн

---

[5] Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны есдүгээр сарын 29-ны өдрийн 134 тоот зарлиг

[6] "Цагдаагийн байгууллагын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдал, цаашид тавих зорилт" хэлэлцүүлэгт тавьсан мэдээлэл, УБ хот, 2017.04.26

байдлаар үнэлж тооцоход гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг холбогдох байгууллагын бүтцийн нэгжид дагнуулан хариуцуулж үндэсний хэмжээний сүлжээ үүсгэсэн байдлаар ажиллуулах шаардлага цаашид улам бүр чухал болно. Ингэхгүйгээр урьдчилан сэргийлэх ажлыг урсгалаар явуулах, эсхүл хавсрага байдлаар хандах тохиолдолд түүний үр дүнд найдах аргагүй юм.

4. Гэмт хэргийн нөхцөл байдал

2004 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын шийдвэрээр[7] "Улсын хэмжээнд 1990-2004 онд бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг иж бүрэн судалж, нэгдсэн прогноз гаргах" ажлын хэсгийг 35 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулсан бөгөөд энэхүү ажлын хэсгийг ХЗДХ-ийн дэд сайд ахалж, нарийн бичгийн даргаар нь ХЗҮХ-ийн Криминалогийн судалгааны секторын эрхлэгчийн хувиар намайг томилсон юм. Энэ ажлын хэсэгт хууль, эдийн засаг, социологи, статистикийн салбарын ажилтнууд, эрдэмтэн судлаач нар, иргэний нийгмийн төлөөлөгчид зэрэг өргөн бүрэлдэхүүнтэй ажилласан. Энэ судалгааны зорилго нь ардчилсан хувьсгалын дараах 15 жилд үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг нийгмийн өөрчлөгдсөн харилцааны онцлогтой холбож авч үзэх, цаашид урьдчилан сэргийлэхэд анхаарах чиглэлийг тодорхойлоход оршиж байсан юм.

Уг судалгааны тайланд "*1990* онд бүртгэгдэж байсан гэмт хэргийн тоог *2004* оны буюу хамгийн буурсан түвшний гэмт хэргийн Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт явдлын байдал, түүний хөдөлгөөнийг сүүлийн 15 жилийн байдлаар авч үзэхэд 1990-1997 он хүртэл үргэлжлэн өсөж, түүнээс хойш 2004 он хүртэл тогтвортой буурсан бөгөөд тооны хувьд 1990 оноос 2 дахин өссөн хэмжээнд[8] цаашид тогтворжих хандлагатай болжээ. Өөрөөр хэлбэл, манай улсын хувьд эрүүгийн нөхцөл байдал нааштай хандлагатай болж, цаашид нийгэмд огцом өөрчлөлт гарахгүй бол энэ байдал тогтвортой үргэлжлэх нөхцөл бүрдэнэ...Мөнгөний ханш, инфляцийн түвшин, амьжиргааны доод түвшин, ажилгүйдэл гэсэн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг тухайн хугацааны гэмт явдалтай харьцуулахад инфляци, мөнгөний ханшны өөрчлөлт гэмт хэрэгт нөлөөлж байгаа гэдэг мэдэгдэхүйц нөлөөлөл ажиглагдсангүй. Харин амьжиргааны доод түвшин, ажилгүйдэл гэмт хэрэгт шууд нөлөөлж байгаа нь батлагдаж байна. Өөрөөр хэлбэл, ажилгүйдэл, амьжиргааны түвшингийн өссөн, буурсан хэлбэлзлийг гэмт хэргийн хөдөлгөөн дагалдаж байна. Энэ нь гэмт хэрэгт нөлөөлж байгаа нь гэмт хэргийн статистикийн судалгаа ба анкетийн судалгаагаар давхар батлагдагдаж байна."[9] гэж дүгнэсэн байна. Энэ бол гэмт хэрэг макро түвшиндээ иргэдийн ажил эрхлэлт, амжиргааны түвшинтэй шууд хамааралтай байгааг шинжлэх ухааны аргачлалаар судалж тогтоосон дүгнэлт учраас өнөөгийн нөхцөлд ч ач холбогдлоо алдаагүй гэж үзэж байна.

Түүнээс хойш ХЗҮХ-ийн бүтцэд гэмт явдал судлалын нэгж байхгүй болж энэ чиглэлийн судалгаа эзэнгүйдэх байдалтай, их дээд сургуулиудын эрдэм шинжилгээний чиг үүрэгт урсгалаар нь даатгаж иржээ. Гэмт хэргийн нөхцөл байдлыг зөвхөн тоон мэдээгээр тогтоодоггүй, гэмт явдлыг нийгмийн хөгжил, хөдөлгөөний байдалтай харьцуулан судалж байж зөв төсөөлөл гарах боломжтой байдаг.

Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 57 дугаар зүйлд "…Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг холбогдох байгууллагуудын дэргэд байгуулж ажиллуулна..."[10] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлд "21.1.Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах шинжилгээ судалгааны ажлыг эрхлэх эрдэм шинжилгээний байгууллага Хууль зүйн сайдын дэргэд ажиллана."[11] гэж тус тус заасан боловч өнөөгийн байдлаар эдгээр хууль тогтоомжийн аль нь ч хэрэгжээгүй явж ирсэн байна.

Гэтэл бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2000 онд 23352 байснаа 2016 онд 27167 болж өссөн дүн харагдаж байна. Энэ нь 2004 оны судалгаагаар төсөөлж байснаас харьцангуй өндөр байгаа бөгөөд тэр үеийнх шиг нийгмийн шилжилтийн үйл явцтай үүнийг хатуу холбож үзэхээргүй байгаа нь анхаарал татаж байна. Иймд гэмт хэргийн сүүлийн хугацааны өсөлтийн шалтгааныг дахин сайтар судалж байж түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг тодорхойлох шаардлага бий болсон гэж үзэхээр байна. Нэн ялангуяа мансуурал, хүний худалдаа, кибер, авлига, зохион байгуулалттай гэмт хэргүүд зэрэг манай улсад шинэ төрлийн гэж үзэж болохуйц гэмт хэргүүдийн шалтгаан нөхцлийг зөв оношлон тогтоож байж л тэдгээртэй үр нөлөөтэй тэмцэх боломж бүрдэх нь ойлгомжтой. Иймд энэ чиглэлд эрдэм шинжилгээ практик үйл ажиллагааны нэгдлийг хангах нь өнөөгийн тулгамдсан асуудал болжээ.

5. Чиг хандлага

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэний хэмжээний зохион байгуулалтын бүтцийг ХЗДХЯ-нд төвтэй сүлжээ байдлаар зохион байгуулж, удирдах нэгжүүдийг бие даасан чиг үүрэгтэйгээр бэхжүүлж, тэдгээрийн үйл ажиллагааны уялдааг хангаж одоогийн бүтцээ улам чамбайхуулахад анраарлаа хандуулах хэрэгтэй байна. Тус тусын хуулийн хэрэгжилтийг чиглэлийн байгууллагуудад нь найдаж орхилгүй, урьдчилан сэргийлэх ажлыг нь нэгдсэн удирдлага зохион байгуулалтад оруулж байж үр дүнд хүрэх боломж бүрдэнэ. Иймд ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь энэ чиглэлийн бүх хууль тогтоомжуудын хэрэгжилтийг бүрэн хангах ажлыг хариуцан тайлагнах явдлыг гол зорилго болгон ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

---

[7] Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2004 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 224 дүгээр тушаал

[8] 1990 онд 9060 гэмт хэрэг бүртгэгдэж байсан нь 15 жилийн дараа 18905 гэмт хэрэг болж 9845-аар буюу 52.0 хувь өссөнийг тайланд дурдсан

[9] Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2004 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 224 дүгээр тушаалаар "Улсын хэмжээнд 1990-2004 онд бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг иж бүрэн судалж, нэгдсэн прогноз гаргах" ажлын хэсгийн тайлан

[10] Монгол Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

[11] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, 1997 оны 12 дугаар сарын 5-ны өдөр

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хуульчилсан хууль тогтоомжуудын холбогдох заалтуудын хэрэгжилтийг нэгдсэн байдлаар зохион байгуулж, эдгээр хууль тогтоомжийн шинэтгэлийг даган сэтгэлгээ, үйл ажиллагааны арга барилаа орчин үеийн болон олон улсын чиг хандлагад нийцүүлэн өөрчлөн шинэчилж байх явдал ихээхэн чухал юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд хуульд заасан үүргийнхээ дагуу оролцож байгаа мэргэжлийн бус байгууллага иргэдийг үргэлжилсэн сургалтад хамруулж, нэгдсэн ойлголттойгоор уг үйл ажилагаанд оролцуулах, гэмт явдалд хандах сэтгэлгээний шинэчлэлт хийх тал дээр бодлого боловсруулж арга хэмжээ авах нь үр нөлөөг дээшлүүлэх чухал хүчин зүйл болно.

Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн тоо өсөлттэй байгаа нь нийгмийн шилжилтийг дагалдсан огцом өсөлтөөс өөр, цаашид тогтовортой харгалзан үзвэл зохих нийгмийн хүчин зүйлтэй холбоотой байх магадлалтай тул гэмт хэргийн тоо бүртгэлээр хязгаарлахгүй, криминологийн судалгааг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд түлхүү ашиглах шаардлага нэгэнт бий болж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулахын тулд одоо үйлчилж байгаа хууль тогтоомжид тусгасны дагуу Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах эрдэм шинжилгээний байгууллагыг байгуулах асуудлыг ХЗДХЯ судлан хойшлуулашгүй шийдвэрлэхийг санал болгож байна.

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ҮЗЭГДЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Б.Мөнхдорж, Б.Мөнхсэргэлэн
Цагдаа судлалын төв, Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн,
Хууль сахиулахын их сургууль

Хураангуй: Монгол Улс дахь гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн, тархалтыг тодорхойлж, гэмт хэргийн улмаас үүссэн хор хохирлыг илэрхийлэн гаргаж, гэмт хэргийн цаашдын чиг хандлагад дүн шинжилгээ хийв.

Түлхүүр үг: Гэмт хэрэг, гэмт явдал, гэмт үзэгдэл, чиг хандлага.

Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсад 231060 (жилд дунджаар 23106) гэмт хэрэг бүртгэгдэж, нийт хэрэгт 207843 хүн холбогдон шалгагдсан статистик мэдээлэл байна[12].

Хүснэгт 1. Гэмт хэргийн хөдөлгөөн

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Бүртгэгдсэн гэмт хэрэг	21268	20704	20373	19825	19197	22089	25362	27318	27757	27167
Өсөлт, бууралт /хувиар/	16.5	-2.7	-1.6	-2.7	-3.2	15.1	14.8	7.7	1.6	- 2.1
Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүн	17810	18642	19612	19378	17982	19734	22286	23737	24857	23805
Өсөлт, бууралт /хувиар/	5.9	4.7	5.2	-1.2	-7.2	9.7	12.9	6.5	4.7	-4.2

График 1. Гэмт хэргийн хөдөлгөөн



Гэмт хэргийн үзүүлэлт 2007 оноос 2011 он хүртэл 9.7%-аар буурч, харин 2011 оноос 2016 он хүртэл 41.5%-аар өссөн байна. Сүүлийн 10 жилийн дунджаас харахад гэмт хэргийн үзүүлэлт жилд 655 хэргээр нэмэгджээ.

Монгол Улсад Эрүүгийн хариуцлага хүлээлгэх субъектын насны доод хязгаар 16, зарим тодорхой гэмт хэрэг дээр 14 нас байдаг учраас 16 ба түүнээс нас гэж авч үзсэн, мөн олон улсын түвшинд харьцуулах байдлаар 18-аас дээш насны хүмүүсийн тоонд харьцуулан тооцоолов.

Албан ёсны статистикийн мэдээлэлд үндэслэн тооцоолоход жилд дунджаар 16 ба түүнээс дээш насны 10 000 хүнд 115, 100 000 хүнд 1153 гэмт хэрэг, 18 ба түүнээс дээш насны 10 000 хүнд 122, 100 000 хүнд 1219 гэмт хэрэг тус тус оногдож байгаа нь Монгол Улсын гэмт хэргийн нөхцөл байдлыг бусад улс оронтой харьцуулах үзүүлэлт болно. Үүнээс үзэхэд хүн ам цөөн, гэмт хэргийн түвшин өндөр, түүнээс үүссэн хор уршиг, хохирол харьцангуй их байгаа нь ажиглагдаж байна[13].

График 2. 18 ба түүнээс дээш насны хүн амд ногдох гэмт хэрэг

[12] Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл.
[13] Үндэсний статистикийн хороо, www.1212.mn



График 3. 16 ба түүнээс дээш насны хүн амд ногдох гэмт хэрэг



Гэмт хэргийн үзүүлэлтийн төлөв байдлаас үзэхэд дэлхий дахинд үйлдэгдэж буй гэмт үзэгдэл ерөнхийдөө өсч байна. Тодруулвал, сүүлийн 30-40 жилд гэмт үзэгдэл дунджаар 3-4 дахин өсчээ. ОХУ-д 6-8 дахин, АНУ-д 7-8 дахин, Англи, Швейцарт 6-7 дахин, Францад 5-6 дахин, Германд 3-4 дахин, Японд 1.5-2 дахин гэмт үзэгдэл өссөн байна[14].

Монгол Улсын 1968 оноос хойшхи 45 жилийн гэмт үзэгдлийн төлөв байдал, хандлагыг авч үзье. Монгол Улсад гэмт хэргийн гаралт 1968 оноос 2016 он хүртэл 7.9 дахин өсчээ. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас өрсөлдөөнт зах зээлийн эдийн засгийн шинэ нийгэмд шилжсэн үе болох 1992 он 12467 гарч байсан бол сүүлийн 25 жилийн хугацаанд 2016 он 27167 болж, 2.2 дахин өссөн байна.

График 4. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо.1968-2016 он

[14] Болдбаатар, Ж. Нямдаваа, О. Криминологи. УБ. 2010



Монгол Улс дахь гэмт хэргийн төлөв байдал, чиг хандлагаас үзэхэд тухайн үеийн нийгэм, эдийн засгийн шалтгаан гэж шууд хэлэхээс илүүтэй төр засгийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар баримталж буй бодлого, Эрүүгийн хуультай шууд холбоотой гэсэн дүгнэлтийг ч хийж болохоор байна. Иймд тухайн нийгэм дэх сөрөг үзэгдэлтэй тэмцэхийн тулд сөрөг гэж үзэж буй нийгмийн харилцаатай тэмцэх, арилгахын тулд Эрүүгийн хуулийг оновчтой болгох нь гэмт үзэгдлийн чиг хандлагад шууд хамааралтай байдал ажиглагдав.

Харин Монгол Улсын шүүхээр жилд дунджаар 5961 гэмт хэрэг шийдвэрлэгджээ[15]. Цагдаа, авлигатай тэмцэх зэрэг хуулийн байгууллагад жилд дунджаар 23106 гэмт хэрэг бүртгэгдсэн байдаг бол үүний 25.7% нь буюу 1/4 нь шүүхээр шийдвэрлэгджээ.

График 5. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо



	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Бүртгэгдсэн гэмт хэрэг	21268	20704	20373	19825	19197	22089	25362	27318	27757	27167
Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг	5831	5812	5407	5460	5877	6161	6169	6375	6756	5762

Гэмт хэргийн тархалт:

Сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэргийн 41.3% нь орон нутагт, 58.7% нь нийслэлд үйлдэгдсэн байна.

График II.6. Монгол Улс, Нийслэлд бүртгэгдсэн гэмт хэрэг

[15] Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээлэл



График 7. Нийслэл дэх гэмт хэргийн эзлэх хувь



Харин гэмт хэргийн 2007 онд 49.4%, 2009 онд 55.7%, 2010 онд 54.8%, 2011 онд 56.1%, 2012 онд 58.4%, 2016 онд 65.9% нь Улаанбаатар хотод үйлдэгдэж, цаашид ч улам өсөх хандлагатай байгаа дүр зураг ажиглагдаж буй нь харамсалтай. Гэмт хэргийн үзүүлэлт төвлөрсөн суурин газруудад ихэвчлэн үйлдэгдэж байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хувьд "Улаанбаатар хот гэмт хэргийн үнэмлэхүй төв" болж байна. Хотжилт нь гэмт хэргийн үндсэн нөхцөл, орон зай, хамаарах хүчин зүйлс болж байна.

Гэмт хэргийн төрөл

Улсын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 33.4%-ийг хулгайлах, 30.4% нь бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах, 7.9% нь залилан мэхэлж авах, 6.6% нь ТХХАБАЖЭсрэг, 5.3% нь танхайрах, 1.7% нь дээрэмдэх, 1.2% нь завших, үрэгдүүлэх, 1.1% нь хүчиндэх бусад төрлийн гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

График 8. 2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн төрөл (Эрүүгийн хуулийн зүйлээр)



Улсын хэмжээнд 2016 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 27689 хүн эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаагаараа, 84 байгууллага, ААН эд хөрөнгөөрөө хохирчээ. Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн 41.0% нь эмэгтэй, 4.8% нь насанд хүрээгүй байгаа ба гэмт хэргийн улмаас 880 хүн нас барж, 11257 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтсэн байна.

Дүгнэлт

Сүүлийн 10 жилийн статистик мэдээлэлд үндэслэн гэмт хэргийн үзүүлэлтээр чиг хандлагыг тодорхойлоход цаашид жилд дунджаар 655 хэргээр өсөн нэмэгдэх прогноз байна. Хүн амд оногдох гэмт хэргийн үзүүлэлт ч гэсэн нэмэгдсэн байна. Ялангуяа Улаанбаатар хотод үйлдэгдэж буй гэмт хэргийн үзүүлэлт улсын хэмжээнд эзлэх хувийн жин, ердийн хөдөлгөөн талаасаа өсөн нэмэгджээ.

Олон улс дахь гэмт хэргийн юүлүүр тогтолцоо (criminal funel system) талаас үзвэл цагдаагийн байгууллага болон авлигатай тэмцэх газар зэрэг хуулийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн 25% нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгддэг. Үлдсэн 75% нь цагдаа, авлигатай тэмцэх зэрэг хууль сахиулах байгууллагаас шалгах явцад болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэгддэг гэж болно.

Гэмт хэргийн юүлүүрийн амсар хэдий чинээ өргөн, үзүүр нь хэдий чинээ нарийн байх тусам хууль сахиулах тогтолцоо сул, авлига өндөр, хууль хэрэгжихгүй, ял завших нөхцөл бүрдсэнийг илэрхийлдэг. Товчхондоо дүгнэж хэлбэл, гэмт хэргийн юүлүүрийн тогтолцоо нь хууль эрх зүйн орчин сайтай газарт яагаад, ямар шалтгаанаар шат шатандаа багасч байгаа нь тодорхой харагддаг бол эсрэгээр нуугдмал хэрэг ихтэй, хууль сахиулах байгуулага, прокурорын байгууллагын шатанд гэмт хэрэг шийдэгдэхгүй байгаа сул талыг харуулдаг.

Иймд орчин үеийн криминологийн шинжлэх ухаан гэмт хэргийн юүлүүрийн зарчмыг хууль эрх зүйн тогтолцоо, менежменттэй холбож судлахыг илүүд үзэж байна.

НУУГДМАЛ ГЭМТ ХЭРГИЙГ ОБЬЕКТИВ БОЛОН СУБЬЕКТИВ АРГАЧЛАЛААР ТООЦООЛОХ АРГА ЗҮЙ

Б. Соронзонбаатар
Хууль сахиулахын их сургуулийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч
Б.Энхболд
Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хошууч

Хураангуй: Нуугдмал гэмт хэргийн ойлголт, ангилалыг тодорхойлж, түүнийг хэмжих арга зүй, нуугдмал гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, таамаглал дэвшүүлэн, бууруулах арга замын талаар дурдсан.

Түлхүүр үг: Нуугдмал гэмт хэрэг, нуугдмал гэмт хэргийг хэмжих, нуугдмал гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан, нөхцөл

1. Нуугдмал гэмт хэргийн ойлголт

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй цогцолбор байдлаар авч хэрэгжүүлэхэд юуны өмнө Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор тогтоох шаардлага зүй ёсоор тавигддаг. Цагдаагийн байгууллагаас гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг нэг бүрийг бүртгэх чиглэлээр 2002 оноос хойш жил дараалан тодорхой зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа ч дорвитой өөрчлөлт гарахгүй байгаа нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны доголдол, цаашид гэмт хэрэг өсөх, гэмт хэрэг нуугдмал шинжтэй болох анхдагч нөхцөл гэж үзэх үндэстэй.

Тийм учир гэмт хэргийн тухай бодит мэдээлэлтэй байж, түүнтэй тэмцэх үйл ажиллагааг төлөвлөх, арга барилаа өөрчлөх, хүч арга хэрэгслийг зөв зохистой ашиглах, хэтийн төлөв боловсруулах, мэргэшсэн албадыг бий болгох нь чухал учир хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдээгүй, нуугдмал гэмт хэргийн талаар судлах нь сүүлийн үед эрдэмтэн судлаачдын туйлын зорилт болоод байна.

Нуугдмал гэмт хэргийн талаар XIX зууны эхээр анх удаа анхаарал хандуулж, А.Кетле, Э.Ферри, Ф.Захаревич[16] нарын эрдэмтдийн эрдэм шинжилгээний бүтээлд тусгалаа олсон байна. А.Кетле "үйлдэгдсэн гэмт хэргийн зөвхөн тодорхой хэсэг л мэдэгддэг ба нуугдмал гэмт хэргийн эзлэх хувь нь олон дахин их хувь эзэлдэг[17]". Түүнчлэн гэмт хэргийг гурван хэсэгт хуваж үзжээ.

Нэгдүгээрт: илэрсэн гэмт этгээдтэй илэрсэн гэмт хэрэг,

Хоёрдугаарт: илрээгүй гэмт этгээдтэй илэрсэн гэмт хэрэг,

Гуравдугаарт: илрээгүй гэмт этгээдтэй илрээгүй гэмт хэрэг[18],

Энэхүү ангиллыг эрдэмтэн Ф.Захаревич 1853 онд өөрийн судалгааны үндсэн дээр баталсан. "...Голоос тороор барьсан загасны тоо голд байх загасны тоог илэрхийлдэггүйтэй адил баривчлагдсан этгээдийн тоо, үйлдэгдсэн гэмт хэргийн тоог бүрэн илэрхийлэх хэрэгсэл биш юм.[19]" Италийн криминалистикч Э.Ферри XX зууны эхэн үед өөрийн социологийн судалгааны үндсэн дээр бодит гэмт хэрэг илэрсэн гэмт хэрэг хоёрын хооронд харилцан хамаарал байдаг ба иргэдийн гэмт хэрэг гэж үзсэн үйлдлийн талаарх мэдээлэл өгөх хүсэл эрмэлзлийн их бага байхаас шууд хамаардаг гэж үзжээ. Түүнээс гадна "илэрсэн", "мэдээлсэн" гэмт хэргийн 65 хүртэл хувь нь ямар нэг хариуцлага хүлээдэггүй гэж үзсэн байна[20].

Дэлхий нийтэд нуугдмал гэмт хэргийн талаар судалгаа шинжилгээний ажлуудын үр дүнд маш их ахиц гарсан хэдий ч нуугдмал гэмт хэргийн нэгдсэн ойлголтод хүрээгүй, нарийвчилсан шалгуур үзүүлэлтийн тодорхойлолт боловсруулалтын шатанд байна. Манай улсад нуугдмал гэмт хэргийг тооцоолох аргачлал, арга зүй боловсруулагдаагүй байгаа нь криминологийн прогноз хийх боломжийг үгүйсгэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил үр дүнгүй байгаагийн гол шалтгаан бол энэ талаар чиглэсэн судалгаа хийгдээгүй, анхаарал хандуулахгүй байгаад оршиж байна.

Латент гэдэг нь "latentis" гэсэн латин үгнээс эхтэй бөгөөд үзэгдэхгүй, нууц, далд, нуугдмал[21] гэсэн утга агуулдаг бөгөөд шинжлэх ухаан танин мэдэхүйн олон салбарт өргөнөөр хэрэглэгддэг байна. Гаднаас үл мэдэгдэх, үл харагдах үзэгдэл, үйл явцыг тодорхойлоход ашиглагддаг байна. Нуугдмал байдлыг зөвхөн судалж буй субьектэд үл үзэгдэх бодит болж буй үйл явцыг хамааруулан ойлгох ба нэг субьектэд үл үзэгдэн орших үйл явц маань нөгөө субьектэд ил байх харьцангуй байдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Дээрх байдлыг

---

[16]Сорокин Н.О. "Измерение параметров скрытой преступности как криминологическая проблема" Дисс... канд юрид. Наук, Нижний Новгород, 1998.

[17] Кетле.А. "Социальная физика, или опыт исследования о развитии человеческих способностей" Киев. 1911. /262 хуудас/ Храмов С.М. "латентная преступность: методология познания и основные направления противодействия" Брест.2010. 15 хуудас.

[18] Кетле.А."Социальная физика, или опыт исследования о развитии человеческих способностей" Киев. 1911. 263 хуудас/ Храмов С.М. "латентная преступность: методология познания и основные направления противодействия" Брест. 2010. 16 хуудас.

[19] Захаревич Ф. "Опыт юридической статистики" Дотоод Явдлын яамны сэтгүүл. 1853. Дугаар 41. 258 хуудас./ Храмов С.М. "латентная преступность: методология познания и основные направления противодействия" Брест. 2010. 16 хуудас.

[20] Ферри Э. "Уголовная социология" М.1908. 258 хуудас./ Храмов С.М. "латентная преступность: методология познания и основные направления противодействия" Брест. 2010. 16 хуудас.

[21] http://ru.wikipedia.org/wiki

харгалзан шинжлэх ухаан танин мэдэхүйн салбар бүрт өөрийн зөвхөн тэр салбарт тохирохуйц бодит шалгуур үзүүлэлт тогтоох нь нуугдмал үйл, үйл явцыг судлахад дөхөм юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгыг хангахад зохих ач холбогдолтой мэдээлэл хэрэгтэй байдаг. Криминологийн ач холбогдол бүхий мэдээлэлд албан ёсны эх сурвалжаар гэмт хэргийн системчлэгдсэн статистик тоо бүртгэл ордог. Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг, нөөц хүчийг хуваарилах зөв зохистой зохицуулах, төлөвлөх, ашиглахад зөвхөн статистик тоо бүртгэлд агуулагдаж буй мэдээлэл ашиглагддаг. Криминологийн шинжлэх ухааны өмнө оршин буй зорилго зорилтод хүрэх, үр дүн гаргахад тоо бүртгэлд тусгалаа олсон бүрэн дүүрэн бодит мэдээлэл ач холбогдолтой. Тиймээс гэмт хэргийг бүртгэгдсэн, нуугдмал гэж хуваан ангилах нь статистик тоо бүртгэлд мэдээлэл байгаа эсхүл байхгүй гэсэн үндэслэлээр хуваан үзэж болно.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, нуугдмал гэмт хэрэг гэсэн ойлголтууд нь ерөнхий ба тусгай шинж чанарыг агуулна. Хэдийгээр нуугдмал гэмт хэрэг нь ерөнхий зүйлийн доторх тусгай хэсэг ч өөрийн гэсэн онцлогтой[22]. Бүртгэгдсэн гэмт хэргээс нуугдмал гэмт хэргийн ялгагдах онцлог нь түүний далд нууц шинж бөгөөд нуугдмал гэмт хэргийг бүрэлдэхүүн, шинж, өгөгдхүүнүүд албан ёсны тоо бүртгэлийн системд байдаггүй. Албан ёсны тоо бүртгэлд бүртгэгдээгүй хэдий ч нуугдмал гэмт хэрэг нь гэмт хэрэг болохын хувьд дараах шинжүүдийг агуулсаар байдаг:

- Нийгэмд аюултай үзэгдэл, эрүүгийн хариуцлага хүлээгээгүйн улмаас дахин давтагдах, их хэмжээний орон зайг хамарсан байдаг,
- Нийгмийн харилцааны гүнд оршин, түүний өөрчлөлтийг даган хувьсаж өөрчлөгдөх чадамжтай байдаг,
- Зарим шинжээчийн үзэж байгаагаар нуугдмал гэмт хэрэг нь бүртгэгдээгүй гэмт хэргүүдийн нийлбэр бөгөөд бүртгэгдсэн гэмт хэргээс хэд дахин илүү байдаг учир нийгэмд тархсан гэж үздэг,
- Өөрийн гэсэн онцлог бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсгийн дийлэнх хэсгийг хөнгөн хүндэвтэр, хэргүүд эзэлдэг бол нуугдмал гэмт хэрэгт хөнгөн, хүндэвтэр, хүнд хэргүүд давамгайлдаг байна. Үүнд: Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд, иргэдийн эрх, эрх чөлөө, эрүүл мэндэд халдсан ямар байдлаар ар гэр, хамаатан садан, найз нөхдийн болон эрхэлж буй ажил үүргийн хувьд нуун дарагдуулсан хэргүүд эзэлдэг байна. Түүнчлэн, онц хүнд гэмт хэргүүд бага ч гэсэн тодорхой хувийг эзэлдэг. Энэ байдал нь нийгэмд олны анхааралд үргэлж байдаг сэдэв хэдий ч нуугдмал гэмт хэрэг дундаа эзлэх хувь бага байна гэж эрдэмтэд үзэж байгаа[23],
- Эрүүгийн болон байцаан шийтгэх (хууль сахиулах үйл ажиллагаа) цаг хугацааны хувьд нуугдмал гэмт хэргийн тооноос хоёр тохиолдолд хасагддаг. Үүнд:

а/ тоо бүртгэлд бүртгэгдсэнээр

б/ хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсноор

- Нуугдмал гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсэг нь орон зайн хувьд тухайн нутаг дэвсгэрийн онцлог шинжид нийцсэн бүтцийг агуулдаг.

Дээрх шинжүүдийг агуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж нуугдмал гэмт хэрэг гэх үзэгдлийн тодорхойлолтыг өгч болно. Нуугдмал гэмт хэрэг гэж "Цаг хугацаа, орон зайн хүрээнд нийгэмд аюултай үзэгдэл болох нийгмийн болон эрүүгийн эрх зүйн шинжийг агуулсан тодорхой нөхцөлд үүсч бий болсон албан ёсны бүртгэлийн системд ороогүй байдлаар илэрхийлэгдсэн бодит гэмт хэргийн нэг хэсгийг нуугдмал гэмт хэрэг гэнэ[24]"

Нуугдмал гэмт хэрэг үүсэн бий олох шалтгаан нь объектив субъектив шинжээр тодорхойлогдсон эдийн засаг улс төр, үзэл суртал ухамсрын, эрх зүйн болон бусад нийгмийн харилцаан дахь нөхцөлүүдээр нөхцөлдсөн нууц далд үйл явцуудын адил нийгмийн харилцааг удирдах, гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын сул дорой байдал алдаанаас үүдэлтэй байна гэж хэлж болно.

Нуугдмал гэмт хэргийг объектив нуугдмал, субъектив нуугдмал гэмт хэрэг гэж ангилж болохоор байна.

Объектив нуугдмал гэмт хэрэг гэдэгт "нуун дарагдуулсан" өөрөөр хэлбэл, хууль сахиулах байгууллагад ямар нэг хэлбэрээр мэдэгдсэн боловч нэгдсэн тоо бүртгэлд ороогүй гэмт хэрэг. Энэхүү ангиллыг орчин цагт үүсэн бий болж буй нуугдмал гэмт хэргийн механизмыг ажиглахад түүнийг тодотгох шаардлага байна гэж үзэж байна. Үйлдэгдсэн нөхцөл байдлын улмаас нуугдмал гэмт хэргийн бүрэлдэхүүнд орж байгаа, өөрөөр хэлбэл, хууль эрх зүйн хийдэл цоорхой, боловсронгуй бус байдлаас хамаарч гэмт хэрэгт тооцогдохгүй, байгууллага албан тушаалтны мэргэжлийн алдаа дутагдал, гэмт хэргийн ертөнцийн сөрөг үйл ажиллагаа зэргээс болж тоо бүртгэлд бүртгэгдээгүй гэмт хэрэг нь ***объектив нөхцөл*** байдлын улмаас энэ байдалд байгаа гэж үзэж болно.

Субъектив нуугдмал гэмт хэрэг гэдэгт "нууц далд" гэмт хэрэг өөрөөр хэлбэл, бодит байдалд үйлдэгдэж хэн нэгэн этгээд хохирсон боловч хууль сахиулах байгууллагад огт мэдэгдээгүй гэмт хэрэг.

2. Нуугдмал гэмт хэргийг тооцоолох арга зүй

2.1. Объектив нуугдмал гэмт хэргийг хэмжих арга зүй

ОХУ-д нуугдмал гэмт хэрэг, ялангуяа объектив нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлох зорилгоор өнгөрсөн зууны 60-аад оны дунд үеэс дорвитой судалгааны ажлууд хийгдэж ирсэн байна. Р.З.Акутаев, Х.Д.Аликперов, С.Босхолов, Г.Булатов, С.В.Вицин, Б.Гаврилов, К.К.Горяинов, А.И.Долгова, Г.И.Забрянский,

---

[22] СазоноваН.В. "Понятие латентной преступности" Уголовное поаво и современность: Межвуз. Сб. Науч.тр. Вып. 6. Красноярск: СибЮИ МВД, 2002.-С.8-180-184.

[23] АкутаевР.М. "Криминологическая характеристика латентной преступности" Дисс... д-ра юрид, наук СПб, 2000.

[24] Сазонова Н.В. "Латентная преступность: понятие, причины, измерение "Дисс.. канд юрид наук. Кранснoярск.. Автореферат С.9. 2004

А.А.Конев, В.В.Лунеев зэрэг криминологич эрдэмтэд өөрсдийн судалгааны ажлаа чиглүүлж байсан. Манай улсад энэ талаар хийсэн дорвитой судалгааны ажил хараахан байхгүй ч эрүүгийн эрх зүйн, байцаан шийтгэх эрх зүйн болон криминологич эрдэмтэд тодорхой түвшинд анхаарлаа хандуулж ирсэн.

А. Нуугдмал гэмт хэргийг тооцох аналогийн арга

Гэмт хэргийн нийгэм эрх зүйн тодорхойлолтод үндэслэн хүн ам зүй, эдийн засаг зэрэг нийгмийн бүхий л салбарын нөхцөл байдлаар адил түвшинд байгаа тодорхой хоёр нутаг дэвсгэрийн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг харьцуулан нэгтгэн дүгнэх үйл ажиллагааг ***аналогийн*** арга гэнэ.

Х1 - Г1 = Х2 – Г2 (Н1)

Х1 - Эхний нутаг дэвсгэрийн нэгжийн хүн амын тоо,

Г1 - Эхний нутаг дэвсгэрийн нэгжийн гэмт хэргийн тоо,

Х2 - Хоёр дахь нутаг дэвсгэрийн нэгжийн хүн амын тоо,

Г2 - Хоёр дахь нутаг дэвсгэрийн нэгжийн гэмт хэргийн тоо гэж үзвэл:

Г2 (Н) = Г1 * Х2 / Х1 хоёр дахь нутаг дэвсгэрийн нэгжийн нуугдмал гэмт хэргийн тоог гаргаж болно.

Дээрх томьёог ашиглахын өмнө нутаг дэвсгэрийн нэгжүүдийг адилтгаж харьцуулах хэрэгтэй ба тухайн нутаг дэвсгэрийн гэмт хэргийн бүтцийг сайтар судлан дүгнэж харьцуулах жишгийг тогтооно. Ингэхдээ гэмт хэргийг тодорхой төрлөөр болон нутаг дэвсгэрийн хүрээгээр төрөлжүүлэн ангилж болно. Үүний үр дүнд тухайн нутаг дэвсгэрийн объектив нуугдмал, субъектив нуугдмал гэмт хэргийг тус тусад нь гаргаж ирэх нь чухал. Тухайн нэгж нутаг дэвсгэрийн нуугдмал гэмт хэргийн нөхцөл байдлыг тодотгох зорилгоор явуулах асуулгын эрсдэлийг тогтоох зорилгоор тусгай коэффициент гаргаж ашиглах нь бодит байдлыг үнэлэхэд ач холбогдолтой. Бүртгэсэн өргөдөл, гомдол мэдээллийн нийт тоог бүртгэсэн гэмт хэргийн тоотой харьцуулж, гарсан тоог объектив нуугдмал гэмт хэргийн тоотой харьцуулж нуугдмал гэмт хэргийн боломжит тоог гаргаж авч судалгаа шинжилгээнд ашиглаж болно.

Б. Нуугдмал гэмт хэргийг тооцох тусгай коэффициентын арга

Гэмт хэргийн тоог эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалын тоог татгалзсан тогтоолыг хүчингүй болгосон тогтоолын тоотой харьцуулж гарган авна. Нутаг дэвсгэрийн нэгжийн сүүлийн 2-5 жилийн тоон өгөгдэхүүнийг ашиглах нь нуугдмал гэмт хэргийн өсөлт бууралтад дүн шинжилгээ хийх дундаж байдлыг тогтоох боломжийг нээн гаргана. Тусгай коэффициентыг дараах томьёо ашиглан гаргана:

*Кд =((З-Д)/Д(П-Пт)Пт)*100%*

З - нийт бүртгэсэн гэмт хэргийн тухай өргөдөл, гомдол, мэдээлэл

Д - нийт бүртгэсэн гэмт хэрэг

П - нийт эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалын тоо

Пт - татгалзсан тогтоолыг хүчингүй болгосон тоо

Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтээр дээрх томьёог ашиглан нийт гэмт хэргийн тухай гомдол мэдээлэл, нийт гэмт хэрэг, татгалзсан материал, татгалзсан тогтоолыг хүчингүй болгосон зэрэгт дүн шинжилгээ хийж гаргаж болно.

В. Хүн амын тоонд харьцуулах арга

Нуугдмал гэмт хэргийн нөхцөл байдлыг тогтоох талаар 27 улсад[25] явуулсан судалгааны дүнд аль ч улсын нуугдмал гэмт хэргийн тоон үзүүлэлт нийт хүн амын 5.6%-аас илүү гараагүй байна[26]. Нийгэм эдийн засаг, хууль эрх зүйн онцлог бүхий улсуудад нийт хүн амд эзлэх нуугдмал гэмт хэргийн тоо 5.6% даваагүй байгаагаас үзвэл нуугдмал гэмт хэргийн тоон үзүүлэлт тодорхой хэмжээнд орших магадлал байна гэж үзэх нь судалгааны сонирхол татах бөгөөд магадгүй үнэнд нийцэх асуудал нь маргаантай хэвээр байна.

Эрүүгийн хууль тогтоомжид заасан гэмт хэрэг бүр өөрийн онцлогоос хамааран нуугдмал байдлын эзлэх хувь нь тус тусдаа өөр байдаг. Гэмт хэргийн үйлдлийн арга, нөхцөл байдал, цаг хугацаа орон зай сэдэлт, хохирол зэргээс хамааран тухайн гэмт хэргийн нуугдмал байдал тодорхойлогддог.

Хээл хахууль авах, өгөх гэмт хэрэгт нуугдмал байдлын эзлэх хувь маш өндөр байдаг. Энэ гэмт хэргийн талаар мэдээлэх, гэрчлэх асуудал маш төвөгтэй эрсдэлтэй байдаг ба аль аль талын эрх ашиг хөндөгддөг учир нуугдмал байдалд оршдог. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт хохирол, хохирогчоос хамааран нуугдмал байдал бага хувийг эзэлдэг. Нийт гэмт хэрэгт хулгайлах гэмт хэргийн эзлэх хувь 30-40% байгаа нь, хээл хахууль авах өгөх гэмт хэргийн эзлэх хувь 0,5-1% байгаа нь нуугдмал гэмт хэрэгт урвуу хамааралтайгаар илэрхийлэгдэнэ. Үүнээс үүдэн нуугдмал гэмт хэргийг нуугдмал шинж чанар бага, их, онц их гэж ангилж болно.

2.2. Субъектив нуугдмал гэмт хэргийг хэмжих арга зүй

Барууны хөгжингүй орнуудад нуугдмал гэмт хэргийн талаар XX зууны дунд үе буюу 1940-өөд оноос эхлэн эрчимтэй судалгаа хийж эхэлсэн. Энэхүү судалгаануудын үндсэн чиглэл нуугдмал гэмт хэргийн тоон хэмжээг хэмжих арга аргачлал боловсруулахад чиглэгдэж байсан. Энэ үйл ажиллагаанд барууны оронд түгээмэл хэрэглэгддэг "Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа" (*National crime victimization survey*), "Гэр бүлийн хүчирхийллийн судалгаа" *(National family Violence surveys),* "Үндэсний эмэгтэйчүүдийн судалгаа" *(National women's study), "Өөрийгөө мэдээлэх судалгаа" (self reported survey) зэргийг дурдаж болно.*

---

[25] (АНУ, ХБНГУ, Финлянд, Польш гэх зэрэг)

[26] Ли.Д.А. Уголовно-статистический учёт: структурно-функциональные закономерности: моногр. М.Русский мир, 1997. 21 хуудас.

Эдгээр судалгаа нь нийгмийн гишүүдэд чиглэгдэх бөгөөд тэдний гэмт хэрэгт хохирч байсан болон гэмт хэрэг үйлдэж байсан талаарх туршлагыг илрүүлэхэд чиглэгдсэн ярилцлага, санал асуулгын аргаар авагдсан судалгаа хамаардаг. Судалгааг явуулахад тусгайлан боловсруулсан асуултаар түүвэрлэлтэд багтаасан иргэдээс авдаг. Судалгаанд оролцогчдын тоо нь тухайн нийгмийн гишүүдийн санал бодлыг илрүүлэхэд хүрэлцэхүйц байх шаардлагатай.

А. Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа (National crime victimization survey)

Гэмт хэргийн албан ёсны статистик нь зөвхөн цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн тоон үзүүлэлт байдаг бол гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа нь гэмт хэрэг, халдлагад өртсөн боловч цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй нуугдмал гэмт хэргийн түвшинг хохирогчдоор дамжуулж тодорхойлохыг оролддог аргачлал. Тухайлбал, "Та өнгөрсөн жилийн хугацаанд гэмт хэргийн хохирогч болж байсан уу?", "*Хэрэв хохирогч болж байсан бол цагдаагийн байгууллагад мэдэгдэж байсан уу?", "Хэрэв цагдаагийн байгууллагад мэдэгдэж байгаагүй бол ямар шалтгаантай бэ*?" гэсэн нуугдмал гэмт хэргийг илрүүлэхэд чиглэгдсэн өргөн хүрээний асуултыг иргэдэд тавьдаг.

Б. Гэр бүлийн хүчирхийллийн судалгаа (National family Violence surveys)

Нуугдмал гэмт хэргийн тодорхойлох өөр нэг арга зүй нь гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг гэмт хэргийн түвшинг тодорхойлох зорилгоор санал асуулга, ярилцлагын арга ашиглан түүврийн аргаар сонгосон гэр бүлийн гишүүдийн судалгаа явуулах арга зүй. Тухайлбал, "*Та гэр бүлийн хүрээнд ямар нэгэн хүчирхийлэлд өртдөг үү?", "Хүчирхийллийг хэн үйлддэг бэ"* гэх мэт асуултыг тавьдаг.

В. Өөрийгөө мэдээлэх судалгаа (self reported survey)

Сүүлийн нэг жилийн хугацаанд гэмт хэрэг үйлдэж байсан боловч цагдаагийн байгууллагад мэдэгдэж байгаагүй гэдгээ судалгаанд оролцогч хүлээн зөвшөөрөх байдлаар нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлох аргачлал байдаг. Энэ аргачлалд ихэвчлэн жижиг гэгдэх хүний бие махбодид хөнгөн гэмттэл учруулах, эд зүйл хулгайлах, зарим тохиолдолд хүчиндэх, доромжлох зэрэг хэргийн чиг хандлагыг тогтооход ашигладаг. Тухайлбал, "Та өнгөрсөн жилийн хугацаанд ямар нэгэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж байсан уу?" гэх мэт асуулт тавигддаг.

3. Монгол Улсын нуугдмал гэмт хэргийн нөхцөл байдал, таамаглал

2012 онд цагдаагийн байгууллага гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 79561 хүлээн авч, үүнээс эрүүгийн хэрэг үүсгэсэн гомдол, мэдээлэл 27566, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материал 49564, татгалзсан материалыг прокурорын байгууллагаас хүчингүй болгосон тогтоолын тоо 51 гэсэн үзүүлэлттэй байна. Харин 2016 онд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 94324, үүнээс эрүүгийн хэрэг үүсгэсэн гомдол, мэдээлэл 27167, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалын тоо 65709, Татгалзсан материалыг прокурорын байгууллагаас хүчингүй болгосон тогтоолын тоо 21 байжээ. Үүнийг тусгай коэффициентын аргачлалаар тооцоолж "график IV.1"-т үзүүлэв.

График IV.1. Нуугдмал гэмт хэргийн нөхцөл байдал таамаглал (2012-2016)

Он	Нуугдмал байх магадлал
2012	0.19
2013	0.15
2014	0.38
2015	0.26
2016	0.07
Дундаж	0.21

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд өнгөрсөн 5 жилийн дунджаар 1 гэмт хэргийн цаана 0.21 гэмт хэрэг нуугдмал байх магадлалтай байжээ.

"График IV.2"-т үзүүлснээр 2012-2016 оны хооронд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэг үүсгэсэн гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалыг харуулсан байна.

График IV.2. Нийт гэмт хэргийн гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэг үүсгэсэн тоо



Дээрх үзүүлэлтээс харахад цагдаагийн байгууллагад цугларч байгаа нийт гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл жил дараалан өсч байгаа бөгөөд нийт гомдол, мэдээллийн 30 орчим хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэсэн нь гэмт хэргийн нуугдмал байх магадлалыг өсгөж байна.

"График IV.3."-т Монгол Улсад гэмт хэргийг шийдвэрлэж буй байдлыг 5 жилээр харуулсан байна. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн буюу эрүүгийн хэрэг үүссэн хэрэг маргаан, түүнд холбогдсон хүмүүсийн 21 орчим хувь нь шүүхээр шийдвэрлэгдэж байна. Энэ тоог цагдаагийн байгууллагад бүртгэсэн гомдол мэдээллийн тоотой харьцуулбал 7.4 хувийг эзэлж байна.

График IV.3. Монгол Улсад гэмт хэргийг шийдвэрлэж буй байдлын зураглал

Нуугдмал гэмт хэргийг судалснаар гэмт хэрэг үйлдэгсдийн зүгээс үзүүлж буй сөрөг үйл ажиллагаатай тэмцэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх ач холбогдолтой. Дээрх зорилгыг биелүүлэхэд дараах хэд хэдэн ажлыг санал болгож байна. Нуугдмал гэмт хэргийг тооцоолох субъектив аргачлал манай улсад төдийлөн сайн хөгжөөгүй, одоогоор хийгдсэн судалгаа байхгүйг харгалзан иргэдийн дунд санал асуулгын болон ярилцлагын аргаар тогтмол хугацаанд асуулга явуулж хэвших, нийт улсын болон нутаг дэвсгэрийн хэмжээний нуугдмал гэмт хэргийн индекс тогтоон ашиглаж хэвших, гэмт хэргийн тоон мэдээнд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг хүчингүй болгосон тоог нэгтгэн гаргаж байх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албан ёсны төсөл хөтөлбөрийн хүрээнд нуугдмал гэмт хэргийн талаар судалгаа явуулах эрх зүйн болон эдийн засгийн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Дээрх арга хэмжээнүүд нь гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр ач тусаа өгөх боломжтой бөгөөд гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, хүний үндсэн эрх, эрх чөлөөг сэргээх, хангах, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэн чадваржуулахад чиглэгдэнэ.

МЭДЭЭЛЭЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Б.Намсрай
ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах
газрын ахлах мэргэжилтэн,
цагдаагийн хошууч

Товч утга: Мэдээлэлд дүн шинжилгээ хийх орчин үеийн арга туршлага, програм хангамжийг хэрхэн хослуулах талаар энэхүү илтгэлээр хөндөж тавилаа.

Түлхүүр үг: Мэдээлэлд дүн шинжилгээ хийснээр мэдээ бий болно. Мэдээ нь аливаа бодлого стратегийн үндэслэл болно.

Нэг.Оршил

Хүмүүс өөрт байгаа мэдээллээ бусадтай хуваалцах замаар Google Wikipedia гэх мэт дэлхийг хамарсан цахим сүлжээнүүд бий болгожээ. Энэ нь үлгэр домог, хов жив, захидал, ном хэвлэл, пейжер, утсан харилцаа, телевиз, радио, аудио болон видео бичлэг зэрэг эх сурвалжаас хэд дахин хялбар, хямд үнээр мэдээллийг солилцох боломжийг олгож байгаа билээ.

Хууль сахиулах байгууллагын ажилтнууд цаг үеэ даган мэдээллийн сүлжээнд идэвхитэй ажиллаж, аливаа мэдээлэл (Raw information)-ийг олж авах, дүн шинжилгээ хийх, мэдээ тайлан (news) боловсруулах арга зүйд суралцах хэрэгцээ шаардлага тулгарсан байна.

Үүнээс шалтгаалж цагдаагийн байгууллагын мэдээллийн санг өргөтгөх, хууль сахиулах болон бусад байгууллагатай хамтарсан дундын сүлжээ, програм хангамжийг нэвтрүүлэх, хууль сахиулагч мэргэжилтнүүдийг аливаа мэдээлэлтэй ажиллах арга зүйд жигд сургаж дадлагажуулах ажил үгүйлэгдэж байгаа болно.

Хоёр.Гадаад орнуудын хууль сахиулах албадын туршлага

- АНУ, ОХУ зэрэг холбооны улсуудад Фюжн центр, Холбооны мэдээллийн алба зэрэг аль нэг хууль сахиулах байгууллагад харъяалагдахгүй бие даасан үйл ажиллагаа явуулдаг мэдээлэл, дүн шинжилгээний албад байна.[27] Энэхүү байгууллагуудын зарим нь улсын болон муж улсын төсвөөс, зарим нь хувийн хэвшил, олон нийтийн байгууллагаас санхүүждэг.
- Англи, Шинэ Зеланд зэрэг улс орнуудад гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний агентлаг, дүн шинжилгээний албад ажиллаж терроризм, зохион байгуулалттай, үндэстэн дамнасан гэмт хэргийн талаар эрсдэл бүхий мэдээллийг нэгтгэн боловсруулах үүргийг дагнан гүйцэтгэдэг.[28] Эдгээр нэгж, алба хаагчид нь ихэвчлэн цагдаагийн байгууллагын төсвөөс санхүүжиж байна.
- Австрали, БНХАУ-д мэдээлэл нэгтгэн боловсруулах ажлыг бүтэц, зохион байгуулалтын нэгжээс илүүтэй хууль сахиулах үйл ажиллагаа талаас нь хөгжүүлж, алба хаагч бүр үүрэг гүйцэтгэх явцдаа олж авсан мэдээллийг тогтоосон шугамчлалын дагуу дата санд оруулах, түүнд нь шат шатны албан тушаалтнууд үнэлгээ өгөх хэлбэр давамгайлах болсон.[29] Энэхүү үйл ажиллагааг улсын төсөв болон цагдаагийн сан, төрөл бүрийн төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байна.
- Зарим оронд мэдээлэл дүн шинжилгээний албыг улсын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий тагнуулын албанд түшиглэн байгуулах жишиг байгаа бөгөөд тухайлбал Израйлын Моссад агентлагийн сөрөг тагнуулын Шабак албыг дурьдаж болно.[30]

Гадаад орнуудын хууль сахиулах байгууллагын жишиг туршлагаас дүгнэж үзэхэд мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, хөгжүүлэх замаар дүн шинжилгээний эх сурвалжийг бий болгоход онцгой анхаарч байна. Гэхдээ улс бүрийн үндэстэн ястны онцлог, соёл, зан заншил, хүн ам, эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин харилцан адилгүй тул аль нэг улсыг онцлон дуурайх албагүй.

Гурав.Мэдээлэлд дүн шинжилгээ хийх зарчим, програм хангамж, дүн шинжээч

Мэдээлэлд дүн шинжилгээ хийх хэд хэдэн голлох зарчим байдаг. Үүнд: компьютерийн програм хангамж болон түүнийг чадварлаг эзэмшсэн дүн шинжээч байх, мэдээллийг тогтоосон цаг хугацаа, графикийн дагуу санд төвлөрүүлж, дүн шинжилгээ хийх, мэдээллийн урсгалыг бүрэн шугамчилсан хэлбэрт оруулж, давхардалыг арилгах зэрэг тус тус болно.

Эдгээр зарчим, аргачлалыг бүрэн нэвтрүүлэхгүйгээр мэдээлэл дүн шинжилгээний ажлыг үр дүнтэй явуулах боломжгүй бөгөөд хууль сахиулах салбарын ажилтнууд анхнаасаа сууриа зөв тавих нь чухал байна. Тухайлбал: мэдээллийг эх сурвалж, тоо чанар, шат дамжлага зэрэг шалгууруар шугамчлал буюу конверийн системд оруулснаар давхардал арилж нэг цонхоор гарах боломж бүрдэнэ.

Програм хангамжид суурилсан мэдээллийн сан бүрдүүлж, түүнийг бүтээлчээр ашигласнаар цагдаагийн байгууллагын мэдээллийн урсгал системчлэгдэнэ. Өөрөөр хэлбэл удирдлагаас өгсөн үүрэг даалгавраар дагнан ажилладаг /Reactive/ арга барилаас салж, мэдээлэлд суурилан ажиллах /Proactive/ хэлбэрт шилжих юм.

Тодруулбал: цуглуулсан мэдээллийн үнэн бодит байдлыг биечлэн судлах, ажлын зураг авалт хийх, дата сангийн мэдээлэлд тулгуурлан илтгэх хуудас, танилцуулга бэлтгэх, нутаг дэвсгэрийн нөхцөл байдалд биечилсэн судалгаа хийх, уулзалт, ажлын хэсгийн хурал зохион байгуулах, санал асуулга авах зэргээр "Proactive" байдлаар ажиллахыг илүүд үзэх хэрэгтэй. Олон улс дахь үүний тод жишээ нь Английн үндэсний

---

[27] https://www.dhs.gov/state-and-major-urban-area-fusion-centers
[28] CIB, New Zealand, tutor 2017
[29] Golden Shield Implemention, China, 2014
[30] Израйлын тагнуулын алба Моссад, 2015, Орчуулга

цагдаагийн газрын харъяа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэлтсийн дүн шинжилгээний алба, ажилтнууд байдаг.[31]

Өөрөөр хэлбэл мэдээлэлд дүн шинжилгээ хийх мэргэжилтэн нь зөвхөн компъютерийн ард суугаад байхгүй, нөхцөл байдлыг биечлэн судлах практик туршлагатай байх ёстой. Мөн мэдээллийг тогтсон стандартаар солилцож, дүн шинжилгээ хийхийн тулд зарим төрлийн өндөр үзүүлэлттэй програм хангамжийг эзэмших хэрэгтэй болдог. Тухайлбал: Excel, Spss болон Vensim, Offender DataBase, Profiling RS, Microsoft Camera IDFN зэрэг статистик, дүн шинжилгээний программуудыг ашиглаж байна.

Энэ хирээр дүн шинжилгээ хийх ажилтан нь IOS, WINDOWS, ANDROID үйлдлийн систем бүхий төхөөрөмжтэй харьцаж ажиллах, камерт бичигдсэн мэдээллийг унших[32], дуудлага мэдээллийн "ProQA for Police", "CAD" програмаас шүүлт хийх, өглөөний рапорт, шуурхай хурал, цуглааны тэмдэглэлд товчлол хийх чадварыг эзэмшсэн байх хэрэгтэй.

Жишээ №1:

Статистикийн мэдээлэлд боловсруулалт хийхэд Spss программыг тохиромжтой гэж үздэг. Энэхүү ухаалаг программын тусламжтай цагдаагийн ажилтнууд аливаа эрсдэл, давуу тал, орц, гарц, арга зам зэрэг хэрэгцээтэй мэдээлэл, шийдлийг олж хардаг. Үүний тулд мэдээллийн урсгалыг анхнаас нь олон хувилбарт загварчлалд оруулна. Жишээ нь: тухайн цагдаагийн байгууллага жагсаал, цуглааны үед үүрэг гүйцэтгэх чадварын хувьд хир байгааг тодорхойлохын тулд конторын болон үндсэн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын орон тооны судалгаа, тусгай хэрэгслийн хангалт, захиргааны хяналтад байгаа хүмүүсийн тоо, жагсаал, цуглааны давтамж, жагсах идэвхитэй хүн амын тоо гм аль болох олон хүчин зүйлийг тооцож программд шивж оруулна.

Программд мэдээллийг нэмж оруулах тусам гарц хувилбарыг бодитой зааж өгнө. Тухайлбал: өмнөх жагсаал, цуглааны талаарх мэдээлэл, цагдаагийн байгууллагаас ажиллах төлөвлөгөө, зураглал, тэдгээрийг хэрхэн тодотгосон талаарх мэдээллийг нэмж оруулснаар урьд оруулсан үзүүлэлтүүдийн нэгэн адит математик статистикийн аргаар загварчилж дүгнэлт, судалгаа хийж өгдөг. Spss программын өгөгдлийн санг тухайн дүн шинжилгээний ажилтан өөрийн зорилгод тохируулан загварчилж, баяжилт хөдөлгөөнийг хийх боломжтой. Үүний тулд программыг ашиглан мэдээллийг эхнээс нь зөв төрөлжүүлж хийх нь чухал. Тухайлбал: санд төвлөрүүлэх мэдээллийн хэлбэр, хэмжээ, мэдээллийг эрэмблэх, тооцоолох, харицуулах, архивлах (ой санамж үүсгэх) гм.

Жишээ №2:

Анх АНУ-ын Холбооны мөрдөх товчоонд нэвтрүүлж байсан "Criminal profiling" сангийн АСР зэрэг дүн шинжилгээний програмууд нь сэжигтэн, хохирогч, гэрч зэргээр тухайн гэмт хэрэгт холбогдол бүхий хүмүүсийн ерөнхий мэдээлэл, гадаад төрх, зан байдал болон хэргийн газраас олдсон, эд мөрийн баримтаар хураагдсан мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийхэд ашиглана.

Criminal Profiling[33]-ийн түгээмэл ашиглагддаг хэлбэр нь гэрч, хохирогчийн мэдүүлэг, үзлэгийн тэмдэглэл, дүрс, дууны бичлэг зэрэг гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан эд мөрийн баримт, сэлт мэдээллийг хэргийг гардан шалгаж байгаа ажилтнуудтай хуваалцдаг.

Сэжигтний талаарх тодорхойлолтонд сэтгэл зүйн байдал, нас, хүйс, зан характер, оршин суугаа газар орны болон гэмт хэргийг үйлдэхдээ урьдчилан бэлтгэсэн эсэх, үйлдлийн арга, давтамж, хэргийн газрын тоо зэрэг нөхцөл байдлууд хамаарна. Өөрөөр хэлбэл хүний хийсэн үйлдэл, түүнээс үлдсэн ул мөр, баримт сэлтүүд нь тухайн хүнийг тодорхойлно гэсэн зарчимд тулгуурлана. Энэ төрлийн дүн шинжилгээг цуврал болон захиалгат хэрэг, зохион байгуулалттай гэмт явдал, терроризмтой тэмцэхэд түгээмэл ашигладаг.

Мэдээлэлд дүн шинжилгээ хийж байгаа ажилтан нь өөрийн олж авсан тоо болон чанарын мэдээлэлд ямар хүчин зүйл нөлөөлж байгааг анхаарч үнэлэлт дүгнэлт өгөх хэрэгцээ байнга тулгардаг.

Жишээ №3:

Монгол Улс дахь гэмт хэргийн илрүүлэлтийн түвшинг гадаадын бусад орны үзүүлэлттэй харицуулж үзэхэд[34]:

Үзүүлэлт / Улс орон	Монгол	Швед	Норвеги	Дани	Голланд	Герман	Англи
Сүүлийн 5 жилийн дундаж	84%	17%	47%	18%	25%	54%	29%

Дээрх үзүүлэлтээс харахад манай улсаас нийгэм, эдийн засгийн хөгжлөөр илүү орнууд эсрэгээрээ гэмт хэргийн илрүүлэлт багатай болж байна. Энэ нь манай улсад гэмт хэргийн илрүүлэлт тооцож байгаа аргачлал бусад орноос өөр байгаа гэсэн дүгнэлтэд хүргэнэ.

Жишээ №4:

2017 оны 7 дугаар сард бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 32 хувь өсчээ. Энэхүү өсөлтөд шинээр хэрэгжүүлж эхэлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалт хэрхэн нөлөөлж байгааг судалж үзэхэд:

---

[31] Англи Улсад нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн нэгжийн мөрдөн шалгах багт 1-2 криминологи судлаач болон дүн шинжээчид байдаг бөгөөд тэд мөрдөгч нарын цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар мөрдөх ажилд дэмжлэг үзүүлэх үүрэг гүйцэтгэдэг.

[32] Камерийн бичлэгт шүүлт хийх, зам маршрутыг цаг хугацаа чиглэлээр нь тогтоох, автомашины камер болон гэрчийн мэдүүлгийг шалгах гм.

[33] http://www.apa.org/monitor/julaug04/criminal.aspx

[34]https://www.bra.se/download/18.366ea42214d6cb5d9d4635ad/1433939412790/2015_The+clearance+rate+in+Sweden+and+other+countries.pdf

Хувилбар **A:** ЭХХШТХ-ийн зохицуулалтаар гомдол мэдээллийг 5 хоногт хянаж шийдвэрлэдэг болсноор энэхүү хугацаанд хохирлын хэмжээ тогтоож, шаардлагатай баримт цуглуулж амжихгүй болсон тул хэрэг бүртгэлтийн хэргийн тоо нэмэгдсэн.

Хувилбар **B:** Дээрэм, булаалт болон хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах зэрэг зарим гэмт хэргийг нэгтгэж хуульчилсан тул энэ төрлийн хэргүүдийн тоон үзүүлэлт өсч бүртгэгдсэн. Бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан тохиолдолд учирсан хохирлын хэмжээнээс үл хамааран гэмт хэрэгт тооцогдох болсон.

Хувилбар **C:** Бүртгэгдэж шалгагдсан хүнийг алах гэмт хэргийг үйлдлийн аргаар нь үзвэл бүгд ахуйн хүрээнд үйлдэгдсэн байна. Иймд "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хууль батлагдсанаар ахуйн хүрээнд хүчирхийлэл үйлдэж, хүний амь насыг хохироох гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин сайжирч, үүний зэрэгцээ цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэгчийг тусгаарлах, хохирогчийг хамгаалах арга хэмжээг ихээхэн хүч хаяж цогц байдлаар авч хэрэгжүүлсэн.

Хувилбар **D:** Зарим төрлийн тухайлбал хүрээлэн буй орчны эсрэг хэрэгт бага бус, үлэмж хэмжээний хохирол учруулсан тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байсан бол шинэ хуулиар хохирлын хэмжээг үл харгалзан хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгахаар болсон, мөн УЕП-ийн шийдвэрээр Мөрдөн байцаах алба өөрөө илрүүлсэн байгаль орчны эсрэг гэмт хэргүүдэд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар харъяалал тогтоосноор илрүүлэлт өссөн гм.

Дөрөв.Мэдээллийн эх сурвалжийг ашиглах

Цагдаа, хууль сахиулах байгууллагад хэрэглэгдэж байгаа мэдээллийн эх сурвалжийг ерөнхийд нь ил, далд гэж ангилдаг. Гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан болон хуулиар төрийн нууцад хамаарсан мэдээ материалыг далд эх сурвалж, эдгээрээс бусдыг ил эх сурвалж хэмээн ойлгож байна.

Мөн цахим шуудан, вэб хуудас, үүрэн холбоо, skype, фейсбүүк, твиттер, инстаграмм зэрэг мэдээллийн сүлжээнд ямар зорилгоор дүн шинжилгээ байна гэдгээс ил, далд мэдээлэл гэх ойлголт үүснэ. Тухайлбал: сонингийн болон цахим сүлжээнд байршуулсан нийтлэл, сэтгэгдэл, жиргээ, хүмүүсийн ам дамжсан яриа, тэмдэглэл зэрэг төрөл бүрийн мэдээллийг системчлэн нэг урсгалд оруулснаар энэ мэдээлэл нууцлах шаардлагатай мэдээлэл болж хувирдаг.

Дүн шинжилгээний ажилтны хувьд ил болон далд мэдээлэл дээр ажиллахын гол ялгаа нь нууцлал, аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ гэсэн асуудал байдаг. Цагдаагийн байгууллагаар жишээ татаж үзэхэд дүн шинжилгээ хийх мэдээллийн эх сурвалж буюу төрөл нилээд өргөн цар хүрээтэй. Мэдээлэл шуурхай удирдлагын төв, Шуурхай удирдлагын штабын хоногийн мэдээ, Мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчил, Объект, субъектийн хяналт, эрэн сурвалжлалт, галт зэвсэг, гэрээт харуул хамгаалалт, ял шийтгэгдсэн хүний статистик, байгууллагын хэмжээний танилцуулга, илтгэх хуудаснууд /хэргийн, нэгдсэн арга хэмжээний, хамгаалалтын гм/, тайлан төлөвлөгөө, судалгааны ажлын тайлан, ажлын хэсгийн протокол гм олон төрлийн мэдээллийг цагдаагийн байгууллага сан бүрдүүлж ашигладаг.

Тухайлбал: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын дагуу алба, нэгж, албан тушаалтнууд мэдээллийг өөр хоорондоо цахимаар шуурхай солилцож, мэдээллийн санг эргэлтэнд оруулах нөхцөл бүрдсэн байна.[35] Харин цаашид мэдээллийг төрөлжүүлэн ангилах, ажлын горим, конверийн тогтолцоонд оруулах асуудал чухал байна.

Жишээ №5 (Стратегийн шинжтэй дүн шинжилгээ)

Сан бүрдүүлэх, сангаас мэдээлэл авах эрхийг олгох	Алба нэгжээс ирүүлсэн мэдээллийг хүлээн авч бүртгэх, ангилах, хуваарилах, хадгалах
Сангаас алба хаагч, нэгжид хэрэгцээтэй мэдээллийг гаргаж өгөх	ЦЕГ-ын удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хүлээн авч бүртгэх, ангилах, хуваарилах
Сангийн мэдээлэлд тулгуурлан танилцуулга бэлтгэх	Өгөгдсөн үүрэг даалгавар, ирүүлсэн танилцуулга мэдээллийг чиглэл хариуцсан дүн шинжилгээ, судалгааны ажилтнуудад хуваарилах, хяналт тавих
Сангийн мэдээлэлд үнэлгээ шинжилгээ хийх	Шаардлагатай асуудлаар нэмэлт судалгаа хийлгэх
Сангийн мэдээллийн баяжилтанд өдөр тутмын хяналт тавих	Зөвлөмж, танилцуулга, шийдвэрийн төсөл, эрх бүхий байгууллагад хүргүүлэх санал хүсэлтийн төслийг боловсруулах, хүргүүлэх гм.
Хууль сахиулах бусад байгууллагатай санамж бичиг, гэрээ байгуулж дундын сан үүсгэх	

бүдэг сайн харагдахгүй байгаа тохиолдолд дүрсийг хуулбарлан авч, сэргээн засварлуулах;

- Эсхүл уг машины ард явж байсан тээврийн хэрэгслийн жолооч нартай холбогдож автомашины камертай эсэхийг тодруулах хэрэв байгаа бол бичлэгийг хуулбарлаж авах. Үүний дараа цагдаагийн байгууллагын

[35] ЦБҮАЖ-ын код 717 "Мэдээллийн дундын сан бүрдүүлэх, ашиглах", код 120.19 "Албан бичиг, захидлаар харилцах" журам, 2017 оны 4 дүгээр сард нэмж өөрчлөгдсөн.

мэдээллийн сангаас жолоочийн мэдээллийг авч, оршин суугаа хаягаар нь цагдаагийн эргүүл жижүүрийг явуулж шалгуулах, баривчлан саатуулах;

- Сэжигтнийг хохирогчоор таниулах, сэжигтний тээврийн хэрэгсэл, гар утсанд үзлэг хийх, гар утаснаас орсон гарсан дуудлагыг шалгах, алдагдсан эд зүйл борлуулсан, нуусан газрыг заалгаж, газар дээр нь очиж шалгах, хураан авах, битүүмжлэх гм.

Тав.Одоо байгаа бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам (санал дүгнэлт)

5.1 Нууцлал аюулгүй байдлыг хангах эсэхэд эргэлзээ төрдөг учраас дүн шинжилгээний программын ашиглалт манайд хумигдмал байдаг. Нөгөө талаас програмд ажиллах чадвартай, практик туршлагатай алба хаагч хэд байгаа вэ гэдэг нь эргэлзээ төрүүлсэн асуудал юм. Мэдээллийн дундын сан бүрдүүлэх, хуваалцах асуудал нууцын тухай хууль тогтоомжийн хүрээнд ихээхэн бэрхшээлтэй тулгардаг. Энэ нь гарсан гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэх, дүн шинжилгээний аргаар сэжигтнийг тодорхойлох зэрэг тактикийн дүн шинжилгээнээс эхлээд бодлого боловсруулах түвшинд хүртэл бэрхшээл учруулж байна.

Иймд хууль сахиулах байгууллагууд өөрийн мэдээллийн сангийн сервер хамгаалалт, програмд хууль бусаар нэвтрэх эрсдлүүдийг бодитой үнэлүүлэх, үүний дараа холбогдох аюулгүй байдлын арга хэмжээг авах, мөн санд нэвтрэх алба хаагчдыг шифрлэх, сангийн мэдээлэлтэй харьцаж ажиллах ажилтнуудын чадвар, албаны ёс зүйн сургалт явуулах хэрэгтэй юм.

5.2 Гадаадын ихэнх орны туршлагаас үзэхэд цагдаагийн байгууллага өөрийн мэдээллийн санг цаг, минутаар баяжуулж, цагдаагийн ажилтан бүр ямар нь хамаа байхгүй мэдээлэл цуглуулж, түүнийгээ мэдээллийн сандаа шивж оруулдаг. Энэ нь өөр нэг үүрэг гүйцэтгэж байгаа ажилтанд хэрэгтэй мэдээлэл байдаг. Яг л хогийн сав шиг харагдах энэхүү мэдээллийн сан нь дотроо цагдаагийн ажилтны бичсэн илтгэх хуудасны мэдээллийн сан, тухайн цагдаагийн газраас зохиосон урьдчилан сэргийлэх ажил зэргээр хэдэн зуун төрөлд хуваагдана.

Эдгээрээс дүгнэн үзэхэд мэдээллийн сангийн төрөл, баяжилтыг стандартад оруулж, аль болох хайрцаглахгүй байхад анхаарч төрөл бүрийн мэдээллийг санд шивдэг болгох хэрэгтэй. Жишээ нь: хүн амины гэмт хэрэг дээр ажиллах, эсхүл хэргийн газраас нотлох баримт бэхжүүлж авах чиглэлээр мэдээллийн санд блог байршуулж болох бөгөөд ингэснээр цагдаагийн ажилтнууд хоорондоо арга туршлагаа солилцох боломжийг бий болгоно.

Үүний дараа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын мэдээллийн сантай цагдаагийн байгууллагын мэдээллийн санг холбох, хувийн хэвшилд ашиглагдаж байгаа хяналтын камеруудыг цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын төв, газар, хэлтсийн жижүүрт холбох зэрэг хамтын ажиллагааны чанартай арга хэмжээ тоо томшгүй байна.

Жишээ нь №7

Манай улсын аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн эзэмшилд 12178 хяналтын камер /Улаанбаатар хотод-6936, Орон нутагт-5242/-ыг ашиглаж байгаа бөгөөд техникийн өргөтгөлийг хийж чадвал эдгээр камерийг харилцан тохирсны дагуу цагдаагийн камерийн хяналтын нэгдсэн сүлжээнд холбох бололцоо байна. Үүний тулд аж ахуйн нэгж, байгууллагуудад ашиглаж байгаа камерийн үзүүлэлтүүдийг судалж, цагдаагийн байгууллагын камерийн хяналтын системд холбоход техникийн ямар өргөтгөл хийх шаардлагатай болохыг тодорхойлох. Аж ахуйн нэгжүүдэд санал тавьж хамтран ажиллах зарчмаар Улаанбаатар хотын өнцөг булан бүрт байгаа камеруудыг санд нэгтгэх, улмаар камеруудыг ашиглан дүн шинжилгээ хийх боломж бүрдэнэ.

5.3 Мэдээлэлд дүн шинжилгээ хийх мэргэжилтэн болон, нийт алба хаагчдыг мэдээлэлтэй ажиллах чиглэлээр чадавхижуулах, мэдээллийн урсгал бий болгох, дундын сан бий болгох, програм хангамж нэвтрүүлэх ажлууд анхандаа ихээхэн зардалтай. Тухайлбал: spss зэрэг дүн шинжилгээний программ нь сүлжээнд ажиллах хязгаараасаа хамаарч 4500-80000 америк долларын ханштай байна. Гэвч одоогоор ийм мөнгө цагдаагийн төсөвт байхгүй байна. Хэрэв энэ төрлийн програм хангамжийг нэвтрүүлэн ажилтнуудыг сургаж чадвал цагдаагийн бүх чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж эхэлнэ. Жишээ нь Канад, Австрали, Шинэ Зеланд зэрэг өндөр хөгжилтэй орнууд уг программын тусламжтай энэ мэт олон тооцооллыг хийдэг бөгөөд ингэснээр нийт шалгасан хэргийнхээ хойноос хөөцөлдөхөд цагдаагийн байгууллага хичнээн хэмжээний зардал гаргасан, эргээд төсвөөс хэдий хэмжээний хөрөнгө гаргуулж авах, орон тоогоо нэмэх асуудлаа тавьдаг байна.

5.4 Цагдаа, хууль сахиулах байгууллагын мэдээллийн шинжээчид болон нийт алба хаагчдыг дараах сургалтад хамруулж чадавхжуулах хэрэгцээ шаардлага байна. Үүнд:

- Тактикийн болон стратегийн дүн шинжилгээ хийх, мэдээллийн санд буй мэдээллийг зөв уншиж судалдаг байх, илтгэл, танилцуулгыг оновчтой бэлтгэх;
- ANACAPA буюу хүснэгтэн мэдээлэл үүсгэж дүн шинжилгээ хийдэг байх, шаардлагатай тохиолдолд шүүхэд танилцуулах баримт сэлтийг боловсруулдаг байх;
- Судалгаа, дүн шинжилгээний ажлын зардлын тооцоо, хяналт шинжилгээ, үнэлгээг хийдэг байх;
- Хийсэн ажлаа бусдад амаар болон бичгээр тайлбарлан таниулах, багаар ажиллах, хариуцлагатай байх, бусдад зөвлөгөө дэмжлэг үзүүлэх туршлага суулгах;
- Компьютерын өгөгдлийн сан, Excel, Spss, бусад программыг эзэмшсэн, мэдээллийн сангийн болон сүлжээний хадлалт, хамгаалалт, нууцлал, аюулгүй байдлыг хангах чадвартай байх зэрэг болно.

----ooOoo----

ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ-СТАТИСТИК

Д.Зүмбэрэллхам
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн
дарга, хууль зүйн ухааны доктор, профессор
М.Цэдэвсүрэн
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн бүртгэл

Хууль тогтоомжийн зохицуулалтыг судлан үзэхэд гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн бүртгэл нь "тоо бүртгэл", "дүн бүртгэл" зэрэг утгаар гол төлөв тусгагдсан байна. Эдгээр бүртгэл нь хүн ам, эдийн засаг, нийгмийн зэрэг олон чиглэл, салбараар хөтлөгдөж ирсний нэг төрөл нь эрх зүйн зөрчил тэр дундаа гэмт хэрэг, захиргааны зөрчил юм.

Гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн "Бүртгэл"-ийн талаар хууль тогтоомжид тусгагдсан байдлыг тоймлон үзвэл Тагнуул, Замын цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Цагдаагийн байгууллагаас олон төрлийн бүртгэлийг хөтөлж байна.

(- Гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэл;
- Гэмт хэргийн тоо бүртгэл;
- Гэр бүлийн хүчирхийллийн талаарх тоо бүртгэл;
- Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн тоо бүртгэл;
- Зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо бүртгэл;
- Биеэ үнэлсэн, эсхүл бусдын биеийг үнэлүүлсэн *зөрчилд захиргааны шийтгэл* хүлээсэн этгээдийн талаарх;
- гэмт хэрэг, *зөрчил*, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл
- замын хөдөлгөөний *дүрэм зөрчсөн* жолооч болон *зөрчлийн* тоо бүртгэл
- гэмт хэрэгт сэжиглэгдсэн, эрүүгийн хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан хүний талаар;
- ял шийтгүүлсэн хүний талаар;
- эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний талаар;
- эрүүгийн хэрэг, үйлдэл холбогдол нь хэрэгсэхгүй болж цагаатгагдсан хүний талаар;
- эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялыг хойшлуулсан хүний талаар;
- хүүхдээ хүмүүжүүлэх үүргээ биелүүлэхгүй, мөн хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлж байгаа, хүүхэдтэй хэрцгий харьцаж байгаа этгээдийн талаар;
- өршөөл, уучлалд хамрагдсан хүний талаар;
- гэмт хэрэгт хохирсон хүний талаар;
- *зөрчил* үйлдсэн этгээдийн талаар;
- эрэн сурвалжлагдаж байгаа хүний талаар;
- гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналтад байгаа хүний талаар;
- цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын тоо бүртгэл;
- эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хуулийн этгээдийн талаар;
- шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх нэгдсэн тоо бүртгэл;
-эрүүгийн гэмт хэргийн дүн бүртгэлийн нэгдсэн тогтолцоо.)

"Тоо бүртгэл", "Дүн бүртгэл" гэсэн утгаар дээрх бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, тогтолцоо байгаагаас Цагдаагийн байгууллагад хамгийн олон төрөл[36]-ийн бүртгэл хөтлөгдөхөөр хууль тогтоомжид заасан байна.

Дээр дурдсан хууль тогтоомжид нэрлэн заасан бүртгэлийн төрлөөс гадна зарим төрлийн бүртгэл хөтлөх харилцааг тусгай хууль, эрх зүйн актаар зохицуулдаг. Тухайлбал, Шүүхийн, Хуулийн этгээдийн, Эд хөрөнгийн эрхийн улсын, Иргэний улсын, Аюултай хаягдлын хадгалалт, устгалын, Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэлийг тус тус нэрлэж болно.

Гэмт хэргийн болон захиргааны зөрчлийн статистик

Статистик гэдэг нь латины "статус" эд юмсын тодорхой хэмжээ гэсэн үгнээс гаралтай бөгөөд энэхүү нэр томьёог анх 1746 онд Немцийн эрдэмтэн Готфрид Ахенваль шинжлэх ухаанд оруулжээ.[37]

Аливаа мэдээллийн шинж чанарыг шалгаад үндсэн мэдээллээс тодорхой төрлийг сонгон авч түүний шинж чанарт тулгуурлан үндсэн мэдээллийг тогтоох талаар аргачилж буй онол-арга зүйн хэлбэржсэн байдлыг Статистик гэнэ.[38]

Хэлбэржилт нь 2 үндсэн төрөлтэй. Нэгдүгээрт, байгаа мэдээллийг цуглуулж хүснэгт, графикт оруулж мэдээллийн дундаж болон чиг хандлагыг тодорхойлсноор тухайн мэдээллийн онцлогийг гаргаж авах буюу мэдээллийг нэг бүрчлэн бичиж тэмдэглэх төрөл. Хоёрдугаарт, үндсэн мэдээллээс түүвэр хийх байдлаар үзүүлэлтийг сонгох ба сонгосон түүвэр мэдээлэлд тулгуурлан үндсэн мэдээллийн онцлог, чиг хандлагыг тодорхойлох төрөл. Энэ төрөл нь 1920-иод оны үеэс үүссэн гэж эх сурвалжид тэмдэглэгдсэн байх бөгөөд энэ төрөлд түүвэр мэдээлэл эргэлзээгүй байх нь хамгийн чухал.

---

[36] Хавсралт 1-ээс харна уу.
[37] Монгол Улсын бүртгэл, статистикийн үүсэл, хөгжил УБ., 2014. 9 дэх тал. Боловсруулж эмхэтгэсэн Ц.Бардах, Х.Бажийхүү
[38] Albert2005.co.jp

Нэг дэх төрөл буюу "нэлэнхүйн статистик"-ийн давуу тал нь энэ тохиолдолд нэг бүрчлэн тэмдэглэсэн мэдээлэл өгөгдөх ба алдаа гарах магадлал бага боловч сул талууд байсан учраас эдгээрийг нөхөх зорилгоор 2 дахь төрөл буюу "түүвэр статистик" гарч ирсэн. 2 дахь төрлийн давуу тал нь цаг хугацаа, зардал, хүний нөөц зэргийг хэмнэдэг. Тэгэхдээ анхаарах хэд хэдэн зүйл байдаг. Тухайлбал, түүврийг оновчтой сонгох, үнэн эсэхийг магадлах, зорилгод нийцсэн байх зэрэг болно.

Статистикийн гол онцлог нь нийгмийн аливаа үзэгдэл, үйл явцыг тоогоор илэрхийлдэгт оршдог ба орчин үеийн ШУ-ны зарчимд тулгуурласан анхны "хүн амын тооллого" нь 1896 онд Бельги улсын статистикч А.Кетлийн удирдлага дор явагдаж байжээ. Статистик нь тоог тоолох, дунджийг гаргах, онцлог болон чиг хандлагыг тодорхойлох зэрэг олон тооны бүрдэл хэсэгтэй байж болно.

Манай улсад статистикийн буюу тоо бүртгэл хөтлөх үйл ажиллагаа хүн ам, мал, эд хөрөнгийн гэсэн төрөл хэлбэрт тулгуурлан хөгжиж ирсэн нь статистикийн түүхэн хөгжлийн талаарх эх сурвалжуудаас харагддаг.

Статистикийн буюу тоо бүртгэлийн байгууллагын албан ёсны үүсэл нь 1924 онд Дотоод хэргийн яаманд тоо бүртгэлийн бие даасан хэлтэс байгуулагдсанаас үүсэлтэй бөгөөд 1927 оны Шүүх явдлын яамны шинэчлэн тогтоосон дүрэмд "... мөнхүү цааз хууль зэргийг шинэчлэн зохиох, зааварлах, тайлбарлах, өөрчлөх устгах тухай саналыг гаргаж зохих газарт мэдүүлэн батлуулж гүйцэтгэх **иргэний ба эрүүгийн хэрэг халдагсдын тоо бүртгэх** ..." гэж заасан байгаагаас харахад иргэний хэргийн хариуцагчийн мөн эрүүгийн хэрэгт холбогдогчийн албан ёсны тоо бүртгэл энэ үеэс эхлэлтэй байна.

Статистикийн тухай хууль анх 1994 онд түүний дараа 1997 онд тус тус батлагдсан байдаг. Хуульд зааснаар албан ёсны статистик нь "Макро эдийн засгийн, Хүн ам, нийгмийн, Үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн, Шүүхийн, Хүрээлэн байгаа орчны статистик" гэсэн үндсэн чиглэл тэдгээрт хамаарах үзүүлэлтээр гарч байхаар хуульчлагдсан.

Түүнчлэн статистик мэдээлэл нь 1997 оны Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө албан ёсны статистик мэдээлэлд тулгуурлан гарч байсан бол шинэчилсэн найруулгаар "захиргааны статистик" мэдээлэл гэсэн төрлийг нэмж статистик мэдээллийн төрөл, агуулгыг өргөжүүлсэн байна.

УИХ-аас 2006 онд "Албан ёсны статистикийг хөгжүүлэх хөтөлбөр 2006-2010", 2011 онд "Статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2011-2015"-ийг тус тус батлсан бөгөөд 2011 онд батлагдсан хөтөлбөрт "Статистикийн тогтолцоог бэхжүүлэх, Статистикийн аргачлал, ангилал, шинжилгээ, судалгааг төгөлдөржүүлэх, Салбарын статистикийг боловсронгуй болгох, Үндэсний тооцооны системийг нэвтрүүлэх, Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, Гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, Статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх"[39] гэсэн дэд зорилтууд тусгагдаж байжээ.

Цаашид статистикийн салбарт баримтлах чиг хандлагын талаар судлан үзэхэд "Монгол Улсын статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016-2020"-ийн төсөл[40]-ийг боловсруулсан байна. Энэхүү төсөлд "Үндэсний статистикийн системийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тогтолцоог бэхжүүлэх, Статистикийн тогтвортой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн статистикийн дэд бүтцийг хөгжүүлэх, Статистикийн мэдээллийн менежментийг сайжруулах, Мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, Статистикийн чадавхыг бэхжүүлэх, Статистикийн үйл ажиллагааг боловсронгуй болгох" гэсэн зорилтууд тусгагджээ. Мөн УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоолоор Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлагдсан бөгөөд Засгийн газраас Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг санаачлан боловсруулж, 2018 онд УИХ-д өргөн мэдүүлэхээр тусгагдсан байна.

Монгол Улс дахь бүртгэгдсэн гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн нөхцөл байдал

Статистикийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар статистик мэдээлэл нь **албан ёсны** болон **захиргааны** гэсэн хэлбэртэй байх бөгөөд мөн дээр дурдсан 5 үндсэн үзүүлэлтээр хуульчлагдсан байна. Үүнээс **Шүүхийн статистик** үзүүлэлтээр "Эрүүгийн хэргийн тоо, төрөл, Шүүхээр шийтгүүлэгчдийн тоо, нас, хүйсийн ялгаа, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, Дампуурсан аж ахуйн нэгж, Захиргааны болон иргэний хэргийн үзүүлэлт" гэсэн 5 үзүүлэлт тусгагдсан байдаг. Харин хуульд захиргааны зөрчилтэй холбоотой үзүүлэлт хуульчлагдаагүй байна.

Монгол Улсын үндэсний статистикийн хорооноос жил бүр Монгол Улсын статистикийн эмхтгэлийг эрхлэн гардаг бөгөөд энэхүү эмхтгэлд дараах төрлийн үзүүлэлт "**гэмт хэрэг**" гэсэн бүлэг үзүүлэлтэд тусгагдсан байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

д/д	Статистикийн эмхтгэл[41]д	Хуульд
1	Бүртгэгдсэн гэмт хэрэг */гэмт хэргийн ангилал, төрөл, бүс аймаг нийслэлээр, гэмт хэргийн зүйл ангиар/*	Хуульд энэ агуулгаараа тусгагдаагүй. Эрүүгийн хэргийн тоо, төрөл гэдэг нэршлээр хуульчлагдсан.
2	18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг	Хуульд нэрлэн заагаагүй боловч ҮСХ-ноос энэ үзүүлэлтээр гаргадаг нь хуульд харшлахгүй.

[39] А.Дэмбэрэл. Статистикийн салбарын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг. Сургалтад зориулсан материал.
[40] Монгол Улсын Их хурал Цахим хэлэлцүүлэг. http://forum.parliament.mn/projects/78
[41] Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг статистикийн эмхтгэлийн 2016 оны дугаар хараахан гараагүй бөгөөд 2015 оны дугаарыг судлан үзэхэд "*гэмт хэрэг*" гэсэн үзүүлэлтээр 10 төрлийн үзүүлэлтийг багтаан нийтэлсэн байна.

	/бүс, аймаг, нийслэлээр/	
3	Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчид */бүс, аймаг, нийслэлээр/*	Хуульд нэрлэн заагаагүй боловч ҮСХ-ноос энэ үзүүлэлтээр гаргадаг нь хуульд харшлаагүй.
4	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт */хохирогч иргэд, эмэгтэйчүүд, нийгмийн байдал, насны бүлгээр/*	Хуульд заасан.
5	Шүүхээр ял шийтгүүлсэн хүн */бүс, аймаг, нийслэлээр, эмэгтэйчүүд, боловсролын түвшин, насны бүлгээр/*	Хуульд заасан. Шүүхээр шийтгүүлэгчдийн тоо, нас, хүйсийн ялгаа гэдэг нэршлээр хуульчлагдсан.
6	Шүүхээр шийдвэрлүүлсэн **хөдөлмөрийн маргаан** */бүс, аймаг, нийслэлээр, ажлаас буруу шилжүүлсэн, ажлаас үндэслэлгүй халагдсан, цалин хөлсний маргаан/*	Хүн ам, нийгмийн статистикийн үзүүлэлт болж хуульчлагдсан. *Захиргааны болон иргэний хэргийн үзүүлэлт хуульчлагдсан.боловч эмхтгэлд нийтлэгддэггүй.*
7	Шүүхээр шийдвэрлүүлсэн дампуурсан аж ахуйн нэгж */бүс, аймаг, нийслэлээр/*	Хуульд заасан. Тэгэхдээ "дампуурсан аж ахуйн нэгж" гэсэн өргөн агуулгаар хуульчилсан.
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн нөхөн төлүүлэлт */эрүү, иргэн, захиргаа, бусад хэргийн/*	Хуульд нэрлэн заагаагүй боловч ҮСХ-ноос энэ үзүүлэлтээр гаргадаг нь хуульд харшлахгүй.
9	Хорихоор өөр төрлийн ял */торгох, эрх хасах, албадан ажил хийлгэх, эд хөрөнгө хураах/*	
10	Авлигын хэргийн шийдвэрлэлт */бүгд, мөрдөн байцаалт явуулсан, мөрдөн байцаалтын үндсэн хугацаанд шийдвэрлэсэн/*	

Статистикийн эмхтгэлд нийтлэгдсэн дээрх хүснэгтэд заасан үзүүлэлтийг Статистикийн тухай хуульд заасан үзүүлэлттэй харьцуулж харвал дараах логик болоод хууль тогтоомжтойгоо уялдахгүй байгаа зөрчил ажиглагдаж байна.

- Хуулийн 6.4.а-д "Эрүүгийн хэргийн тоо, төрөл" гэсэн үзүүлэлт Шүүхийн статистикийн үзүүлэлт болж хуульчлагдсан. Гэтэл статистикийн эмхтгэлд "Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, төрөл"-ийн талаарх үзүүлэлтүүд нийтлэгдэж, харин "эрүүгийн хэргийн тоо төрөл" гэсэн үзүүлэлт нийтлэгдэхгүй байна;
- "Гэмт хэрэг" гэсэн бүлэг үзүүлэлтэд "Шүүхээр шийдвэрлүүлсэн **хөдөлмөрийн маргаан**", **"дампуурсан аж ахуйн нэгж"** буюу иргэний хэрэг, маргаанд хамаарах үзүүлэлт багтсан байна;
- Хуулийн 6.4.д-д "Захиргааны болон иргэний хэргийн үзүүлэлт" гэж хуульчилсан боловч энэ үзүүлэлтээр нийтэлсэн мэдээлэл статистикийн эмхтгэлд бараг нийтлэгдэхгүй байна. ҮСХ-ны зөвшөөрснөөр ШЕЗ-өөс 2008 онд анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн эрүүгийн, иргэний болон захиргааны хэргийн мэдээллийн маягтууд тэдгээрт хамаарах үзүүлэлтүүдийг баталсан бөгөөд хагас, бүтэн жилээр энэхүү мэдээлэл шүүхээс гардаг;
- Хуулийн 6.4.б-д "Шүүхээр шийтгүүлэгчдийн тоо" гэж хуульчилсан байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 45.2-т "эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тогтоосон ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээгээр хүлээлгэнэ" гэж заасан. Үүнээс харвал ялаас гадна "эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ" шүүхээр шийтгүүлсэн гэх ойлголтод хамаарч байна;

Цагдаагийн ерөнхий газраас "Монгол Улс дахь бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал"-ыг харуулсан цогц мэдээллийг цаасаар болон цахимаар нийтэлж, олон нийтийн хүртээл болгож байгаа.

Энэхүү мэдээллээр Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, Аймаг, дүүргүүдийн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, Зарим төрлийн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, Гэмт хэргийн онцлог, шалтгаан нөхцөл, Гэмт хэрэгт холбогдсон хүний онцлог, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын санал зөвлөмж, Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик үзүүлэлтүүд гэсэн цогц мэдээллийг багтаадгаараа онцлогтой.

Энэ мэдээллээс статистикийн эмхтгэлд бүртгэгдсэн гэмт хэрэгтэй холбоотой хэд хэдэн мэдээлэл нийтлэгдэж байна. Харин захиргааны зөрчлийн талаарх мэдээлэл огт нийтлэгдэхгүй явсаар иржээ.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн үзүүлэлтийн талаар Статистикийн тухай хуульд зохицуулалт байхгүй явсаар ирсэн нь энэ төрлийн статистик үзүүлэлт боловсронгуй болох, судалгааны эргэлтэд орох, мэдээлэл хүсэгчийн мэдээлэл авах эрх зэрэгт сөрөг нөлөө үзүүлж байгааг цаашид анхаарах хэрэгтэй.

Монгол Улс дахь захиргааны зөрчлийн нөхцөл байдал ямар байгаа талаар судлан үзэхэд 2016 онд улсын хэмжээ[42]-нд **нэг сая гучин найман мянга тавь /1.038050/-н** захиргааны зөрчил бүртгэгдсэн байна. Өөрөөр хэлбэл манай улсын 3 хүн тутмын 1 нь захиргааны зөрчил үйлдэж байгаа дүр зураг гарч байна.

[42] Цагдаагийн ерөнхий газар. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ., 2016. 231 дэх тал

Гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн бүртгэл-статистикийн уялдаа

Аливаа бүртгэл, дансанд орц болон гарц гэж байдаг. Шүүх болон хууль сахиулах үйл ажиллагаанд хамаарах бүртгэлд ч мөн энэ бүрдэл байгаагаас гадна эдгээр байгууллагын эрхлэн хариуцаж буй чиг үүрэгтэй холбоотойгоор үйл ажиллагааны уялдаа холбоо, мэдээлэл солилцоо болон түүний үнэн, зөв байдал зэрэг голлох асуудлууд нь энэ салбарыг хөгжүүлэх, бодлогыг тодорхойлох хүчин зүйлс болох боломжтой.

Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх асуудлыг сүүлийн үед эрх зүйн актуудад хуульчилж, энэ чиглэлээр томоохон ажлууд эрчимтэй хийгдэж эхэлсэн. Тухайлбал, цагдаа, прокурор, шүүх /*эрүү, иргэн, захиргааны хэргийн төрлөөр бие даасан нэгдсэн систем мөн шүүхийн цахим сан ажилладаг*/, ШШГ байгууллагын цахим мэдээллийн нэгдсэн систем, мөн Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээг зохион байгуулах ажил зэргийг дурдаж болох юм. Түүнчлэн ҮСХ, Шүүхийн шинжилгээ, шүүх, цагдаа зэрэг байгууллагаас эрхлэн гаргаж буй тайлан, эмхтгэл, мэдээллүүдийн төрөл, цар хүрээ, давтамж нэмэгдсэн.

Дээр дурдсанаар мэдээллийн сан, нэгдсэн тогтолцоо бүрдэх ажил эрчимтэй хийгдэж байгаатай зэрэгцүүлээд тухайн мэдээллийн уялдаа, үнэн, зөв байдлыг хангах асуудлыг орхигдуулахгүй хамтад нь хэрэгжүүлэх нь статистикийн олон улсын зарчим[43]-ыг хангах, практикт үүсээд буй тулгамдсан асуудал[44]-ыг шийдвэрлэхэд ач холбогдолтой.

Мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх ажилд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байдаг. Үүнд:

1. Мэдээлэгчдийг нэгдсэн арга зүйгээр хангах /мэдээлэгч бүр тухайн үзүүлэлтийн тоог гаргах талаар нэгдсэн ойлголттой байх/, хүний нөөцийг бэхжүүлэх;
2. Мэдээллийн бүрдлийг хангах[45]
3. Мэдээллийн эх сурвалжийг тулгах, нягтлах[46]
4. Мэдээллийг холбох, хөрвүүлэх, хөгжүүлэх /цахим мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх/
5. Зөвхөн бүртгэгдсэн мэдээллээс гадна тэдгээрийг боловсруулж хэрэглээнд бэлтгэх, статистик мэдээлэлд шилжүүлэх, дүн шинжилгээ хийх зэрэг болно.

Эдгээр шаардлагыг хангасан мэдээлэл нь хоорондоо уялдаатай, үнэн, зөв, ашиглахад хялбар дөхөм байж, мэдээллийн нэгдсэн тогтолцоо болж чадах юм.

Эрүүгийн хэрэг /гэмт хэрэг/ болон түүнд хамаарах үзүүлэлт нь бусад хэрэгтэй харьцуулахад шүүхээс өмнөх шатанд хэрэг нь үүсдэг мөн түүнчлэн үзүүлэлт нь хүн, хэрэг гэсэн зэрэгцсэн 2 утгаар гардаг, мөн эрх зүйн зөрчил дотроо хор уршиг, үр дагавраар хамгийн хүнд тул энэ төрлийн мэдээлэл нийгэмд түлхүү нийтлэгддэг бас эрэлт хэрэгцээ ч их байдаг тал ажиглагддаг.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл[47]-ээс харахад орц буюу "бүртгэгдсэн нийт зөрчлийн тоо" байна. Харин шийдвэрлэгдсэн нийт зөрчлийн тоо, үлдэгдлийн тоо байхгүй, шийтгэгдсэн зөрчил гаргагчийн тоо түүний задаргаа болох үзүүлэлтүүд гарч байна. Эрүүгийн хэргийн шүүхийн шүүн таслах ажлын тайлан мэдээгээр гардаг "Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн тайлан" гэсэн мэдээллийн үзүүлэлт түүнийг нөхөх зааврааас харахад "зөрчил гаргагчаар" буюу хүний тоогоор илэрхийлэгдсэн үзүүлэлт байна. Харин энэхүү мэдээллийг Тайланд бичиж дүгнэхдээ зөрчлийн тоо, түүний шийдвэрлэлт гэж дүгнэсэн[48] байдал ажиглагдаж байна. ЦЕГ болоод ШЕЗ-өөс гаргаж буй захиргааны зөрчлийн үзүүлэлтээс гадна иргэн болон захиргааны хэргийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн тохиолдолд шүүгч шийтгэвэр гарган захиргааны хариуцлага ногдуулах цөөн тохиолдлууд гардаг.

Дээрхээс харахад захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаарх мэдээллийн бүрдэл хангагдах ажил гүйцэд хийгдэхгүй байгаа гэсэн дүр зураг харагдаж байна. Мөн Бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдлын талаарх мэдээллийн балансын задаргаа, нөхөх зааврыг хамт нийтлэхгүй байгаа нь энэ төрлийн мэдээллийг хэрэглэгчид ашиглахад хүндрэлтэй байдал үүсгэж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

Гэмт хэрэг, эрүүгийн хэргээс гадна иргэн болон захиргааны хэргийн бүртгэл-статистикийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага бий. Тухайлбал, ШЕЗ-өөс баталсан иргэний хэргийн мэдээллийн маягт ШС-2-ийн 11-р мөр "шийдвэрлэсэн хэрэг"-т хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг, 115 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэрэг, 117 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэрэг тус тус хамаардаг. Энд 117 дугаар зүйл нь "Хэргийг хэрэгсэхгүй болгох" гэсэн агуулгатай. Гэтэл захиргааны хэргийн маягт ШС-3-ийн 14-р мөр "шийдвэрлэсэн бүх хэрэг"-т "хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай" үзүүлэлт хамаарахгүй байгаа.

Эндээс харахад яг нэг ижил үзүүлэлт нь "Шийдвэрлэсэн бүх хэрэг" гэх үзүүлэлтийн бүрдлийг нэг бол хангах, үгүй бол хангахгүй байх гэсэн ялгамжтай байдлаар үзүүлэлт болон батлагдсан байна. Гэтэл шийдвэрлэсэн хэрэг гэдэг бол шүүхийн статистикийн хамгийн чухал үзүүлэлтийн нэг бөгөөд үүний цаанаа шүүхэд ажиллаж байгаа хүмүүсийн хийсэн ажил, зарцуулсан хөдөлмөр үнэлэгдэж байдаг. Иргэний хэрэгт энэ үзүүлэлтийг шийдвэрлэсэн хэрэгт хамааруулж байгаа бол үүнтэй ижил захиргааны хэрэгт мөн хамааруулж батлах нь ойлголтын зөрүүг арилгахаас гадна хийж гүйцэтгэсэн ажлыг нэг стандартаар үнэлэх талаар ач холбогдолтой.

---

[43] НҮБ-аас шалгуур болгосон 10 зарчмын нэг нь статистик "Үнэн, бодитой байх" зарчим болно.

[44] Сүүлийн үед зохион байгуулагдсан хурал, семинар, хэлэлцүүлэг бүр дээр "үйл ажиллагааг уялдуудах" асуудал хөндөгдөж байгаа. Мөн ҮСХ болон цагдаагийн багууллага 2014 онд хамтран хийсэн "Гэмт хэргийн хохирогчийн өнөөгийн бадалд хийсэн баримтын судалгаа"-нд мэдээлэл маш их зөрүүтэй байгаа талаар тодорхой дурдсан байдаг.

[45] Хавсралт 2-оос харна уу.

[46] Хавсралт 2-оос харна уу.

[47] Энэ мэлээлэл нь ЦЕГ-аас мөн ШЕЗ-өөс гарч байна.

[48] Монгол Улсын шүүхийн тайлан /2013 он/. 121 дэх тал

Мөн захиргааны хэргийн нэлээд хувь нь хэд хэдэн шаардлагыг багтаан шийдвэрлэгддэг онцлогоосоо шалтгаалан шаардлага тус бүрийг шийдвэрлэсэн хууль, маргааны төрөл харилцан адилгүй тоологдохоор гардаг. Гэтэл практик дээр ШС-3 маягтын дагуу захиргааны хэргийн үзүүлэлтийг гаргахад хэдэн шаардлага байгаагаас үл хамааран нэг хэрэг гэж үзэн түүний шаардлагуудыг шийдвэрлэсэн хууль, маргааны төрлийг аль нэгээр нь сонгож мэдээллийг гарган, ҮСХ-д хүргүүлж байгаа.

Санал

- Статистикийн тухай хуульд заасан албан ёсны статистик үзүүлэлтийн ангилал, төрлийг боловсронгуй болгох, ялангуяа шүүх болон хууль сахиулах үйл ажиллагааны статистикийг зөвхөн "шүүхийн статистик"-т багтаан хуульчилж байгааг өөрчлөх;
- "Шүүхийн статистик"-ийн үзүүлэлтийг "гэмт хэрэг" гэсэн бүлэг үзүүлэлтэд хамааруулан статистикийн эмхтгэлд нийтэлж байгааг өөрчлөх;
- Захиргааны зөрчлийн холбогдох үзүүлэлтийг Статистикийн тухай хуульд үзүүлэлт болгон хуульчлах, статистикийн тайланд нийтэлж байх;
- Статистикийн тухай хуулийн 6.4.а, 6.4.б, 6.4.г дэх хэсгүүдийн агуулгыг бүрэн илэрхийлэх үзүүлэлтийг нийтлэх эсхүл эдгээр хэсгүүдийг эмхтгэлд нийтлэгдэж буй утгатай ижил болгон өөрчлөх;
- Иргэн болон захиргааны хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн тохиолдлууд нь ЦЕГ-аас гаргаж байгаа "Улсын хэмжээнд бүртгэгдсэн захиргааны бүртгэл, түүний шийдвэрлэлт" гэсэн мэдээлэлд тоологдохгүй байгааг анхаарах;
- Мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхдээ мэдээллийн уялдаа, үнэн, зөв байдлыг хангах асуудлыг орхигдуулахгүй хамтад нь хэрэгжүүлэх;
- Бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдлын талаарх мэдээлэлд түүний балансын задаргаа, нөхөх зааврыг хамт нийтлэх;
- Шүүх болон хууль сахиулах үйл ажиллагааны тоо бүртгэлд иж бүрэн боловсруулалт хийж тэдгээрийг мөн чанараар нь статистик мэдээлэлд шилжүүлэх;
- Зөвхөн гэмт хэргээр хязгаарлахгүй иргэн болон захиргааны хэргийн статистикийг боловсронгуй болгох тус тус шаардлагатай байна.

Хавсралт 1

Гэмт хэрэг, захиргааны зөрчлийг бүртгэх талаар хууль тогтоомжид тусгагдсан зохицуулалтын түүвэр жагсаалт

д/д	Хууль тогтоомжийн нэр	Зүйл, заалт
		Хууль
1	Гүйцэтгэх ажлын тухай	9.2.Гүйцэтгэх ажилд хууль тогтоомжийг чанд сахиулах, нуцыг хангуулах зорилгоор **Тагнуулын байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:** 9.2.1.гүйцэтгэх ажлын нэгдсэн **тоо бүртгэл** хөтлөх, энэ талаарх холбогдох журмыг баталж мөрдүүлэх; 9.2.3.гүйцэтгэх байгууллагаас гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл олж авах, улсын хилээр нэвтрүүлэх, ашиглахад зөвшөөрөл олгох, гүйцэтгэх байгууллагын мэдэлд байгаа гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн улсын **нэгдсэн тоо бүртгэл** хөтөлж, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих;
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	**20 дугаар зүйл.Гэмт хэргийн талаарх мэдээлэл цуглуулах, боловсруулах** 20.1.Шүүх, прокурор, цагдаагийн болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, эрх бүхий бусад байгууллага нь гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох зорилгоор гэмт хэргийн мэдээлэл цуглуулах, боловсруулах үйл ажиллагааг дараах байдлаар эрхэлнэ: 20.1.1.гэмт хэргийн **тоо бүртгэл** хөтлөх;
3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай	**11.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:** 11.1.4.гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, **тоо бүртгэл** хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталж, хэрэгжилтэд хяналт тавих;
4	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай	**10.1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь дараах төрөлжсөн сангаас бүрдэнэ:** 10.1.5.зам тээврийн осол, хэрэг, зөрчлийн бүртгэл, мэдээллийн санд зам тээврийн осол, түүнээс учирсан хохирол, Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн **тоо бүртгэл**, мэдээллийг хамруулах; 10.1.6.жолоочийн эрүүл мэнд, зам тээврийн осолд өртсөн хүний бүртгэл, мэдээллийн санд механикжсан тээврийн хэрэгслийн жолоочийн эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт, зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний **тоо бүртгэл**, **мэдээллийг** хамруулах;
5	Зөрчлийн тухай	**11.2 дугаар зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль зөрчих** 1.Хуульд заасан холбогдох зөвшөөрөлгүйгээр газрын кадастрын үйл ажиллагаа явуулсан, эсхүл холбогдох материалд засвар хийсэн; газрын нэгдмэл сангийн **тоо бүртгэл**, эсхүл газрын улсын бүртгэлийг буруу хийсэн; газрын кадастрын мэдээллийн санд дур мэдэн өөрчлөлт хийсэн, эсхүл тэдгээрийг олшруулж бусдад дамжуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. **15.20 дугаар зүйл.Иргэний цэргийн үүрэгтэй холбоотой журам зөрчих** 1.Цэргийн **тоо бүртгэлийн** журам зөрчсөн, эсхүл зарлан дуудсан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, эсхүл дайчилгааны сургууль, цугларалт, цэрэг татлагаас зайлсхийсэн цэргийн үүрэгтэн, цэргийн насны иргэнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. **6.15 дугаар зүйл.Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих** 4.Усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүс тогтоох шаардлагыг зөрчсөн; усны **тоо бүртгэл**, эрэл, хайгуул, судалгааны тайлан, хяналт-шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалтын бүртгэл, хаягдал усны бүртгэлийг хугацаанд нь явуулаагүй, эсхүл тайлан, мэдээг гаргаж өгөөгүй бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6	Садар самуун явдалтай тэмцэх тухай	**12 дугаар зүйл. Тоо бүртгэл** 12.1.Биеэ үнэлсэн, эсхүл бусдын биеийг үнэлүүлсэн зөрчилд захиргааны шийтгэл хүлээсэн этгээдийн талаарх **тоо бүртгэлийг** цагдаагийн байгууллага эрхлэн хөтөлнө. /Энэ зүйлийг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/ *[Энэ хэсгийн "захиргааны" гэснийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн*

		хуулиар хасахаар заасан бөгөөд үүнийг 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/
7	Цагдаагийн албаны тухай	**10.1.Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:** 10.1.10.гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн **тоо бүртгэл** хөтлөх, лавлагаа гаргах; 10.2.Цагдаагийн байгууллага энэ хуулийн 10.1.5, 10.1.6-д заасан ажиллагаа явуулахад шаардлагатай **тоо бүртгэл** хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, тусгай техник, арга хэрэгсэл ашиглах, халхавчийн байгууллага, нууц гүйцэтгэх болон туслагч, туслах ажилтныг ажиллуулна. **13.1.Цагдаагийн байгууллага захиргааны хяналтын чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:** 13.1.3.зам тээврийн осол, түүнээс учирсан хохирол, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолооч болон зөрчлийн **тоо бүртгэл** хөтлөх; **61 дүгээр зүйл. Үйл ажиллагаандаа тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сүлжээ, сан үүсгэж ашиглах** 61.1.Цагдаагийн байгууллага дараах **тоо бүртгэл** хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан үүсгэн үйл ажиллагаандаа ашиглана: 61.1.1.гэмт хэрэгт сэжиглэгдсэн, эрүүгийн хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан хүний талаар; 61.1.2.ял шийтгүүлсэн хүний талаар; 61.1.3.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний талаар; 61.1.4.эрүүгийн хэрэг, үйлдэл холбогдол нь хэрэгсэхгүй болж цагаатгагдсан хүний талаар; 61.1.5.эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялыг хойшлуулсан хүний талаар; 61.1.6.хүүхдээ хүмүүжүүлэх үүргээ биелүүлэхгүй, мөн хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлж байгаа, хүүхэдтэй хэрцгий харьцаж байгаа этгээдийн талаар; 61.1.7.өршөөл, уучлалд хамрагдсан хүний талаар; 61.1.8.гэмт хэрэгт хохирсон хүний талаар; 61.1.9.зөрчил үйлдсэн этгээдийн талаар; 61.1.10.эрэн сурвалжлагдаж байгаа хүний талаар; 61.1.11.тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигчийн болон тээврийн хэрэгслийн татвар, даатгал, оношилгооны талаар; 61.1.12.жолоодох эрхийн үнэмлэх авсан хүний талаар; 61.1.13.гэрээт болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн талаар; 61.1.14.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналтад байгаа хүний талаар; 61.1.15.Галт зэвсгийн тухай хуулийн 12.9-д заасан мэдээллийн сан; 61.1.16.цагдаагийн алба хаагч галт зэвсэг хэрэглэсэн тохиолдлын талаар; 61.1.17.гарын хээ, сум, хонгио, генетикийн мэдээлэл; 61.1.18.хуулийн этгээдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн хэрэгслийн мэдээлэл; 61.1.19.цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын тоо бүртгэл; 61.1.20.эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хуулийн этгээдийн талаар; 61.1.21.бусад.
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай	**7.1.Шийдвэр гүйцэтгэх газар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:** 7.1.3. шүүхийн зарим төрлийн шийдвэрийг бусад байгууллагаас гүйцэтгэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, энэ талаар нэгдсэн **тоо бүртгэл** хөтөлж, хяналт тавих; 7.1.4.шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар улсын хэмжээнд нэгдсэн **тоо бүртгэл** хөтлөх;
МУОУГэрээ		
9	Нэгдсэн үндэстний байгууллагын дүрэм	**73 дугаар зүйл** е) XII, XIII бүлгийн заалтуудад хамаарах нутаг дэвсгэрээс бусад хариуцлага хүлээсэн холбогдох нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгэм, боловсролын салбар дахь нөхцөл байдалд хамаарах **тоо бүртгэлийн** болон бусад техникийн шинж чанартай бөгөөд уг нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, хуулийн дэг ёсонд үл харшлах мэдээ сэлтийг Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээллийн журмаар тогтмол хүргүүлж байхыг ариун үүргээ гэж үзэж байна.
10	Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц	**2 дугаар зүйл** Хяналтад хамрагдах бодис 3. III жагсаалтад орсноос бусад бэлдмэл нь тэдгээрт орсон мансууруулах эмийн адил хяналтын арга хэмжээнд хамрагдах боловч эдгээр мансууруулах эмийн тооцоо, дүн бүртгэлээс ялгаатай тооцоо (19 дүгээр зүйл), дүн бүртгэл (20 дугаар зүйл)-ийн ийм бэлдмэлийн хувьд шаардахгүй бөгөөд 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (c) дэд хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (b) (ii) дэд хэсгийг

		хэрэглэхгүй. 4. III жагсаалтад заасан бэлдмэлүүд нь II жагсаалтад орсон мансууруулах эм агуулсан бэлдмэлийн адил хяналтын арга хэмжээнд хамрагдана. Харин үүнд 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (b) дэд хэсэг болон 3-15 дахь хэсэг, түүнчлэн тэдгээрийг олж авах болон жижиглэн худалдаалахын хувьд 34 дүгээр зүйлийн (b) хэсгийг хэрэглэх хэрэггүй бөгөөд шаардлагатай мэдээллийг иймм бэлдмэл бэлтгэхэд хэрэглэсэн мансууруулах эмийн хэмжээгээр тооцоо (19 дүгээр зүйл) болон дүн бүртгэл
11	Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц	а) Урьд нь хяналтад хамрагдаагүй байсан бөгөөд I жагсаалтад нэмсэн бодисын талаар ийм мэдэгдэл өгсөн тал 7 дугаар зүйлд жагсаасан хяналтын тусгай арга хэмжээг боломжийн хэрээр харгалзан үзэж, тухайн бодистой холбогдуулан: v) 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (a) дэд хэсгийн дагуу дүн бүртгэлийн илтгэлийг Хороонд өгнө; b) Урьд нь хяналтад хамрагдаагүй байсан бөгөөд II жагсаалтад нэмсэн бодисын талаар ийм мэдэгдэл өгсөн тал тухайн бодистой холбогдуулан: v) 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (a), (c), (d) дэд хэсгийн дагуу дүн бүртгэлийн илтгэлийг Хороонд өгнө;
УИХ-ын тогтоол		
12	Хуулийн байгууллагуудын талаар авах арга хэмжээний тухай	1.Хуулийн байгууллагуудын хараат бус ажиллах баталгааг сайжруулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /М.Энхболд/-т даалгасугай: 2/ эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэх, гэмт хэргийн дүн мэдээ, шалтгаан, эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор эрүүгийн гэмт хэргийн дүн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох;

Статистик мэдээлэл цахим хэлбэрээр



СтХ-ийн 6.4-т заасан Эрүүгийн хэргийн тоо, төрөл, Иргэн болон захиргааны хэргийн үзүүлэлт статистикийн мэдээлэл болж цахим хэлбэрээр нийтлэгдэхгүй байна.

ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛСЭН ХӨДӨЛМӨРИЙН МАРГААН, бүс, аймаг, нийслэлээр, жилээр



УЛСЫН ХЭМЖЭЭНД 2016 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Үүнээс: Асран хамгаалах үүргээ урвуулах 118		Үүнээс: Садар самууныг сурталчлах 123		Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах 124		Хүчиндэх 126		Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг 130-144		Өмчлөх эрхийн эсрэг 145-155		Үүнээс: Бусдын зд хөрөнгийг хулгайлах 145	
			Бүх хэрэг		Бүх хэрэг		Бүх хэрэг		Бүх хэрэг		Бүх хэрэг		Бүх хэрэг		Бүх хэрэг	
			2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
		A	38	39	40	41	42	43	44	45	46	47	48	49	50	51
61	Улсын дүн			3	1	0	28	20	279	290	141	116	13445	13336	9169	9065

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Үүнээс: Хувийн өмчийг хулгайлах		Үүнээс: Мал хулгайлах		Үүнээс: Авто тээврийн хэрэгсэл хулгайлах		Үүнээс: Халаасны хулгай		Үүнээс: Галт зэвсэг хулгайлах	
			Бүх хэрэг		Бүх хэрэг		Бүх хэрэг		Бүх хэрэг		Бүх хэрэг	
			2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
		A	52	53	54	55	56	57	58	59	60	61
61	Улсын дүн		6956	7303	1180	805	367	404	621	538	14	12

9065=7303+805+367+404+538+12=9062

2016 ОНД УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШИЙДВЭРЛЭЛТ

№	Төв, орон нутгийн цагдаагийн байгууллага	Захиргааны зөрчлийн шийдвэрлэлт												
		Хоёр. Шийтгэврээр торгосон болон тэзврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан												
		Үүнээс:												
		Цагдаагийн алба хаагч							Шүүгч					
		Зөрчил	Торгосон					Тэзврийн хэрэгсэл жолоодох эрх хассан	Зөрчил	Торгосон				Баривчлсан
			Иргэн	Албан тушаалтан	Байгуулага, аж ахуйн нэгж	Торгуулийн хэмжээ /мян.төг/ 2015	Торгуулийн хэмжээ /мян.төг/ 2016			Иргэн	Албан тушаалтан	Байгуулага, аж ахуйн нэгж	Торгуулийн хэмжээ /мян.төг/	
	A	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26
57	Улсын дүн	103828	72541	107	1163	2701175.0	2759700.6	30017	6583	1199		4	24118	5380

График 1.3 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүн таслах бусад ажиллагааны дүн мэдээ

ЦЕГ-ын мэдээлэлд-6583, ШЕЗ-ийн мэдээлэлд-7003

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН МЭДЭЭЛЭЛ

шатны шүүхүүдийн хэргийн үлдэгдэл 3.5 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан байна. Хугацаа хэтэрсэн үлдэгдэл хэргийн хувьд эрүүгийн хэрэг 96.8 хувиар, захиргааны хэрэг 97 хувиар тус тус өссөн бол иргэний хэрэг 6.6 хувиар буурсан байна.

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны журмаар шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийвэл эрүүгийн хэргийн тогтоол магадлалын 44.8 хувийг, иргэний

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн 30

АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН 2 ДУГААР САРЫН ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЭЛ №2

2017.03.06 Улаанбаатар хот

4. Хугацаа хэтрэлт: Хугацаа хэтэрсэн нийт 785 хэрэг байгаагаас иргэний 682, захиргааны 103 хэрэг байна. Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн нийт хугацаа хэтэрсэн

2 ДУГААР САРЫН НЭГДСЭН ДҮН:

График.6 /Эрүү/

Д/д	Шүүх	Хүлээн авсан	Хянан шийдвэрлэсэн	ХХША-д	Хугацаа хэтэрсэн
1	Нийслэл дэх Эрүүгийн хэрэгийн анхан шатны шүүхүүд	311	218	341	-
2	Орон нутаг дахь эрүүгийн хэрэгийн анхан шатны шүүхүүд	105	402	300	-
3	Нийт	416	620	641	

АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН 3 ДУГААР САРЫН ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЭЛ №3

2017.04.03 Улаанбаатар хот

4. Хугацаа хэтрэлт: Хугацаа хэтэрсэн нийт 851 хэрэг байгаагаас иргэний 743, захиргааны 108 хэрэг байна. Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн нийт хугацаа хэтэрсэн 743 хэргийн 660 хэрэг буюу 88.8%-нь

3 ДУГААР САРЫН НЭГДСЭН ДҮН:

График.6 /Эрүү/

Д/д	Шүүх	Хүлээн авсан	Хянан шийдвэрлэсэн	ХХША-д	Хугацаа хэтэрсэн
1	Нийслэл дэх Эрүүгийн хэрэгийн анхан шатны шүүхүүд	408	274	406	-
2	Орон нутаг дахь эрүүгийн хэрэгийн анхан шатны шүүхүүд	545	492	321	-
3	Нийт	953	766	727	

Үндэсний статистикийн хорооны зөвшөөрснөөр, Хууль зүйн сайдын 2014 оны 12-р сарын 22-ны өдрийн А/241тоот тушаалаар батлав.

Маягт ШГ- 3

ТҮДГЭЛЗҮҮЛСЭН, СЭРГЭЭСЭН ГҮЙЦЭТГЭХ БАРИМТ БИЧГИЙН 2017 ОНЫ 03 САРЫН МЭДЭЭ

Захиргааны хэргийн шийдвэртэй	Захиргааны шүүхийн шийдвэртэй	Гүйцэтгэх хуудас	мян.төг	25	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		Мөнгөн дүн	тоо	26	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Захиргааны шийтгэврээр оногдуулсан торгуулийн	Гүйцэтгэх хуудас	мян.төг	27	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		Мөнгөн дүн	тоо	28	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Дүн	**Гүйцэтгэх хуудас /25+27/**	**мян.төг**	**29**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**
		Мөнгөн дүн /26+28/	**тоо**	**30**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШИЙДВЭРТ ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙГ БАГТААН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ГАРГАЖ БАЙГАА НЬ АГУУЛГЫН ХУВЬД АЛДААТАЙ МЭДЭЭЛЭЛ БОЛНО.

ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК СУДАЛГААНД КЛАСТЕР ШИНЖИЛГЭЭГ АШИГЛАХ НЬ

П.Мөнхтуяа
ХААИС, ЭЗБС, ЭЗСМЗ-ын тэнхимийн эрхлэгч, доктор /Ph.D/
Ш.Баярдулам
ХААИС, ЭЗБС, ЭЗСМЗ-ын тэнхимийн багш, магистр

Хураангуй: Гэмт хэрэг нь аль ч нийгмийн үед байдаг нийгмийн сөрөг үр дагаврын илрэл бөгөөд тодорхой шалтгаанаар нөхцөлдсөн эдийн засаг, улс төр, үзэл суртал, нийгмийн сэтгэл зүй, удирдлага зохион байгуулалт зэрэг бусад нийгмийн үзэгдлүүдтэй харилцан холбоотой зүй тогтолт үзэгдэл юм. Гэмт явдлын эрчимтэй байдал нь түүнийг төрүүлж байдаг нийгмийн сөрөг үзэгдэл, үйл явцын хоорондын зөрчлийн шинж чанартай холбоотой илэрдэг. Гэмт явдал нь нийгэм улс төр, эдийн засгийн бүх хэлбэршлийн үед нийгмийн хөгжлийн, зөрчлийн сөрөг үр дагавар болж оршин ирсэн бодит үзэгдэл юм. Гэмт хэргийн талаарх түгээмэл ажиглалтыг тусгаж байдаг статистикийн тоо мэдээлэл нь их тооны хуульд тулгуурладаг учраас нийгмийн үзэгдэл болох гэмт хэргийн зүй тогтлыг хангалттай зөв тогтоох боломжтой байдаг. Монгол улсын гэмт хэргийн зарим төрлийг Ази номхон далайн бүс нутгийн хөгжингүй болон хөгжиж буй орнууд, хөрш орнуудтай харьцуулан судаллаа. Мөн 1990-2016 оны гэмт хэргийн тоо мэдээн дээр үндэслэн Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 7 дүүргийн гэмт хэрэг гаралтын түвшинг кластер шинжилгээний тусламжтайгаар ангилж, кластер бүрд тохирсон бодлого боловсруулах боломжийн талаар авч үзлээ.

Түлхүүр үг: Гэмт хэргийн түвшин, дисперси, кластер шинжилгээ.

ОРШИЛ

Гэмт явдал нь тодорхой засаг захиргааны нэгжид, нутаг дэвсгэр дээр сар, жилийн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргүүдээс бүрэлддэг. Гэмт хэрэг, гэмт явдал хоёрын хоорондын харилцан үйлчлэл нь бүхэл ба хэсэг, ерөнхий ба тусгайн тухай гүн ухааны категорийн зүй тогтолтой холбогдон тайлбарлагдана. Гэмт явдал нь гэмт хэргийн төрлүүд, гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн онцлог шинжүүдээр ангилагдаж байдаг элементүүдийн нийлбэр, бүхэл системийг бүрдүүлдэг олонлог юм. Гэмт хэрэг бүр нь нийгэмд аюултай эрүүгийн хуулиар хориглогдсон байдгаараа нийтлэг шинжтэй. Тодорхой гэмт хэргүүдийн харилцан нэгдэх шүтэлцээнд нь нэг бүхэл бүтэн юмны салшгүй хэсэг гэсэн байр сууринаас судалсны үр дүнд сая гэмт явдлын зүй тогтлыг бүрэн илрүүлж чадна.

"Криминологи" гэсэн үг нь латин гаралтай **crimeni**, гэмт хэрэг, грек гаралтай **logis** сургаал гэсэн үгнээс бүтсэн байна. Уг шинжлэх ухаан нь гэмт хэрэгтэн бие хүн, гэмт явдал, түүний шалтгаан, нөхцөлийг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах шинжлэх ухаан юм. Монгол Улсын Эрүүгийн хуульд "Хориглосон, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг, эсхүл гэм буруутай үйлдэл эс үйлдэхүйн улмаас хор уршиг учирсан байхыг хуулиар заасан бол гэмт хэрэгт тооцно". Криминологи нь гэмт явдлыг тооны болон чанарын агуулга талаас нь судлан үзнэ. Нийгмийн хөгжлийн өнөөгийн түвшинд гэмт явдалтай тэмцэх асуудлыг улам нарийн болгож, энэ асуудлыг шинжлэх ухааны үндэстэй судлан тогтоож, арилгах арга замыг боловсруулах явдал чухал зорилтын нэг болон тавигдаж байна. Үүнийг сүүлийн жилүүдэд эрх зүй, социологийн шинжлэх ухааны уулзвар дээр өөрийн судлах зүйл, арга, боловсруулах асуудалтайгаа төрөн гарч ирсэн криминологийн шинжлэх ухаан судлаж байна. Бидний мэдэх *"уламжлалт"* гэх тэр арга, хэрэгсэл одоо үр дүнд хүрэх нь багасч, шинжлэх ухааны болон нийгмийн бусад салбаруудын мэдлэг, хамтын ажиллагаа илүү ихээр шаардагдах болсныг сүүлийн үед гараад байгаа онц ноцтой, хүнийг санаатай алах, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, залилангийн гэмт хэргүүд буурахгүй байгаагаас харж болно. Ийм учраас шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа шинжилгээний үр дүн дээр тулгуурлан гарч болзошгүй гэмт хэргийн нөхцөл байдалд тохирсон, нутаг дэвсгэрийн онцлогийг тусгасан ялгаатай бодлого боловсруулах зайлшгүй шаардлага урган гарч байна.

Судалгааны үр дүн

Монгол Улсын гэмт хэргийн гаралт тодорхой цаг хугацаанд хэрхэн өөрчлөгдсөнийг харуулсан динамик эгнээг байгуулж 1990-2016 оны өсөлтийн дундаж хурдыг тооцлоо.

Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, 1990-2016 он

Зураг1.



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Дээрх тооцооллоос харахад гэмт хэргийн гаралт 1990-2000 оны хооронд жилд дунджаар 10 хувиар, 1990-2016 онд жилд дунджаар 4.2 хувиар өссөн байна. 2000-2016 оны хооронд зөвхөн 0,9 хувиар өссөн нь гэмт хэргийн тоо огцом өсөөгүй мэт харагдаж байгаа боловч энэ нь 1995 оноос хойших гэмт хэргийн тоо буурахгүй удаан хугацаанд хадгалагдаж байгаатай холбоотой юм. Монгол Улсын гэмт хэрэг гаралтыг олон улсын түвшинтэй харьцуулъя.

Гэмт хэрэг гаралтын түвшин, 2005-2011 он, %

Зураг2.

Эх үүсвэр: Statistical yearbook for Asia and the Pacific, 2012

Дээрх зургаас харахад Ази Номхон далайн бүс нутгийн хөгжингүй орнууд 2005-2011 онуудад тогтвортой буюу өсөлтийн хурд тогтвортой хадгалагдаж байна. Харин хөгжиж буй орнуудын хувьд гэмт хэрэг гаралтын түвшин 2005 онд 3,7 хувь байсан бол жил бүр буурсаар 2011 онд 2,6 хувь болон буурсан байна.

Шоронд ял эдэлж буй хүмүүсийн тоо, 100000 хүн тутамд,
улсаар, 2012 он

Зураг3.



Эх үүсвэр: Statistical yearbook for Asia and the Pacific, 2012

Дээрх зургаас харахад Монгол Улсын 100000 хүн тутамд ноогдох шоронд ял эдэлж буй хүмүүсийн тоо 290 хүнтэйгээр 3-рт орж байгаа боловч нийт хүн амын тоотойгоо харьцуулахад маш өндөр үзүүлэлт юм. Тухайлбал 2012 онд ОХУ-ын нийт хүн амын тоо 143,2 сая, БНХАУ-ын нийт хүн амын тоо 1,3 тэрбум, Монгол улсын нийт хүн амын тоо 2,9 сая хүнтэй харьцуулахад тэргүүлж байна.

Бүртгэгдсэн дээрмийн гэмт хэргийн тоо, улсаар, 2012 он

Зураг4.



Эх үүсвэр: *Statistical yearbook for Asia and the Pacific, 2012*

Монгол Улсын аймаг, нийслэлийн дүүргүүдийн гэмт хэрэг гаралтын түвшинг кластер шинжилгээний тусламжтайгаар ангилсан бөгөөд дараах үзүүлэлтүүдийг сонгон авлаа.

x1-хүн амын тоо
x2-хүнийг санаатай алах гэмт хэрэг
x3-хулгайн гэмт хэрэг
x4-дээрмийн гэмт хэрэг
x5-мал хулгайлах гэмт хэрэг
x6-танхайрах гэмт хэрэг
x7-согтуугаар үйлдсэн гэмт хэрэг
x8-залилан гэмт хэрэг
x9-хүчингийн гэмт хэрэг
x10-эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг
x11-боловсролгүй иргэд
x12-илрүүлэлтийн хувь

Кластер шинжилгээг хийхдээ n=30 –аас бага үед К- дунджийн аргыг ашиглан кластер шинжилгээ хийдэг. Манай өгөгдлийн хувьд n=27 байгаа учир аймгуудыг сонгон авсан үзүүлэлтүүдээр нэг төрлийн бүлгүүд болгохдоо хүснэгт 1-ийн өгөгдөлд үндэслэн хийсэн. Энэ нь судлаачийн тодорхойлсон бүлгийн тоотой тэнцүү, бие биеэсээ боломжит дээд хэмжээгээрээ харилцан адилгүй шинж чанартай бүлгүүдэд хуваарилдаг арга юм. Юуны өмнө корреляцийн шинжилгээний тусламжтайгаар үзэгдлүүдийн мультколинеарыг арилгахын тулд стандарчлагдсан хэлбэрт оруулна. Объектуудын ойртолтын хэмжээг тодорхойлохын тулд Чебышевын хэмжээс ба евклидын зайг ашиглан дендрограмм зургийг гаргах ба үүний үр дүнд гэмт хэрэг гаралтын түвшинг 3 юм уу 4 кластерт хуваах болохоор харагдаж байна.

"Чебышевийн хэмжээс" аргаар бодсон кластерын дендрограмм

Зураг5.



Шаталсан алгоритмын үндсэн зарчим нь эхлээд хамгийн ойрхон бүлэг элементүүдийн дараалаар, дараа нь бие биеэсээ хол байгааг нь нэгдүүлэн судлана. Дисперсийн шинжилгээний тусламжтайгаар олон хэмжээст бүлэглэлийн тоон характеристикүүдийг тодорхойлж болно. Дисперсийн шинжилгээний үр дүн нь судалж буй шинж тэмдгүүдийн бүлэг хоорондын болон бүлгүүдийн дундаж дисперсийн утгыг тодорхойлохоос гадна F статистик түүний ач холбогдлын түвшинг үнэлэхэд оршино. Бүлэг хоорондын дисперс нь хэдий чинээ их байна бүлгүүдийн дисперс нь төдий чинээ бага байвал кластер сайн болно гэдгийг харуулна. 3 кластер болгон хуваасан шинжилгээний үр дүнг дараах хүснэгтээр үзүүлье.

Дисперсийн шинжилгээний үр дүн (3 кластер)

Хүснэгт1.

Үзүүлэлтүүд	Бүлэг хоорондын дисперс	Бүлгүүдийн дисперс	F статистик	Ач холбогдлын түвшин
Хүн амын тоо	17.97410	8.02590	26.8742	0.000001
Хүнийг санаатай алах	15.07379	10.92621	16.5552	0.000030
Хулгайн гэмт хэрэг	20.30657	5.69343	42.8000	0.000000
Дээрэмдэх гэмт хэрэг	23.44559	2.55441	110.1419	0.000000
Мал хулгайлах гэмт хэрэг	14.23526	11.76474	14.5199	0.000074
Танхайрах гэмт хэрэг	21.22906	4.77094	53.3960	0.000000
Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг	19.92770	6.07230	39.3809	0.000000
Залилан гэмт хэрэг	24.02992	1.97008	146.3692	0.000000

Хүчингийн гэмт хэрэг	16.47619	9.52381	20.7600	0.000006
Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг	23.11921	2.88079	96.3036	0.000000
Боловсролгүй иргэд	**12.51301**	**13.48699**	11.1334	0.000380
Илрүүлэлтийн хувь	**6.76257**	**19.23743**	4.2184	0.026921

Дээрх хүснэгтээс харахад судалж буй объектуудыг 3 кластер болгон хуваах нь хангалтгүй гэдэг нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл боловсролгүй иргэд (x11) ба илрүүлэлтийн хувь (x12) ач холбогдолгүй болгож байна. Учир нь энэ 2 үзүүлэлтийн бүлгүүдийн дисперс нь бүлэг хоорондын дисперсээс их утгатай байна. Иймээс судалж буй объектуудын кластерийг 4 болгож хуваая.

Дисперсийн шинжилгээний үр дүн (4 кластер)

Хүснэгт2.

Үзүүлэлтүүд	Бүлэг хоорондын дисперс	Бүлгүүдийн дисперс	F статистик	Ач холбогдлын түвшин
Хүн амын тоо	18.09842	7.90158	17.56036	0.000004
Хүнийг санаатай алах	16.17192	9.82808	12.61535	0.000044
Хулгайн гэмт хэрэг	20.54566	5.45434	28.87917	0.000000
Дээрэмдэх гэмт хэрэг	23.59315	2.40685	75.15268	0.000000
Мал хулгайлах гэмт хэрэг	12.36498	13.63502	6.95255	0.001697
Танхайрах гэмт хэрэг	21.31103	4.68897	34.84441	0.000000
Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг	20.31582	5.68418	27.40143	0.000000
Залилан гэмт хэрэг	24.07971	1.92029	96.13699	0.000000
Хүчингийн гэмт хэрэг	16.50973	9.49027	13.33730	0.000030
Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг	23.29748	2.70252	66.09159	0.000000
Боловсролгүй иргэд	14.67286	11.32714	9.93118	0.000216
Илрүүлэлтийн хувь	17.04868	8.95132	14.60193	0.000015

Дээрх дисперсийн шинжилгээний үр дүнгээс харахад бүлэг хоорондын дисперс нь бүлгүүдийн дисперсээс их байгаа тул 4 кластер болгон хуваах нь зохимжтой гэдгийг харуулж байна.

Монгол Улсын гэмт хэрэг гаралтын түвшний олон хэмжээст гаралтын үр дүн

Хүснэгт3.

Нэгдүгээр кластер буюу өндөр	Хоёрдугаар кластер буюу дунд	Гуравдугаар кластер буюу дундаас доогуур	Дөрөвдүгээр кластер буюу доогуур
Баянгол Баянзүрх Сүхбаатар Сонгинохайрхан Чингэлтэй	Баян-Өлгий Дорнод Ховд Хөвсгөл Өвөрхангай Орхон Дорноговь Хэнтий Сэлэнгэ Баянхонгор Төв	Завхан Увс Говьсүмбэр Дархан-Уул Хан-Уул Архангай Өмнөговь	Сүхбаатар Дундговь Булган Говь-Алтай

Дээрх хүснэгтээс харахад нэгдүгээр буюу гэмт хэрэг хамгийн өндөр түвшинтэй кластерт Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сүхбаатар Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүд орсон байна. Энэ нь хүн амын төвлөрөлтэй салшгүй холбоотой бөгөөд Оросын академич В.Кудрявцев хүн амын төвлөрөл нь хүмүүсийн гэмт хэрэг үйлдэх сэдэл, гэмт хэрэгтний биеэ авч явах байдалд шууд нөлөөлөхгүй ч, юуны өмнө гэмт зан үйлийн халдварлал, солилцоо явагдах, гэмт хэргийн орчин бүрэлдэх, соёл төлөвших, гэмт үйл ажиллагаа байгууллагажих нөхцөл болж, механик нөлөө үзүүлдэг гэсэн юм.

Гэмт хэрэг хамгийн бага түвшинтэй кластерт Сүхбаатар, Дундговь, Булган, Говь-Алтай аймгууд орсон байна.

Кластер тус бүрийн нормчлогдсон дундаж утга

Зураг 6.



Зураг 6.-с харахад гэмт хэрэг хамгийн өндөр түвшинтэй кластер болох Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сүхбаатар Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдэд малын хулгай бусад кластеруудаас хамгийн бага, гэмт хэрэг хамгийн бага түвшинтэй кластер болох Сүхбаатар, Дундговь, Булган, Говь-Алтай аймагт малын хулгай хамгийн их байгааг харж болно.

Дүгнэлт

1. Монгол Улсын гэмт хэрэг гаралтын тоо 1990-2016 оны хугацаанд буураагүй бөгөөд өсөлтийн дундаж хурд 4.2 хувь, 1990-2000 оны гэмт хэрэг гаралтын өндөр түвшин одоо болтол хадгалагдаж байна.
2. Судалгааны үр дүнд үндэслэн тухайн кластерт гарч буй гэмт хэргийн төрлөөс хамааран урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах боломжтой юм.
3. Гэмт хэргийн хамгийн өндөр түвшинтэй ангилалд Улаанбаатар хотын дүүргүүд орж байгаа нь хүн амын нягтрал, шилжих хөдөлгөөн, ядуурал зэрэг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүдтэй салшгүй холбоотой бөгөөд кластер тус бүрд тохирсон хууль эрх зүйн бодлого, төсөв, бодлогыг явуулах нь зүйтэй гэдгийг харуулж байна.
4. Судалгааны дүн зөвхөн тоон үр дүнг төдийгүй Монгол Улсад мөрдөж буй хууль эрхзүйн орчны талаар баримталж буй бодлогыг өөрчлөх, сайжруулах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Эрүүгийн хууль
2. Многомерный статистический анализ в экономических задачах: компьютерное моделирование в SPSS: учеб. пособ. / под ред. И.В. Орловой. – М.: Вузовский учебник, 2009. – 310 с.
3. Методология статистических исследований в бизнесе и социальной сфере: сб. науч. трудов / Минобрнауки РФ, Московский государственный университет экономики, статистики и информатики (МЭСИ), кафедра теории статистики и прогнозирования; [редкол. В.Г. Минашкин. (гл.ред.), Н.А. Садовникова, Р.А. Шмойлова]. – М.: МЭСИ, 2010. – 159 с.: ил.
4. Мхитарян В.С. Математико-статистический анализ социально-экономических процессов: межвузовский сб. науч. трудов / В.С. Мхитарян; Федеральное агентство по образованию, МЭСИ. – Вып. 8 / [редкол.: В.С. Мхитарян (гл. ред.) и др.]. – М., 2011. – 235 с.: ил.
5. Gujirati D.N. Basic Econometrics. – 3nd ed. – McGraw-hill,1992. – 466 p.

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД БҮС НУТГИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ХАРГАЛЗАХ НЬ

Д.Сэржмядаг
Доктор (Ph.D), дэд хурандаа

Хураангуй: Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад гамшгийн эрсдэлийн асуудал онцгой чухал тул манай оронд тодорхой хэмжээнд нөлөөллөө үзүүлээд эхэлсэн уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас улам бүр нэмэгдэж буй Зүүн хойд Азийн салбар бүс нутаг дахь гамшгийн эрсдэлийн төлөв байдлыг авч үзсэн бүс нутгийн хамтын ажиллагаа, хамтарсан судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: Үндэсний аюулгүй байдал, Зүүн хойд Ази, гамшиг, гамшгийн эрсдэл

Оршил

Уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас дэлхий дахинд тохиолдох гамшгийн тоо улам бүр өсч байна.

Ази, Номхон далайн бүс нутаг, түүний дотор Зүүн хойд Азийн салбар бүс нутаг нь дэлхийн гамшигт хамгийн өртөмтгий бүс нутагт хамаарна. Тус салбар бүс нутагт Хятадын эх газар, Тайвань, Өмнөд Солонгос, Хойд Солонгос, Япон, Оросын холбооны улс, Монгол улс орж байгаа бөгөөд газар нутгийн талбайн хэмжээ 20 сая 200 мянган км^2, үүнээс хуурай эх газар – 15 сая 600 мянган км^2 (75%), усан гадаргуй – 5 сая 200 мянган км^2 (25%). Газар зүйн төв нь БНХАУ-ын Хар мөрөн\ Хэйлунзянь\ мужийн Муданзян хотод байгаа бөгөөд түүнээс 1600 км-ийн радиус дотор Бээжин, Сөүл, Пхеньян, Токио, Улаанбаатар, Тяньжин болон Шанхай, Пусан, Нарита, Осака, Владивосток, Хабаровск зэрэг хотууд багтаж байгаа бөгөөд энэ бүсэд 1,8 тэрбум гаруй хүн ам амьдарч байна[49].

Азийн бусад бүс нутагтай харьцуулахад Зүүн Хойд Азийн улс орнууд гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүгийн боломж нөөц харьцангуй сайн. Учир нь тус бүс нутагт дэлхийд тэргүүлэх хүчирхэг эдийн засагтай БНХАУ, Япон, БНСУ байдаг бөгөөд эдгээр улсуудад Ази номхон далайн нийт баялгийн ойролцоогоор 60% хамаарна[50].

Зүүн хойд Азийн улс орнууд нь эдийн засгийн хувьд хүчирхэгжиж байгаа хэдий ч болзошгүй гамшгийн аюул, түүнд өртөх эмзэг байдлаа арилгаж, гамшгийн эрсдэлээ мэдэгдэхүйц бууруулж чадахгүй юм.

Дэлхий дээр болж байгаа бүх үзэгдлүүд өөр хоорондоо нягт хамааралтай бөгөөд үүний нэг нь дэлхийн дулааралтай холбоотой уур амьсгалын өөрчлөлт, түүнээс үүдсэн гамшгийн эрсдэлүүд юм. Энэ утгаараа бидний оршин байгаа бүс нутаг дахь гамшгийн эрсдэлийн асуудал бол улс орны үндэсний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй харгалзаж үзэх хүчин зүйл гэдэг нь тодорхой юм.

Үүний тод илэрхийлэл нь Монгол Улсын Их Хурлаас батлан мөрдөж байгаа Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010) баримт бичигт гамшиг нь үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийн нэг болохыг тодорхойлсон явдал. Тодруулбал, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)-д "Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдолоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн" гэж томъёолж Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах таван арга зам тодорхойлсоны тавдахь арга зам нь "байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах"-д чиглэсэн арга хэмжээнүүдийг багтааж өгсөн.

Эндээс гамшгийн эрсдэл нь үндэсний аюулгүй байдалд онцгой чухал нөлөөтэй гэдгийг харж болно.

Иймд энэхүү судалгаанд бидний амьдарч буй Зүүн хойд Азийн салбар бүс нутаг дахь гамшгийн эрсдэлийг Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хүрээнд зайлшгүй тооцох хүчин зүйл гэдгийг тус бүс нутгийн гамшгийн эрсдэл, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, эдгээрийн Монгол Улс дахь нөлөө ба оролцоогоор тодорхойлж харуулахыг зорилоо.

Зүүн хойд Азийн гамшгийн эрсдэл

Уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас дэлхий дахинд тохиолдох гамшгийн тоо улам бүр өсч байгаагийн дийлэнх нь Ази тивд тохиолдож байна (1-р зураг).

---

[49] О.Үржин, Зүүн хойд Азийн хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын тойм, , "Зүүн хойд Азийн хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал" олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2015

[50] At the Crossroads: Climate change adaptation and Disaster Risk Reduction in Asia and the Pacific, A Review of the Region's Institutional and Policy Landscape (2011). UNISDR, Asia Pacific secretariat, p.48



1-р зураг. Дэлхий дахинд тохиолдсон байгалийн гамшгийн хандлага, тивүүдээр[51]

Сүүлийн 10 жилийн статистикаас харахад Ази тивд жилд дунджаар 150 гаруй гамшиг тохиолдож байгаа нь дэлхий дахинд тохиолдсон нийт байгалийн гамшгийн 40 хувийг эзэлдэг. Эдгээр гамшигт жил бүр 200 сая гаруй хүн өртөж (дэлхийн хэмжээнд гамшигт өртсөн хүний 90%), жилд дунджаар 41.6 тэрбум ам.долларын хохирол (дэлхийн хэмжээнд учирсан нийт хохирлын 39%) учирч байна[52]. Түүнчлэн Ази тивд тохиолдож буй байгалийн гамшгийн 40% нь, гамшигт өртөгсдийн 88% нь Зүүн өмнөд болон Зүүн хойд Азид тохиолджээ[53].

Дэлхий дахинд улс орнуудын гамшгийн эрсдэлийг индексээр үнэлж харьцуулан гаргадаг хэд хэдэн хувилбарууд байна. Эдгээрээс энэ судалгаанд аюул, өртөнгө ба эмзэг байдал, даван туулах чадварын хүрэлцээгүй байдал гэсэн эрсдэлийн 3 үндсэн хүчин зүйлд үндэслэж дэлхийн 191 улс орнуудын эрсдэлийг тооцдог INFORM эрсдэлийн индексийн үнэлгээгээр Зүүн хойд Азийн 6 орныг харьцуулан авч үзлээ.

Энэхүү эрсдэлийн индексийг НҮБ болон Европын комиссоос хамтран дэлхийн улс орнуудын байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшиг ба хүмүүнлэгийн хямралын эрсдэлийн түвшинг индексээр илэрхийлж 2012 оноос эхлэн жил бүр 0-10 хүртэл оноогоор үнэлж гаргадаг. Энэхүү эрсдэлийн үнэлгээнд ган, салхи шуурга, газар хөдлөлт болон үер гэсэн байгалийн аюулт үзэгдлээс гадна улс орныг хямралд хүргэж болох эмх замбараагүй байдал, террорист халдлага зэрэг хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарах эрсдэлийг мөн тооцдог бөгөөд индексийн утга 10 руу дөхөх тусам эрсдэл ихсэж байгааг илтгэнэ. INFORM хэмээх эрсдэлийн үнэлгээний нээлттэй эх үүсвэрт тус бүс нутгийн гамшгийн эрсдэлийг дараах байдлаар тодорхойлсон байна (1-р хүснэгт).

1-р хүснэгт. Зүүн хойд Азийн улс орнуудын INFORM эрсдэлийн индекс[54]

УЛС ОРОН	INFORM ИНДЕКС*	3 ЖИЛИЙН ХАНДЛАГА	ЗЭРЭГ	БАЙГАЛИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛ	ХҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ГАМШГИЙН ЭРСДЭЛ
МОНГОЛ	3,8	↑	88	3,6	3,6
ОХУ	4,4	↑	62	6,3	5,7
БНХАУ	4,1	↓	74	7,9	5,5
БНСУ	1,6	→	170	5,2	1,8
БНАСУ	5,6	↑	30	4,8	5,3
ЯПОН	2,0	→	153	8,3	0,6
БҮСИЙН ДУНДАЖ	3,6			6,0	3,8

* Тайлбар: 10-6,5 эрсдэл маш өндөр, 6,4-5,0 эрсдэл өндөр, 4,9-3,5 эрсдэл дунд, 3,4-2,0 эрсдэл бага, 1,9-0 эрсдэл маш бага

Дээрх хүснэгтээс харахад Зүүн хойд Азийн бүс нутгийн 6 орны гамшгийн эрсдэлийн индекс сүүлийн 3 жилд ерөнхийдөө өсөх (Япон, БНСУ-аас бусад 4 орон) хандлагатай байна. Энэ бүс нутагт байгалийн гамшгийн эрсдэл өндөр (6.0) төвшинд, хүний үйл ажиллагаатай холбоотой эрсдэл дунд (3.8) төвшинд байна. Энд анхаарал татаж буй нэг зүйл бол манай орны урд, хойд хөрш орнуудад улс орныг хямралд хүргэж болох эмх замбараагүй байдал, террорист халдлага зэрэг хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарах эрсдэл өндөр буюу ОХУ-д 5.7, БНХАУ-д 5.5 байгаа явдал юм.

ЗХА-д гамшгийн эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйл

XXI зууны хүн төрөлхтний өмнө бодитой тулгарч уур амьсгалын өөрчлөлт, хүн амын эрчимтэй өсөлт, хотжилт, хүрээлэн байгаа орчны доройтол зэрэг асуудлаас үүдсэн байгаль, нийгэм дэх өөрчлөлт нь гамшгийн эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна. Энэ талаар "Эрсдэлийн нийгэм"-ийн онолыг үндэслэгч Германы социологич У.Бек[55] бидний амьдарч буй XXI зууныг "эрсдэлийн зуун" гэж нэрлэж, "нийгэм ба техносферийн

[51] ADB (2013) Food Security in Asia and the Pacific. Manila: ADB and LIU Institute for Global Issues.
[52] Yasuyuki SAWADA and Fauziah ZEN (2014). Disaster Management in ASEAN, p1
[53] ADB (2013) Food Security in Asia and the Pacific. Manila: ADB and LIU Institute for Global Issues.
[54] Index for Risk Management, 2017 http://www.inform-index.org/
[55] Ulrich Beck, "Risk Society: Towards a New Modernity", 1992

хөгжлийн одоогийн хандлага хадгалагдсан нөхцөлд XXI зууны дунд үеэс гамшгийн нөхцөл байдал нийгмийн амьдралын хэвийн үзэгдэл болно" гэж тодорхойлсон.

Дэлхийн дулааралт, уур амьсгалын өөрчлөлт

Дэлхийн агаарын температур хоёр хэмээс дээш дулаарвал экологийн тэнцвэр алдагдаж гамшгийн хэмжээнд хүрнэ гэж үздэг. XX зуунд агаарын температур 0.9 хэмээр дулаарсан. Эрдэмтдийн судалгаагаар агаар мандал дахь хүлэмжийн хийг яаралтай бууруулахгүй бол ойрын 15 жилд дэлхийн температур 2-4 хэмээр дулаарах төлөвтэй байгаа ажээ[56].

Энэ нь дэлхийн экосистемийн тогтолцоонд өөрчлөлт (ус, хөрс, ургамал, амьтны аймаг зэрэг) гарахын сацуу байгалийн гамшигт үзэгдлийн давтагдал, эрчим нэмэгдэхэд нөлөөлж байна. Тухайлбал, Ази тив тэр дундаа Зүүн хойд Азийн бүс нутагт зонхилон тохиолдож байгаа гамшгийн нөхцөл байдлаас харахад уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан байгалийн гамшгийн тоо улам бүр нэмэгдэж байна.

2-р зураг. Ази Номхон далайн бүс нутагт тохиолдсон байгалийн гамшгийн тоо, гамшгийн төрлөөр

Энэ зургаас харахад ус, цаг агаарын гаралтай гамшиг 1970-1979 онд жилд дундажаар 37 удаа тохиолддог байснаа 2000-2009 онд 146 удаа болж 4 дахин нэмэгдсэн байхад геологийн болоод биологийн гаралтай гамшгийн тоо харьцангуй бага хэмжээгээр нэмэгджээ. Ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл (үер, хүчтэй салхи зэрэг)-ийн дотроос үерийн давтамж 1970-1979 онд жилд 11 удаа тохиолдож байсан бол 2000-2009 онд жилд 72 удаа тохиолддог болж 6 дахин нэмэгдсэн[57].

Дэлхийн хэмжээнд жил бүр 6 сая га газар цөл болон хувирч байна. Үүний зэрэгцээ Африк, Ази тивийн 71%, Умард Америкийн 74%, Европ тивийн 5% цөлжилтөд өртсөн баримт байна[58].

Хэрвээ эдгээр өөрчлөлт цаашид энэ хэвээр үргэлжлэх бол улс орны хөгжлийн асуудалд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох шаардлага үүсэх бөгөөд энэ нөхцөл байдал нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хангахад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг түлхүү авч үзэх хэрэгцээг бий болгож байгаа юм.

Хүн амын өсөлт



Сүүлийн тавин жилийн туршид дэлхийн хүн ам 50 шахам нэмэгдэж түүхэнд гарч байгаагүй өсөлттэй тулгарч байна. Хүн амын ихэнхдээ Ази, Африкийн хөгжиж орнуудад явагдаж байгаа[59] бөгөөд үүнийгээ дагаад хотжилт эрчимтэй нэмэгдэх болов. Тухайлбал, 1950 дэлхийн 2,5 тэрбум хүний 30%-бага нь хотод амьдардаг байсан 1998 он гэхэд дэлхийн хүн амын 5,7 тэрбум болж өсч үүний 45% нь амьдрах болсон байна. Нэгдсэн үндэстний байгууллага 2025 он дэлхийн хүн ам 8,3 тэрбум болох бөгөөд үүний 60%-аас илүү нь хотод амьдрах тооцоо гаргажээ[60].

Хүн амын төвлөрөл ихэссэнээр улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцааны цар хүрээ улам бүр нарийн төвөгтөй болохын зэрэгцээ хүн ам ихээр төвлөрсөн газарт гамшиг үүсэх эрсдэл нь улам бүр нэмэгдэж байна.

Хүрээлэн байгаа орчны доройтол

Дэлхийн экосистем улам доройтож байгаагаас хүн төрөлхтний одоо ба ирээдүйн аюулгүй байдлын хангах үүднээс нийгмийн хөгжил, эдийн засгийн хөгжил, экосистемийг хадгалах гэсэн гурван асуудлыг нэг нь нөгөөгөө золиослохгүй байхаар харилцан хамааралд нь зохицуулах санааг илэрхийлдэг "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал"-ыг дэвшүүлэн тавьсан. Хүрээлэн буй орчин, эдийн засгийн өсөлт (амьдралын чанарын дээшлэлт), нийгмийн хөгжил гэсэн тогтвортой хөгжлийн гурван баганын үр дүн, үр дагавар нь эрчим хүчний аюулгүй байдал, түүнийг хангах шийдлээс ихээхэн шалтгаалдаг[61]. Үүнтэй холбоотойгоор сүүлийн 50 жилийн хугацаанд хөгжиж буй орнуудын эрчим хүчний хэрэглээ ойролцоогоор 350%-аар нэмэгдсэн[62].

Нэн ялангуяа Зүүн хойд Азийн улс орнууд эрчим хүчний хэрэглээгээр дэлхийд дээгүүрт орж байна. Энэ салбар бүс нутгийн улс орнуудаас БНХАУ, ОХУ, Япон, БНСУ эрчим хүчний дэлхийн хамгийн их хэрэглээтэй улсуудын эхний 9-д багтана. Тухайлбал, БНХАУ, ОХУ, Япон, БНСУ нийт хэрэглээгээрээ харгалзан 1, 3, 5 ба 9 дүгээр байруудад орж байна. Түүнчлэн хүрээлэн буй орчинд хамгийн их бохирдол учруулдаг газрын тосны хэрэглээгээр эдгээр дөрвөн орон дэлхийн эхний 9 (Хятад хоёрт, ОХУ тавд, Япон гуравт, БНСУ есд), нүүрсний

---

[56] О.Үржин, Зүүн хойд Азийн хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын тойм, , "Зүүн хойд Азийн хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал" олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2015

[57] Overview of Natural Disasters and their Impacts in Asia and the Pacific, 1970 - 2014, Disaster Risk Reduction Section ICT and Disaster Risk Reduction Division ESCAP

[58] Я.Адъяа, Х.Тэрбиш Байгаль хамгаалал, байгал орчны эрх зүйн асуудал. УБ., 2009, 188х., х71

[59] OECD, 2003

[60] Britton, N.R, 1998

[61] О.Үржин, 2015

[62] Brown, Gardner & Halweil, 1998

хэрэглээгээр эхний 7 (Хятад нэгд, ОХУ тавд, Япон дөрөвт, БНСУ долоод) орны тоонд багтдаг. Дан ганц Хятад улс нүүрсний хэрэглээгээр дэлхийн нийт хэрэглээний 50 хувийг эзэлж байна[63].

Энэ бүхэн нь бүс нутагтаа их хэмжээний бохирдол үүсгэж байгаа бөгөөд энэ нь хөрш орнуудын хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

Хүрээлэн буй орчны доройтол нь улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүн амыг аливаа гамшигт өртөх эмзэг байдлыг улам бүр ихэсгэнэ.

Зүүн хойд Азийн гамшгийн эрсдэлийн Монгол Улс дахь нөлөө

Монгол оронд байгалийн гаралтай болон хүний үйл ажиллагаанаас үүдсэн арав гаруй аюулт үзэгдэл, осол тохиолдож эдгээрийн нилээдгүй хувь нь гамшгийн хэмжээнд хүрдэг. Эдгээр байгалийн аюулт үзэгдэл, ослын тохиолдох давтамж, хамрах хүрээ сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, уул уурхайн эрчимтэй өсөлт, хотжилттой холбоотойгоор улам бүр нэмэгдэх болсон (2-р зураг).



2-р зураг. 2000-2015 онд гарсан аюулт үзэгдэл, ослын тоо, оноор (Эх сурвалж: Гамшиг судлалын хүрээлэн, 2016)

Монгол оронд тохиолдох гамшгийн ихэнх нь орон нутгийн хэмжээнд тохиолддог бол ой хээрийн түймэр, хүчтэй салхи, шуурга болон халдварт өвчин, цөлжилт зэрэг нь хөрш зэргэлдээ улс орон, бүс нутгийн түвшинд харилцан уялдаа холбоотой тохиолдож байна.

Сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэхэд жилд тохиолдох байгалийн гаралтай гамшгийн 60-70 хувийг ой, хээрийн түймэр эзэлж байгаа бөгөөд жилд дунджаар ойролцоогоор 10 түймэр ОХУ-аас хил давж орж ирдэг ба мөн тооны түймэр манай улсаас урд хөрш БНХАУ- руу дамждаг байна.

Монгол оронд хүчтэй салхи шуурга жилд дунджаар 20 орчим удаа тохиолддог бөгөөд эдгээрээс хаврын хуурайшилттай үед тохиолдсон *хүчтэй шороон шуурга* нэн хүчтэйгээр удаан үргэлжилсэн тохиолдолд түүний учруулах аюул, хор хөнөөл нь Монгол оронд төдийгүй бүс нутгийн түвшинд хүрдэг. Эрдэмтэд 1950-аад оноос хойш Зүүн хойд Азид тохиолдох шороон шуурганы тоо 5 дахин өссөнийг[64] тогтоож цаашид энэ аюулын давтамжийг улам бүр нэмэгдэх хандлагатай байна гэж үзэх болсон.

Биологийн гаралтай аюулт үзэгдэл болох хүн, малын халдварт өвчин нь манай оронд тохиолдсон нийт байгалийн гаралтай гамшгийн 17 хувийг эзэлж байгаа бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчин олноор гарах болсон. Эрдэмтэн, судлаачдын тэмдэглэснээр урьд өмнө манай оронд байгаагүй хэл хөхрөх хэмээх өвчин дэлхийн бөмбөрцөгийн өмнөд өргөрөгийн 38^0-аас хойд өргөрөгийн 40^0 хүртлэх халуун орны өвчин байжээ. Гэтэл энэ өвчин дэлхийн бөмбөрцөгийн хойд өргөрөгийн 40^0-аас хойш 53^0 өргөрөг хүртэл тэлж манай оронд бүртгэгдэх болсон. Үүнтэй холбоотойгоор шувууны томуу, хэл хөхрөх, амьсгалын замын хам шинж зэрэг 26 өвчин шинээр бүртгэгдэж, шүлхий, цэцэг өвчин зэрэг 8 өвчин дахин сэргэж байгаа өвчнөөр бүртгэгдээд байна[65].

Цөлжилт, газрын доройтлын үйл явц нь өнөөдөр дэлхийн 100 гаруй оронд илрэлээ олсон дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй экологийн бүлэг асуудлын нэгд зүй ёсоор багтах болсон байгаль, нийгэм, эдийн засгийн хавсарсан нөлөөнд явагдах экологийн үйл явц юм. Монгол орны хувьд цөлжилтөд илүү өртөмтгий буюу хуурай, гандуу бүс нутаг нийт нутгийн 41 хувийг эзлэн тархсан, газар зүйн байрлалын хувьд Сибирийн ой, Төв Азийн цөлийн шилжилтийн бүсэд орших байрлал зэрэг нь уур амьсгалын ерөнхий өөрчлөлт, нийгмийн хөгжлийг дагасан хүрээлэн буй орчны доройтол, газар болон байгалийн нөөц ашиглалтад гарах өөрчлөлтүүдэд ихээхэн эмзэг байдалтай газар нутаг юм.

Үүнтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд Монгол орны хэмжээнд ажиглагдаж буй дулаарлын үйл явц, бэлчээрийн мал аж ахуйд гарсан тоон өөрчлөлт, уул уурхайн замбараагүй үйл ажиллагаа зэрэг нь цөлжилтийн үйл явцыг улам бүр хурдасгах хүчин зүйл болж байна. Иймээс байгаль, нийгэм, эдийн засгийн хавсарсан нөлөөн дор хөгжих цөлжилтийн үйл явц, түүний үр дагаврыг шинжлэх ухааны үүднээс үнэлэх асуудал нь үндэсний, бүс нутгийн, олон улсын төвшинд чухалд тооцогдож байна. 2010 оны цөлжилтийн нэгдсэн зургаас харвал Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 77,8 хувь нь их, бага хэмжээгээр цөлжилт, газрын доройтлын үйл

[63] О.Үржин, Зүүн хойд Азийн хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын тойм, , "Зүүн хойд Азийн хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал" олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2015

[64] 8th Special Session of the Governing Council of the United Nations Environment Programme and Global Ministerial Environment Forum, 29 to 31 March 2004

[65] Д. Оргил (2014). Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй мал аж ахуйн салбар дахь гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал, ЭШХ, Улаанбаатар.

явцад өртсөн бөгөөд үүнээс 35,3 хувь нь сул, 25,9 хувь нь дунд, 6,7 хувь нь хүчтэй, 9,9 хувь нь нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж байна.[66]

Эдгээр гамшгийн төрлүүд нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Иймд Монгол улс нь цаашид бүс нутгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр хамтран ажиллах хэрэгцээ, шаардлага өндөр байгааг харж болно.

ДҮГНЭЛТ

Үндэсний аюулгүй байдлыг хангахад бүс нутгийн гамшгийн эрсдэлийг харгалзах асуудлыг авч үзсэн энэхүү судалгаанаас дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын удаа дараагийн үзэл баримтлалд гамшгийн эрсдэл нь үндэсний аюулгүй байдалд онцгой чухал нөлөөтэй гэдгийг тодорхойлж өгсөн байна.
- Хүн төрөлхтний өмнө тулгарч буй уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, хотжилт, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг асуудлуудын нөлөөгөөр Зүүн хойд Азид тохиолдох гамшгийн давтамж, цар хүрээ улам бүр нэмэгдэж байна. Бүс нутгийн гамшгийн эрсдэлийн энэхүү нөхцөл байдал нь манай орны нутаг дэвсгэрт их, бага хэмжээгээр нөлөөллөө аль хэдийн үзүүлж эхэлжээ.
- Энэ бүхэн нь цаашид бүс нутгийн гамшгийн эрсдэлийг улс орныхоо аюулгүй байдлыг хангахад харгалзаж үзэх нэн чухал хүчин зүйл гэдгийг харуулахын зэрэгцээ гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг нэгтгэн авч үзсэн бүс нутгийн хамтын ажиллагааг бүх талаар өргөжүүлэх нэн ялангуяа хамтарсан эрсдэлийн судалгааг явуулах шаардлагатай гэдгийг харуулж байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010
2. Гамшиг судлалын хүрээлэн, Монгол оронд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээний эмхэтгэл 2000-2013, 2014-2015,
3. Д. Оргил (2014). Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй мал аж ахуйн салбар дахь гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал, ХСИС, Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал эрдэм шинжилгээний хурал, Улаанбаатар
4. О.Үржин (2015)., Зүүн хойд Азийн хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын тойм, , "Зүүн хойд Азийн хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал" олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл
5. Н.Мандах, Ж.Цогтбаатар, Д.Даш (2013)., "Монгол орны цөлжилтийн төлөв байдал" Ногоон хөгжил – XXI зууны гурван талт хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл Монгол, Орос, Хятад гурван орны эрдэмтдийн IV форумын эмхэтгэл.
6. Я.Адъяа, Х.Тэрбиш (2009)., Байгаль хамгаалал, байгал орчны эрх зүйн асуудал
7. At the Crossroads: Climate change adaptation and Disaster Risk Reduction in Asia and the Pacific, A Review of the Region's Institutional and Policy Landscape (2011). UNISDR, Asia Pacific secretariat
8. Yasuyuki SAWADA and Fauziah ZEN (2014). Disaster Management in ASEAN
9. ADB (2013) Food Security in Asia and the Pacific. Manila: ADB and LIU Institute for Global Issues.
10. 8th Special Session of the Governing Council of the United Nations Environment Programme and Global Ministerial Environment Forum, 29 to 31 March 2004
11. Overview of Natural Disasters and their Impacts in Asia and the Pacific, 1970 - 2014, Disaster Risk Reduction Section ICT and Disaster Risk Reduction Division ESCAP
12. www.inform-index.org
13. CRED Crunch (2013)"Disaster Data: A Balanced Perspective", Issue No. 30 http://reliefweb.int/sites/reliefweb.int/files/resources/CredCrunch30.pdf

[66]Н.Мандах, Ж.Цогтбаатар, Д.Даш "Монгол орны цөлжилтийнтөлөв байдал" Ногоон хөгжил – XXI зууны гурван талт хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл Монгол, Орос, Хятад гурван орны эрдэмтдийн IV форумын эмхэтгэл., УБ., 2013 он.., 35 дах тал.

КИБЕР ОРЧИН БА ТЕРРОРИСТ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Д.Сумъяацэрэн
Хууль сахиулахын их сургууль, Эрдэм шинжилгээ, инновацийн газар, Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, цагдаагийн ахмад
Л.Цогтбаяр
Хууль сахиулахын их сургууль, Цагдаагийн сургуулийн Мөрдөх албаны тэнхимийн багш

Хураангуй: Энэхүү илтгэлд кибер орчны өнөөгийн байдал, кибер орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, Европол буюу Европын цагдаагийн байгууллагаас 2016 онд гаргасан тайлан мэдээнд үндэслэсэн террорист үйлдлийн ангилал, мөн манай улсад бүртгэгдсэн кибер халдлагын зарим тохиолдол зэргийг авч дүгнэн тодорхой санал дэвшүүлжээ.

Түлхүүр үг: Кибер орчин, кибер гэмт хэрэг, террорис үйл ажиллагаа, кибертеррорист үйлдэл.

Цахим орчин гэдэг нь мэдээлэл технологийн орчин дахь үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх ойлголт, харин "**кибер**" гэсэн үг нь цахим үйл ажиллагааг хэрэгжүүлж буй дэд бүтэц, орчны үйл ажиллагаа түүний удирдлагын талаарх илүү өргөн хүрээний ойлголтыг илэрхийлдэг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал[67]-ын 3.6.1.11-д "**Кибер орчин** дахь гэмт явдалтай тэмцэх, аливаа гэмт хэргийг илрүүлэх, нотлоход тооцоолох хэрэгслийн криминалистик техникийн шинжилгээ ашиглах үндэсний чадавхийг бий болгоно", 3.6.1.1-т. "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн орчинд сөргөлдөх аюулаас сэргийлэх, **кибер орчин** дахь гэмт явдалтай тэмцэх чиглэлд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ" гэж тодорхойлсон.

Бид цаашид "Цахим гэмт хэрэг" бус "Кибер гэмт хэрэг" гэж томьёолж, нэг мөр хэрэглээнд нэвтрүүлэх нь оновчтой байх эрх зүйн үндэслэлтэй.

"Кибер гэмт хэрэг" гэж дэлхий нийтэд нэгдсэн тодорхойлолт өдийг хүртэл байхгүй боловч "Кибер гэмт хэргийн тухай" 2001 оны европын /Будапештийн/ конвенцид ч энэ талаар цогц тодорхойлолт байхгүй байгаа нь техник, технологийн хэт өсөнгүй, хурдатай хөгжилтэй холбоотой.

Товчхондоо "Компьютер, мэдээллийн сүлжээ, интернет ашиглан үйлдэгдсэн бүх төрлийн гэмт хэрэг" гэж ойлгож болно. Кибер гэмт хэрэг нь дараах байдлаар ангилагдана.

- Хувь хүний эсрэг (вирус, залилан, фишинг, спэм г.м)
- Өмчийн эсрэг (бусдын эд хөрөнгийг сүйтгэх, хортой програм тараах г.м)
- **Төр, олон нийтийн эсрэг** (Кибер терроризм, Мэдээллийн дайн)

Компьютер хэрэглээнд нэвтэрснээс хойш үйлдэгдэх болсон "кибер гэмт хэрэг" нь компьютер, сүлжээ, систем, интернэт ашиглан гэмт хэрэг үйлддэг байсан бол одоо үед улам боловсронгуй болж, утасгүй сүлжээг өргөн ашиглахаар болсон учир энэ талын гэмт үйлдлийн хандлага, шинж, түүнтэй тэмцэх тогтолцоог судлах шаардлага бий болсон.

Кибер орчны өнөөгийн байдал

Компьютерын техник нь бидний амьдралд гүн гүнзгий нэвтэрч гэр ахуй, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, худалдаа, банк, батлан хамгаалах, эмнэлэг-анагаах ухаан, бүх шатны боловсрол олгох сургалт, шинжлэх ухаан, соёл урлаг (шоу бизнес) г.м. нийгмийн бүхий л салбарт компьютер өргөн ашиглагдаж байна. Хөгжлийн төвшингөөр манай орон хэдийгээр "хөгжиж байгаа" ч гэсэн дэлхийн технократ иргэншлийн салшгүй хэсэг учраас "бүх нийтийн компьютержилт", мэдээлэл холбооны технологи тодорхой хэмжээнд нэвтрэхийн сацуу уламжлалт гэмт хэрэг, зөрчил цахим хэлбэрт хувирч, шинэ төрлийн гэмт хэргүүд үйлдэгдэх болж, сүлжээ, систем, мэдээллийн нэгдмэл, бүрэн бүтэн байдал, нууцлал, хамгаалалтад заналхийлэх аюулууд олширч зөвхөн гэмт хэрэг бус цахим терроризмын аюул, эрсдэл эрс нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Үүний улмаас мэдээллийн аюулгүй байдлын асуудал нь зөвхөн программ-техникийн асуудал байхаа больж улам бүр нарийн төвөгтэй, захиргаа-удирдлагын асуудал болон хувирч байна.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь дан ганц асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байгаад зогсохгүй иргэн, хувийн хэвшил, иргэний-нийгмийн байгууллага, бүс нутаг, олон улсын хамтын ажиллагаанаас ихээхэн хамаарах болоод байгаа.

Арван жилийн өмнө интернетийг зөвхөн Personal computer буюу ширээний компьютер хэрэглэгч нар ашигладаг байсан бол энэ цаг үед утас, таблет, ухаалаг бугуйн цагтай дурын хэн боловч интернетийг ашиглах боломж бүрдсэн. Канадын "Hootsuite" компаний 2017 оны

[67] Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол.

нэгдүгээр сарын байдлаар гаргасан судалгаагаар дэлхийн нийт хүн ам 7,4 гаруй тэрбумд хүрсэн бол эдгээрээс 3,7 гаруй тэрбум нь интернет ашигладаг, нийгмийн сүлжээг идэвхтэй ашигладаг 2,7 гаруй тэрбум хүн байдаг бол гар утсаар нийгмийн сүлжээг ашигладаг 2,5 гаруй тэрбум хэрэглэгч байгааг тэд тогтоожээ.[68]

Харин манай улсын тухайд 2017 оны нэгдүгээр сарын байдлаар нийт хүн ам 3,03 сая, эдгээрээс 1,6 сая нь интернет, нийгмийн сүлжээг ашигладаг бол гар утсаар нийгмийн сүлжээг ашигладаг 1,5 сая хэрэглэгч байдаг талаар тус байгууллагын тайланд дурджээ. Эндээс дэлхий нийт, тэр тусмаа манай улс мэдээлэл холбооны технологийн дэвшлийг бүх салбарт өргөн ашиглаж, улам бүр хөгжиж байгаа боловч аюулгүй байдлын хувьд онцгой эрсдэлт нөхцөл байдал бодитой бий болжээ.

Кибер орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг

Кибер орчны хөгжлийг гэмт хэрэг үйлдэх нөхцөл, хэрэгсэл болгон хувь хүний эсрэг, өмчийн эсрэг, **төр-засаг, иргэд, олон нийтийн эсрэг** (кибер терроризм болон мэдээллийн дайн) ашиглах үзэгдэл дэлхийд төдийгүй манай улсын хэмжээнд жил тутам харьцангуй өссөн үзүүлэлттэй байна.

Эрүүгийн цагдаагийн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс 2016 онд нийт 57 холбогдогчтой, 2.044.040.0 /хоёр тэрбум дөчин дөрвөн сая дөчин мянга/ төгрөгийн хохиролтой, 60 хэрэг, үйлдлийг илрүүлэн холбогдох албадад шилжүүлж ажиллажээ.

Тухайлбал, кибер орчинд компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 14, иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих гэмт хэрэг хоёр, интернэт орчинд садар самуун сурталчилсан хоёр, интернэт орчинд мөрийтэй тоглоом зохион байгуулсан хоёр, бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлсэн 10, бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэрэг хоёр, галт зэвсэг худалдсан нэг, мансууруулах бодис хадгалсан нэг хэргийг илрүүлэн, шалгасан байна.

Харин **төр-засаг, иргэд, олон нийтийн эсрэг** (кибер терроризм болон мэдээллийн дайн) ашиглах үзэгдэл бүртгэгдээгүй боловч энэ талын гэмт үйлдлийн онцлог шинж, хандлага, ангилалыг судлах, мэдээллийг цуглуулах, хамтран ажиллах шаардлага зүй ёсоор бий болсон.

Харин интернетийг террорист үйл ажиллагаанд ашиглах үзэгдэл Европ болон АНУ, Зүүн Өмнөд Азийн улс орнуудад түгээмэл үйлдэгдэж байгаа талаар олон улсын хууль сахиулах байгууллагууд бүртгэн мэдээлэл ирүүлж байна.

Террорист бүлэглэлүүд бүлэглэлдээ гишүүд элсүүлэх, сургалтын видео файлууд байршуулах, үйл ажиллагаагаа бусдад сурталчлах, мөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэх зэрэг зорилгоор интернетийг өргөнөөр ашиглаж байна.

Жишээ нь, террорист бүлгүүдээс гар хийцийн тэсрэх бөмбөг хэрхэн бүтээх, угсрах ажиллагааг харуулсан, сургасан бичлэг, бусдыг гэмт үйл ажиллагаанд өдөөн турхирах, олон нийтийг айдаст автуулах зэрэг мэдээллийг цахим орон зайд түгээх нь маш богино хугацаанд асар олон хүнд хүрдэгээрээ онцлогтой аюулт үйлдэл байдаг.

Улс орнууд төрийн бодлого, үндэсний стратеги төлөвлөгөөндөө кибер аюулгүй байдлын талаар тусгах зайлшгүй шаардлага байгаа талаар Европын аюулгүй байдлын холбооны шинжээчид зөвлөж, уриалж байна. Мөн олон улсын хууль сахиулах байгууллагуудын болон хувийн хэвшлийнхний хамтын ажиллагаа, тэр дундаа техникийн болон бодлогын талаасаа хамтран ажиллах нь энэ төрлийн гэмт үзэгдэлтэй тэмцэхэд онцгой ач холбогдолтой.

Манай улс Европын аюулгүй байдлын холбооны 57 дахь гишүүн орон болсон нь кибер аюулгүй байдалтай холбоотой тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар бусад гишүүн орнуудтай хамтран ажиллаж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох ач холбогдолтой.

Кибертерроризм ба Европол

Терроризмын албан ёсны тодорхойлолтыг 2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр терроризмтой тэмцэх Зөвлөлийн ерөнхий шийдвэрийн 1-р зүйлд тодорхойлсон бөгөөд Европын холбооны гишүүн бүх улс орнууд өөр өөрсдийн дотоодын хууль тогтоомжид тусгаж, баталсан. Тус зөвлөлийн боловсруулсан ерөнхий шийдвэрт алан хядах шинжтэй гэм буруутай үйлдлийн "агуулга, хэлбэрийн хувьд аливаа улс орны аль эсхүл олон улсын байгууллагыг хохирооход чиглэсэн:

- Тухайн улсын ард иргэдийг айлган сүрдүүлэх, айдаст автуулах;
- Засгийн газар, эсвэл олон улсын байгууллагыг ямар нэгэн үйлдлээсээ татгалзах эсвэл олон нийтэд харш шийдвэр гаргуулах;
- Аливаа улс орон, олон улсын байгууллагын улс төр, эдийн засаг, хүн ам зүйн нийгмийн бүтцийг тогтворгүй болгох, бүр мөсөн устгах зорилготой үйлдлийг ойлгоно" гэж тодорхойлсон.

Терроризмын төрөл[69]

[68] http://www.smartinsights.com/social-media-marketing/social-media-strategy/new-global-social-media-research/

Европын цагдаагийн (EUROPOL) 2016 оны тайланд дурдсанаар террорист үйл ажиллагааг дараах байдлаар ангилсан байдаг. Үүнд:

- **Jihadist terrorism** (Жихадист терроризм-шашин шүтлэгтэй холбоотой)
- **Right-wing terrorism** (Хэт барууны үзэл баримталсан терроризм буюу "Баруун жигүүрийн" гэж нэрлэдэг)
- **Left-wing terrorism** (Хэт зүүний үзэл баримталсан, анархист терроризм буюу "зүүн жигүүрийн" гэж нэрлэдэг)
- **Ethno-nationalism and separatism** (Хэт үндсэрхэг-националист болон салан тусгаарлах терроризм)
- **Single-issue terrorism** (Нэг удаагийн, бие даасан терроризм буюу амиа золиослох гэх мэт)

Жихадист терроризм

Исламын шашины гаж урсгалд хэт итгэсэн хувь хүн, зохион байгуулалттай бүлэг, гэмт сүлжээ болон бүлгүүд өөрсдийн гэм буруутай үйл ажиллагаагаа бурхны хүсэл хэмээн мухар сүсгээр "зөвтгөн" гүйцэтгэдэг.

"Жихадист терроризм" гэдэг нэр томьёог "шашин шүтлэгтэй холбоотой терроризм" болон "Исламын шашны терроризм" гэх нэршилтэй дүйцүүлэн хэрэглэхээр болсон ба учир нь хэт туйлширсан жижиг бүлгийн үзэл суртал нь Исламын шашины олон арван сая сүсэгтэн олныг төлөөлөх үндэслэлгүй бөгөөд шашин шүтлэгийг аливаа гэмт үйлдэлтэй холбож болохгүй гэж үзсэн. "Шашин шүтлэгтэй холбоотой терроризм" гэх нэршил нь чухам ямар төрлийн гэмт үйлдлийг ийм төрлийн терроризм гэж ойлгохыг тодорхой зааж өгөөгүй зэрэг хүндрэлтэй хэд хэдэн шинэ асуултуудыг бий болгож байна.

Цаг хугацааны явцад ийм төрлийн терроризмыг тодорхойлсон төрөл бүрийн нэршил бий болсон. Тухайлбал, "хэрцгий жихадизм", "Исламын шашинтай холбоотой цэрэгжилт" болон "терроризм шашны нэрийг барих" гэх мэт. "Жихадист терроризм" гэдэг ангилал дор шашны ариун судар бичиг болон домогт түүхэн бичгээс тодорхой хэсгийг сонгон өөрсдийн гаж үзлийг зөвтгөн бусад үзэл санааг "хуйвалдааны онол"[70] хэмээн итгүүлж гэмт үйл ажиллагааг гүйцэлдүүлэх зорилготой тодорхой хувь хүн, бүлгүүдийг ойлгоно. Террорист бүлгүүд нь гэмт үйл ажиллагаандаа барууны иргэншлийн эсрэг үзэл, еврейчүүдийн эсрэг үзэл, ижил хүйстнүүдийн эсрэг зэрэг үзэл санааг давхар агуулж, энгийн ард иргэдийн эсрэг аймшигт гэмт хэрэг үйлддэг.

Ийм төрлийн террорист бүлэглэлд багтаж байгаа гишүүдийн зарим нэг нь өөрсдөө шашин шүтлэггүй байж болох бөгөөд хувийн өс хонзон, ашигийн үүднээс гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байна. Европын холбооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн ихэнх террористууд нь барууны иргэншлийн амьдралын хэв маягт хорссон, улмаар хэт туйлширсан экстремист суртал ухуулгад автсан хүмүүс байдаг. Эдгээр хүмүүс аль ч шашны сургаал, номлолд байдаггүй үзлийг баримтлан өөрсдийн гэмт үйлдлийг зөвтгөдөг.

Хэт барууны үзэл баримталсан терроризм ("Баруун жигүүрийн")

Хэт барууны үзэл баримталсан террорист бүлгүүд улс төр, нийгэм, хүн ам зүй болон эдийн засгийн системийг өөрчилж, хэт барууны загвараар улс орныг удирдан жолоодохыг хүсдэг. Хэт барууны үзэлд давамгайлдаг нэг үндсэн санаа нь тухайн бүлэг өөрсдийгөө бусдаас илүү гэж тодорхойлоод нийтийг нэг яс үндэстэн аль эсхүл тодорхой бүлэг захиран удирдах ёстой гэсэн гаж үзэл. Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, эрх мэдлийг хэт шүтэх, бусад улс үндэстнүүдээс айж эмээх болон цагаачдыг үзэн ядах шинж чанар ийм төрлийн экстремист бүлэгт түгээмэл байдаг. Нео-Нацист, нео-Фашист болон хэт үндсэрхэх бүлгүүд энэ ангилалд багтана.

Хэт зүүний үзэл баримталсан, анархист

Хэт зүүний үзэл баримталсан террорист бүлгүүд улс төр, нийгэм, хүн ам зүй болон эдийн засгийн системийг бүхэлд нь өөрчилж, утоп нийгмийн тогтолцоо болох коммунист үзэл суртал бүхий нийгмийн анги давхаргүй улс байгуулахыг зорилгоо болгодог бөгөөд хэт зүүний үзэл баримталсан терроризмын дэд ангилал бол анархист терроризм.

Энэ нь оюуны үнэт зүйлийг эрхэм зорилго болгосон хүмүүнлэг, ардчилсан нийгмийн тогтолцооны эсрэг төдийгүй эрх мэдэл, хөрөнгөт давхрагыг эрс эсэргүүцдэг.

Хэт зүүний үзэл баримталсан террорист бүлгүүдийн жишээ нь Италийн Улаан Бригад болон Грекийн Хувьсгал Байгууллага зэрэг байна.

Хэт үндсэрхэг-националист болон салан тусгаарлах терроризм

Хэт үндсэрхэг-националист болон салан тусгаарлах хүсэлтэй террорист бүлгүүд хэт үндсэрхэг үзэл болон зөвхөн нэг шашин ноёрхох ёстой гэсэн үзэл агуулсан байдаг. Салан тусгаарлах хүсэлтэй бүлгүүд нэг том улсаас жижиг хэсгийг тасдан авч, өөрсдийн улсыг байгуулахыг хүсдэг бөгөөд тэд өөр нэг улсын газар нутгаас булааж авах гэсэн үзэлд автсан байх жишээтэй. Ийм төрлийн бүлэгт хэт зүүний болон барууны шинж чанартай үзлүүдэд тод ажиглагддаг. Бүгд Найрамдах Ирландын Зэвсэгт Хүчин, Баскийн ЭТА болон Курдын ПКК энэ ангилалд багтана.

Нэг удаагийн, бие даасан терроризм

Нэг удаагийн шинжтэй, бие даасан экстремист бүлгүүд аливаа улс оны улс төр, нийгэм, хүн ам зүй болон эдийн засаг, үйлдвэрлэлийн системийг бүхэлд нь өөрчлөхөөс илүүтэйгээр аль нэг улсын төрийн бодлого аль эсхүл амьдралын хэв шинжийг эрс өөрчлөхийг хүсдэг. Энэ ангилалд багтах бүлгүүд ихэвчлэн амьтдын эрх, байгаль орчны аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, үр хөндөлтийн эсрэг зэрэг нийгмийн шинжтэй компанит ажил өрнүүлдэг. Тухайн ангилалд багтах бүлгүүдээс дурдвал, Эх Дэлхийг Чөлөөлөх Фронт болон Амьтдыг Чөлөөлөх Фронт зэрэг байна.[71]

---

[69] Европын цагдаа [Europol] "Террорист нөхцөл байдал, чиг хандлагын тайлан" [Terrorism Situation and Trend Report TE-SAT]. Европын цагдаагийн алба. 2016 он.

[70] Conspiracy theory

[71] Европын хууль сахиулах агентлагийн "TE-SAT 2016" тайлан. 43 дахь тал.

Дээрх террорист бүлэглэлүүд интернет сүлжээг алан хядах ажиллагаандаа түлхүү ашиглах хандлагатай болсон. Гэмт бүлэглэл нь террорист үйл ажиллагаандаа интернет сүлжээг ашиглан халдлагын объект болгож дэлхий дахин, бүс нутаг, аль нэг улсын төр засаг, нийгмийн бүлгүүдийг багтаадаг бөгөөд хор аюул нь төрийн тэргүүн, албан хаагчид, ард иргэд, нийгмийн тодорхой бүлгийн гишүүд нэг бүрт хүрч улмаар бодлого үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлж чаддаг терроризм гэж үздэг.

Техник технологийн өндөр хөгжлийн эрин үед терроризмын нэг төрөл, тэр дундаа мэдээллийн терроризмд багтаж байгаа кибертерроризмын аюул улам бүр дэлгэрч алв нэгэн улс орон, нутаг дэвсгэрийн хил хязгаар харгалзалгүйгээр үйлдэгдэх эрсдэл өндөр болсон энэ цаг үед энэхүү терроризмын эсрэг дэлхий нийтээрээ тэмцэх төдийгүй олон улсын хууль сахиулах хамтын үйл ажиллагааны нэг хэсэг болж байна.

Кибертеррорист үйлдлийн шинж

Кибертерроризм нь мэдээллийн дэд бүтэц, харилцаа холбоо, компьютер, компьютерийн сүлжээ, системийг ашиглан уламжлалт терроризмын шинж чанарыг агуулж улс төр, нийгэм, хүн ам зүй, эдийн засаг, шашины тогтолцоог хохироох, сүйтгэх зорилгоор урьдчилан төлөвлөсөн хорлон бусниулах ажиллагаа төдийгүй бодит амьдралд физик хөнөөлтэй, мэдээллийн дэд бүтцийг хүчтэй уналтанд оруулах террорист үйлдэл.

Кибер терроризм үйлдэгдэх бүс, хил хязгаар нь кибер орон зай хаана оршиж байна тэр бүгдийг хамаарч үйлдэгддэг. Кибер орон зай гэдэг нь мэдээллийн дэд бүтцийн харилцан холбоотой бүх сүлжээ, түүн дотроо интернэт, харилцаа холбооны сүлжээнүүд, компьютерийн систем, эмзэг дэд бүтэц бүхий салбар дахь бүхий л үйл явц тэдгээрийн хэрэглээ, хяналт, хамгаалалтын орчин. Үүнд: Дэд бүтцэд нь мэдээллийн технологи бүрэн нэвтэрсэн автомат удирдлагатай, компьютерийн хяналтын систем бүхий үйлдвэрийн дэд бүтцийг авч үзнэ. Тухайлбал: Атомын цахилгаан станц, цөмийн үйлдвэр, кибер сэтгүүл зүй, телевиз, радио, банк, төмөр зам, агаарын тээвэр, автозамын хөдөлгөөний зохицуулалтын компьютерийн удирдлагын сүлжээнд халдан террор үйлдэх аюул нэгэнт бий болсон байна.

Мэдээллийн технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед террорист аюул заналхийлэл хүрээгээ тэлж зохион байгуулалтын хувьд улам сайжирч, кибер халдлагыг хувь хүн, бүлэглэл үйлдэхээс илүүтэйгээр тодорхой нэг улсаас зохион байгуулан үйлдэх хандлага ажиглагдаж байна. Үүний тод жишээ бол 2010 оны 7 сард илэрсэн "**Stuxnet**" нэртэй хортой код кибер орчинд тархаасан. Уг хортой код нь Иранд илэрсэн бөгөөд компьютерийн экспертүүдийн тодорхойлсоноор "зорьсон объект"-доо аль хэдийнээ халдсан байх магадлал өндөртэй гэж дүгнэж байна.

Энэ нь Ираны "**Bushehr**" цөмийн эрчим хүчний үйлдвэр байх магадлалтай бөгөөд хортой код үйлдвэрийн удирдлагын системд нэвтрэн байрлаж өөрт ирэх зааврын дагуу үйлдвэрийг бүрэн удирдах чадвартай байхаар бүтээгдсэн нь хамгийн их аюултай.

Мэргэжилтнүүд уг хортой кодыг цөмийн үйлдвэрийн удирдлагын системд нэвтэрсэнээс нь улбаалан "кибер цөмийн зэвсэг" гэж нэрлэхэд хүрсэн. Мөн кибер ертөнцийг үзэл санаа, дургүйцэл, зэвүүцлээ илэрхийлэх талбар болгон ашиглаж байгаа нь олон нийтэд айдас түгшүүрийг төрүүлж байна. Тухайлбал: Оросын хакерууд Эстоний төв талбайд байрлаж байсан Оросын цэргийн хөшөөг нүүлгэсэнийг эсэргүүцэн 2007 оны 4 сарын 27-оос эхлэн дөрвөн долоо хоногийн турш Эстоны засгийн газрын порталууд, банк, хэвлэл мэдээллийн байгууллагууд руу халдсан нь асар хэмжээний эрсдэлт үйл ажиллагаа болсон.

Сүүлийн үед Украин улсаас гаралтай гэх мэдээлэл барьцаалагч "**Petya**"[72] (Петя) нэртэй вирус дэлхий даяар тархаж олон улсын анхааралыг зүй ёсоор татсан. Энэ вирус нь Оросын Роснефт, АНУ-ын эмийн бүтээгдэхүүний Merck, олон улсын эрчим хүч, тээврийн Maersk, Британий сурталчилгаа, PR-ийн WPP зэрэг томоохон компаниудын компьютерийн системд халдаж, мэдээллийг нь барьцаалсан байдаг[73]. Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн Эдуард Сноуден "Petya" вирусыг мөн NSA-ийн компьютерт нэвтрэх аргыг ашиглан тархаж байгаа гэж дүгнэжээ.[74] Мөн 2017 оны 5 дугаар сард "**WannaCry**"[75] вирус дэлхий даяар тархаж, 100 гаруй орны 300 мянга орчим компьютер цахим халдлагад өртсөн байна. "WannaCry" нь NSA (Америкийн Үндэсний Аюулгүй байдлын Агентлаг)-ийн ашигладаг байсан системийн цоорхойгоор халддаг байсан тухай мэргэжилтэн нар тодорхойлж байна.

Кибертеррорист үйлдэл, Монгол Улс

Манай улсын хувьд мэдээллийн технологи, цахим үйлчилгээ бүхий л салбар, хувь хүний хэрэглээнд өргөн нэвтэрсэн байгаа нь кибер халдлага, терроризм үйлдэгдэх орчин нөхцөл нэгэнт бий болсоныг харуулж байна. Ерөнхий сайд 2004 онд оюутан, залуучуудтай онлайн ярилцлага хийх үед сүлжээний үйлчилгээг унагах довтолгоо хийсэн. Банк, санхүү, бизнесийн зарим байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын түвшин доогуур байгааг ашиглан мөнгө хулгайлах тохиолдол цөөнгүй үйлдэгдэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн веб сайт www.president.mn 2008 онд 11 сарын 15-нд халдлагад өртөж нүүр хуудсанд зураг байрлуулж, АНУ-ын ерөнхийлөгчийн илгээсэн и-мейлийг устгасан. Нийгмийн даатгалын

---

[72] Petya is a family of encrypting ransomware that was first discovered in 2016. The malware targets Microsoft Windows-based systems, infecting the master boot record to execute a payload that encrypts a hard drive's file system table and prevents Windows from booting. It subsequently demands that the user make a payment in Bitcoin in order to regain access to the system.

[73] Мэдээлэлд тус вирус халдаж биткоиноор $300 төлсөн тохиолдолд компьютерийн мэдээллээ олж авахыг шаарддаг байна.

[74] "Компьютерийн "Петя" вирус дэлхий даяар тархлаа". 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдөр. http://www.ikon.mn/n/11q8

[75] The WannaCry ransomware attack was a May 2017 worldwide cyberattack by the WannaCry ransomware cryptoworm, which targeted computers running the Microsoft Windows operating system by encrypting data and demanding ransom payments in the Bitcoin cryptocurrency. The attack began on Friday, 12 May 2017, and within a day was reported to have infected more than 230,000 computers in over 150 countries.

ерөнхий газрын мэдээллийн системээс 2008 онд нийт цалингийн цэс алдагдсан. МУ-ын төрийн байгууллагуудын нэгдсэн портал вэб сайт www.pmis.gov.mn 2009 онд хакерын халдлагад өртсөн ба сайтад хортой код байрлуулсан байсан зэрэг нь кибер ертөнц дэх аюулгүй байдлаа хангаж ажиллах шаардлагатайг илтгэж байна.

Кибер халдлага, террорист үйл ажиллагаанаас сэргийлэх нь мэдээллийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдалтай зайлшгүй холбогддог. Иймээс цахим орчин дахь мэдээллийн аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг бүх түвшинд сайжруулах, эзэмшигч, хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах мэдлэг, ёс зүй, чадварыг нь дээшлүүлэх хэрэгтэй. Америк, Англи, Герман, Япон, БНСУ зэрэг орнуудад кибер орчны мэдээллийн аюулгүй байдлыг хангах, халдлагатай тэмцэх үйл ажиллагааны цогц эрх зүйн орчныг бүрдүүлэн дагаж мөрддөг улмаар кибер халдлагад хариу үйлдлийн чиглэлээр эрчимтэй ажиллаж байгаа туршлага, арга барилыг судлан хамтран ажиллах шаардлагатай.

Ийнхүү интернет түүний сүлжээ нь террорист үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл төдийгүй үндсэн "БАЙ" нь болж байна.

Кибер терроризм нь уламжлалт терроризмоос дараах шинжээр ялгаатай байдаг.

- Өөрийгөө нуух, нуугдах боломжтой.
- Мэдээлэл технологийн систем нэвтэрсэн ямар ч "бай" сонгох боломжтой.
- Илрүүлэхэд хүндрэлтэй.
- Үйлдэгч этгээдэд бие махбодын зэрэг эрсдэл байхгүй.
- Хөрөнгө оруулалт бага шаардана.
- Орон зай хамаарахгүй удирдах боломжтой.

Кибер терроризмтэй тэмцэх зорилгоор дэлхийн улс орнууд олон улсын гэрээ конвенци боловсруулж байгаа нь эрх зүйн нэгдсэн хамгаалалтын тогтолцоог бий болгож хамтын ажиллагааг өргөжүүлэх эхлэл болж байна.

Манай орон энэ бүх үйл ажиллагаанд нэгдэн орохоос гадна олон улсын эрх зүйн баримт бичигт үндэслэн үндэсний онцлог, хандлагыг тусган дотоодын эрх зүйн баримт бичгийг батлан, мөрдүүлж, мэдээллийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдлын цогц арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй шаардлага бий болсон байна.

Дүгнэлт

Манай улс Европын аюулгүй байдлын холбооны 57 дахь гишүүн орон, кибер аюулгүй байдалтай холбоотой тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар бусад гишүүн орнуудтай хамтран ажиллаж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох ач холбогдолтой. Хэдийгээр манай улсад кибер халдлагыг эс тооцвол террорист үйл ажиллагаа одоогоор бүртгэгдээгүй боловч эрсдэлт бүлэгт зүй ёсоор хамаарч байна.

Мэдээллийн технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед террорист аюул заналхийлэл хүрээгээ тэлж зохион байгуулалтын хувьд улам сайжирч, кибер халдлагыг хувь хүн, бүлэглэл үйлдэхээс илүүтэйгээр тодорхой нэг улсаас зохион байгуулан үйлдэх хандлага ажиглагдаж байна.

Санал

1. Кибер аюулгүй байдлыг хангах, кибер гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын болон үндэсний эрх зүйн тогтолцоог бий болгож, мөрдүүлэх.
2. Иргэдийг террорист үйл ажиллагааны талаар сурталчилж буй сурталчилгааны эсрэг нийтэд, тэр дундаа өсвөр үеийнхэнд хандсан эерэг сурталчилгаа, мессеж өгөх, мэдээллээр тогтмол хангах тогтолцоог бий болгох. Иргэдийн кибер орчинд ажиллах ёс зүй, ухамсарыг дээшлүүлэх, энэ талын боловсролыг шат шатанд нь олгодог байх.
3. Хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг чадваржуулах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хүний нөөц, кибер мөрдөгчдийг тусгайлан бэлтгэдэг тогтолцоо бий болгох. мэдээллийн технологийн салбарт байр сууриа олсон, мэргэжлийн IT инженерүүдтэй хамтран ажиллах, тэднийг энэ төрлийн гэмт явдалтай тэмцэхэд авч ажиллуулах.
4. Цахим эд мөрийн баримтыг шинжлэх боломж бүхий техник, технологи бүхий лаборатори бий болгох нөхцлийг бүрдүүлэх.
5. Кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах олон улсын болон дотоодын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх шаардлага бий болжээ.

БЭЛГИЙН МӨЛЖЛӨГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

Ц.Бат-Эрдэнэ
Хууль сахиулахын их сургуулийн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч

Гэмт явдал нь нийгмийн болон эрх зүйн үзэгдэл бөгөөд энэхүү үзэгдэл нь өөрийгөө хүн төрөлхтөнд таниулаад байхыг төдийлөн хүсдэггүй, судлахад маш төвөгтэй үзэгдэл[76] учраас эрдэмтэн, судлаачид энэхүү нийгмийн сөрөг үзэгдлийн шалтгаан, нөхцлийг тогтоох зорилгоор тасралтгүй судалж, шинжлэн өөр өөрсдийн үзэл номлолыг дэвшүүлэн тавьсаар ирсэн.

Гэмт явдлын шалтгаан, нөхцлийг нийгмийн мөн чанараас салангид авч үзэх боломжгүй бөгөөд хүн төрөлхтөн, нийгэм оршин байгаа цагт нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдал бодитойгоор оршсоор байх болно.

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шалтгаан, нөхцлийг зөв тогтоосноор энэ төрлийн гэмт хэргийн мөн чанарыг нээн илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагааг оновчтой зохион байгуулах зэрэг олон талын ач холбогдолтой.

Гэмт явдлын шалтгаан нь нөхцөлтэйгээ харилцан холбоотойгоор түүгээр дамжин илэрдэг[77] бөгөөд гэмт явдлын шалтгаан, нөхцөлд задлан шинжилгээ хийхийн тулд "хүчин зүйл" гэсэн ойлголтыг тодруулах нь чухал ач холбогдолтой байдаг. Хүчин зүйл нь гэмт явдлын гаралтад нааштай нөлөө үзүүлэхийн зэрэгцээ сөрөг нөлөө үзүүлж болно. Тухайлбал, Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн тухайд энэхүү хүчин зүйл нь дэлхий нийтийг хамарч буй даяаршил бөгөөд манай улс ч дэлхий нийтийн нэгэн адил даяарчлагдаж байна. Даяаршлын нөлөөгөөр манай улсын хөгжил, цэцэглэлтэд ач холбогдолтой шинэ боломжууд бий болохын зэрэгцээ олон улсын шинжтэй гэмт хэргүүд "экспортлогдох" эрсдэл бүхий нөхцөл байдал бий болоод байна.

Гэмт явдлын шалтгааныг агуулгаар нийгэм, эдийн засгийн, үзэл суртлын, соёл хүмүүжлийн, удирдлага, зохион байгуулалтын, нийгэм, сэтгэл зүйн гэж ангилахын зэрэгцээ гэмт явдлын ерөнхий шалтгаан, тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, тодорхой нэг гэмт хэргийн шалтгаан гэж ангилж болно.[78]

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн нийгэм, эдийн засгийн харилцаанаас үүдэлтэй, тодорхой нэг гэмт хэргийн шалтгааныг дараах байдлаар авч үзлээ. Үүнд:

1.Эдийн засгийн тогтворгүй байдал

Эдийн засгийн хөгжил буурай, төрөөс хүний эрхийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ сул улсуудад хүний бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдал, нийгмийн ёс суртахуунд халдах гэмт хэрэг илүү ихээр үйлдэгддэг. Монгол Улсад сүүлийн жилүүдэд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт инфиляцийн түвшинд шууд нөлөөлж, инфиляци хоёр оронтой тоонд шилжээд байна.

Эдийн засгийн тогтворгүй байдал нь нийгэмд ажилгүйдэл, ядуурлын түвшинг нэмэгдүүлснээр иргэд өөрсдийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг хангахыг эрмэлзэхээсээ илүү амь амжиргаагаа хэрхэн залгуулах тухай илүү анхаардаг болох нь бидний судалгаагаар тогтоогдсон. Охид эмэгтэйчүүд гэр бүлээ тэжээх, амь зуухын тулд биеэ үнэлэх зам руу ихээр орж, тэдний энэхүү эмзэг байдлыг нь гэмт этгээдүүд овжиноор ашиглаж, тэднийг бэлгийн мөлжлөт ашиглаж, ашиг хонжоо олж байна.

2. Ядуурал

Манай улсын эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд өссөн үзүүлэлттэй, энэ нь манайхтай ижил эдийн засгийн хөгжилтэй орнуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт боловч сүүлийн 2 жил буурсан үзүүлэлттэй байгаа нь манай эдийн засгийн өсөлт тогтворгүй байгааг илтгэнэ. Эдийн засгийн үзүүлэлт буурсан нь ядуурал төдий чинээгээр их байгааг илтгэх нэгэн үзүүлэлт юм.

Үндэсний Статистикийн газар НҮБ-ын зөвлөмжийн дагуу Дэлхийн Банк, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2003 онд Улсын хэмжээгээр ядуурлын талаар явуулсан судалгаангаар хүн амын 36.1% буюу 900.000 хүн ядуу амьдарч байна. Үүнээс баруун бүст 51.1% нь ядуу амьдарч[79] байсан бол 2012 оны байдлаар ядуурлын түвшин 39.1% болж, даруй 3%-иар өссөн үзүүлэлтэй байна.[80]

Судлаачдын зүгээс бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шууд шалтгааныг дараах байдлаар авч үзлээ. Бид энэ түвшний судалгааг явуулахдаа хууль сахиулагчид болон иргэдээс дор дурдсан шалтгаануудаас:

1. Улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал;
2. Ажилгүйдэл;
3. Ядуурал;
4. Иргэдийн бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг;
5. Иргэдийн амар хялбар аргаар мөнгө олох хүсэл, эрмэлзлэл;
6. Залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх газар цөөн, баар, цэнгээний газар их;
7. Хууль сахиулах байгууллагаас урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй явуулдаг;
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх урт;
9. Хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдын хүнд суртал гаргадаг, иргэдийг чирэгдүүлдэг;
10. Хууль сахиулах байгууллагуудын ажлын ачаалал их;

---

[76] "Гэмт хэргийн бодит тоон үзүүлэлийг тогтооход нөлөөлж болох хүчин зүйлс".Б.Батзориг.// "Гэмт явдалтай тэмцэх асуудал".2002., №1., 9-р тал
[77] Н.Жанцан. "Криминологи". УБ., 2004., 44-р тал
[78] Н.Жанцан. "Криминологи".УБ., 2004., 45-р тал
[79] Үндэсний статистикийн газрын Эдийн засгийн судалгааны хэлтсийн дарга Б.Бадамцэцэгийн мэдээлэл.2006.01.18
[80] Үндэсний статистикийн газрын мэдээлэл. 2012.12.10

11. Хууль, эрх зүйн орчин бүрдээгүй;
12. Бусад

Хамгийн гол гэсэн 3 шалтгааныг нэрлэнэ үү гэсэн асуултад хууль сахиулагчдын 86% нь ажилгүйдал, ядуурал, 82% нь иргэдийн амар хялбар аргаар мөнгө олох хүсэл, эрмэлзэлэл, 62% нь хууль сахиулах байгууллагуудын ажлын ачаалал их, 48% нь иргэдийн энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг, 26% нь хууль бус зар сурталчилгаанд тавих хяналт хангалтгүй, 6% нь залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх газар цөөн гэж, иргэдийн 96% нь ажилгүйдал, ядуурал, 92 % нь иргэдийн амар хялбар аргаар мөнгө олох хүсэл, эрмэлзэлэл, 82% нь иргэдийн энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг, тус тус хариулсан байна. Хамгийн их хувь авсан шалтгаан нь ажилгүйдэл, ядуурал, иргэдийн амар хялбар аргаар мөнгө олох хүсэл, эрмэлзэлэл, иргэдийн энэ гэмт хэргийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг явдал байна.

3. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн сөрөг нөлөөлөл

Монгол Улсад сүүлийн жилүүдэд сонин, сэтгүүл, богино долгионы FM радио, арилжааны телевизүүд ихээр байгуулагдаж, иргэд нийтийн сүлжээ буюу social media-г өргөнөөр ашиглаж байна. Энэ нь иргэд мэдээ, мэдээллийг цаг тухай бүр нь түргэн шуурхай авах боломжийг нэмэгдүүлж байгаа боловч арилжааны телевизүүд болон сонин, сэтгүүл, нийтийн сүлжээгээр гэмт хэргийн шинжтэй зар мэдээ ихээр цацагдах болсон бөгөөд эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа зар мэдээнд хууль хяналтын байгууллагаас тавьж буй хяналт байхгүй байна.

Гэмт этгээдүүд хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчдыг элсүүлэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ялангуяа, нийтийн сүлжээ буюу social media) ашиглах чиг хандлагатай байна. Тухайлбал, 2004 оны 9 дүгээр сард Д гэгч эмэгтэй хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар нийтлүүлж, Япон улсад өндөр цалинтай ажилд зуучилна гэж 7 эмэгтэйг хууран мэхэлж Макаод аваачин тус бүрийг 3500 ам.долларaар худалдсан, 2004 оны 10 дугаар сард 10 эмэгтэйг мөн Макао руу худалдахыг завдсан (2006 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 17 дугаартай Сүхбаатар дүүргийн Шүүхийн шийтгэх тогтоол.) Мөн Б гэгч facebook.com-д Дэлхийг тойрон аялагчдын клуб гэсэн групп хаяг нээж, гадаадад аялуулна, суралцуулна хэмээн хууран мэхэлж, групптээ элсүүлэн, элсэлтийн хураамж гэж 60 иргэнээс 205-380 ам.доллар авсан байна. **Үүнээс үзэхэд, гэмт этгээдүүд нийтийн сүлжээг ашиглан хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн болон залилан мэхлэх зэрэг гэмт хэргийг үйлдэж, богино хугацаанд олон хүнийг элсүүлэх бүрэн боломжтой болох нь харагдаж байна.**

2006-2010 онд Нийслэл, дүүргүүдийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн нийт 12 хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн зар сурталчилгааг түгээсэн байгууллагуудыг ямар нэгэн байдлаар хэрэгт хамааруулан шалгаагүй, хариуцлага хүлээлгээгүй байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд ЭБШ хуулийн 80.1.6-д заасан гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг нотлох хүрээнд хууль бус зар сурталчилгааг түгээсэн байгууллагад хариуцлага тооцдог болох нь чухал ач холбогдолтой.

Шүүгчидтэй ярилцлага хийх явцад: *"ТВ чат"-аар хүүгээ захиалга өгч алуулсан "Чатны эмээ"-ийн гэх хэрэгт прокурор хяналт тавихдаа чатаар тэр зарыг нэвтрүүлсэн телевизийг эрүүгийн хариуцлагад татах ёстой байсан. Хэрэв татсан бол бусад мэдээллийн хэрэгслүүдэд тодорхой хэмжээгээр сургамж болох байсан"* гэж нэгэн шүүгч хэлснийг зориуд тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самуун, биеэ үнэлэхийг сурталчилсан, уриалсан кино, нэвтрүүлэг цагийн хязгаарлалтгүй, ямар нэгэн хяналтгүй цацагдаж, дээрх нэвтрүүлэг маргааш нь давталтаар өдрийн цагаар нэвтрүүлэгдэж байгаа нь өсвөр, залуу үеийнхэний хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлж, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх хүчин зүйл болж байна.

2010 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хийсэн судалгааны тайланд нийслэлд нэвтрүүлгээ цацдаг телевизүүд болон "ЧАТ" сувгаар нийт 254 цагийн биеэ үнэлэх, биеэ үнэлэхэд татан оролцуулах, түүнийг зохион байгуулахад уриалсан, өдөөн түлхсэн хууль бус зар сурталчилгаа явагдсан талаар дурджээ.[81] Үүнд:

№	Утас	Мэдээллийн агуулга	Түгээж буй телевиз	Огноо
1.	9997...	25 настай, царайлаг, дажгүй залуу байна. Анусаар секс хийх бүсгүй байвал залга.	NTV телевиз	2009.04.02
2.	8816…	7-9 насны цэвэрхэн, онгон охидууд хайж байна		
3.	9907...	Ні бүсгүйчүүдээ дуудлагаар очиж хөхний толгой цоолж ээмэг зүүж өгнө сак бүсгүйчүүд байна уу? Үнэ хямд		

Монгол Улсын хэмжээнд нийт 50 FM радио үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 18 FM радио нэвтрүүлгээ цацаж байна. Үүнээс 2 FM радиог сонгон авч мэдээллийн агуулгад дүн шинжилгээ хийхэд гол төлөв садар самууныг сурталчилсан, бэлгийн мөлжлөгийн шинжтэй сурталчилгаа явуулж байсан.[82] Тухайлбал,

[81] Хууль зүйн Үндэсний хүрээлэн. Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл судалгааны тайлан. УБ., 2010. 24 дэх тал

[82] Хууль зүйн Үндэсний хүрээлэн. Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл судалгааны тайлан. УБ., 2010. 24 дэх тал

FM радиогийн эрэгтэй хөтлөгч утсаар шууд нэвтрүүлэгт холбогдсон оролцогчдоос "Чи нэг эрэгтэй, 2 эмэгтэй гурвуулаа секс хийж үзсэн үү? Мөнгө, хайр, секс гурвын алийг нь илүүд үздэг вэ? чи хамгийн сүүлд хэзээ секс хийсэн бэ? Найз залуутайгаа юу? Эсвэл зуурдын хүнтэй юу?" зэргээр асууж байна.

Хөтлөгчийн энэхүү садар самуун, ёс суртахуунгүй үг хэллэг хэрэглэж байгаа нь өсвөр үе залуучуудын хүмүүжилд сөргөөр нөлөөлж, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг үйлдэгдэх хүчин зүйл болж байна. Учир нь FM радиогийн нэвтрүүлэгт холбогдсон оролцогчдын 91 хувь нь өсвөр үе буюу 14-18 насныхан, хүйсийн хувьд 60.5% эмэгтэй, 39.5% нь эрэгтэй байдаг нь судалгааны явцад ажиглагдсан.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дээр дурдсан хэлбэрээр түгээгдэж буй хууль бус зар сурталчилгаа нь бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг үйлдэгдэх хүчин зүйл болж байна. Энэ нь "*Хууль бус зар сурталчилгаа нь Эрүүгийн хуульд заасан ямар төрлийн гэмт хэрэг үйлдэхэд голчлон нөлөөлдөг болох?"* гэсэн асуултад иргэдийн 240 буюу 80 хувь нь бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг, 200 буюу 66.8 хувь нь хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, 80 буюу 26.7 хувь нь хүчиндэх гэмт хэрэг, 80 буюу 26.7 нь бусад гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байна гэж тус тус хариулснаар[83] нотлогдож байна.

2010 онд Хууль зүйн Үндэсний хүрээлэнгээс хийсэн "Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг" судалгааны тайлангаас үзэхэд бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг үйлдэгдэхэд хамгийн их нөлөөлж буй шалтгаанд асуулгад оролцогчдын 45 хувь нь эцэг, эхийн хараа хяналтгүй байдал, садар самуун, хүчирхийллийг сурталчилсан хууль бус сурталчилгааг хяналтгүйгээр олон давталттайгаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж байгаа байдал, хүүхэд, залуучуудын ёс суртахууны төлөвшил тааруу байдал, 24 хувь нь мэдээлийн хэт задгай байдал, гэр бүлийн хүчирхийлэл, 10 хувь нь хүүхэд, залуус чөлөөт цагаа өнгөрөөх орчин байхгүй" гэж тус тус хариулжээ.

Эцэст нь хэлэхэд "шинэ төрлийн арга"-аар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь "шинэлэг хэлбэр"-т шилжсэн учраас хууль сахиулах байгуулагын албан хаагчид "шинэлэг арга барил"-аар ажиллахыг нөхцөл байдал харуулж байна. Мөн хохирогч өөрийн нэр төрийг хамгаалах, ичих, айх зэргээс шалтгаалан энэ гэмт хэргийн илрүүлэлт бага байдаг. Энэ нь бэлгийн мөлжлөгт өртөгдсөн хохирогч, гэрчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт хомстой холбоотой.

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд цагдаагийн байгууллага төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, олон нийтэд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн тухай мэдлэг, мэдээлэл өгөх, хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг сургаж, чадавхжуулах, хохирогчдод хууль зүйн болон эдийн засгийн туслалцаа өгүүлэх зэргээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах ихээхэн ач холбогдолтой.

Цагдаагийн байгууллагаас Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүйсийн тэгш эрхийн төв, Хүний эрх хөгжил төв, Иргэдэд туслах хүний эрхийн төв, Хүний аюулгүй байдлын судалгааны төв зэрэг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх, иргэдэд энэ төрлийн гэмт хэргийн тухай ойлголт, мэдээлэл өгөх, судалгаа хийх зэргээр үйл ажиллагаа явуулж буй эдгээр байгууллагуудтай хамтран ажиллах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх нь зүйтэй.

Цагдаагийн байгууллага хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн тухай иргэдийн ойлголт, мэдээллийг нэмэгдүүлэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн байгууллагаас хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг бэлтгэн нэвтрүүлж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл бэлтгэн нэвтрүүлэхэд төсөв хөрөнгө ихээр шаардагддаг тул гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр томоохон төслийг санхүүжүүлэн хэрэгжүүлж буй Швейцарийн хөгжлийн агентлаг, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүний аюулгүй байдлын судалгааны төв зэрэг төрийн бус байгууллагуудтай цагдаагийн байгууллага хамтран биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд энэ төрлийн гэмт хэргийн ойлголт мэдээлэл өгөхүйц мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг үзэгчдийн оргил цагаар олон давталттайгаар телевизийн сувгаар цацаж байгаа нь үр дүнтэй ажил болж байна. Тухайлбал, Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг, түүний нийгмийн хор аюулын талаарх мэдээллийн дагуу иргэд цагдаагийн байгууллага болон төрийн бус байгууллагад хандаж, улмаар эрхээ хамгаалуулж, гэм буруутай этгээдэд шүүхээс эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах зорилгоор мэдээлэл сурталчилгааг өргөжүүлж хууль сурталчилах өдөрлөг, уулзалт, уралдаан тэмцээн, сургалтыг цагдаагийн байгууллагын төрөл мэргэжлийн албадаас төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээллийг телевизээр болон богино долгионы радио, сонин хэвлэлээр өгч ажилласан нь энэ иргэдийн энэ төрлийн гэмт хэргийн ойлголтыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд байгууллагыг татан оролцуулах, тэдний идэвхи санаачлагыг өрнүүлэхэд зохих үр нөлөө үзүүлж байна. Тухайлбал, 2010-2012 онд Хүний эрхийн Үндэсний комисс, Хууль зүйн Үндэсний хүрээлэн, шүүх, прокурор, цагдаагийн байгууллага хамтран хууль сахиулах байгууллагын албан хаагчдад "Хүн худалдаалах гэмт хэргээс урьчилан сэргийлье" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Цаашид энэхүү хамтын ажиллагааг улам эрчимжүүлэх шаардлагатай.

---

[83] Хууль зүйн Үндэсний хүрээлэн. Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл судалгааны тайлан. УБ., 2010. 24 дэх тал

Цагдаагийн байгууллага иргэдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын иргэдийн оролцоо, дэмжлэгт тулгуурлах явуулах шаардлагатай байна. Нутгийн захиргааны байгууллага харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг, нийтийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийг нийтийн эргүүлд гаргах, хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр томилох, нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчаар ажиллуулж байна. Энэ нь ач холбогдолтой болох нь практикаар тогтоогдсон. Энэхүү үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх шаардлагатай байна.

Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын сургалт сурталчилгааг сайжруулах шаардлагатай байна. Ингэхийн тулд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зурагт хуудас, мэдээллийн самбар ашиглах нь үр дүнтэй.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн оюутнуудын энэ төрлийн гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор сургалт явуулах, тэдэнтэй хамтран ажиллах шаардлагатай. Оюутан, сурагчид энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий бүлэгт хамаардаг. Сүүлийн жилүүдэд оюутнууд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч болох явдал нэмэгдсэн нь энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмагтай холбоотой гэж үзэж болно. Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулиудын хичээлийн хөтөлбөрт *"Гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх"* чиглэлийн хичээлийг оруулах ихээхэн ач холбогдолтой. Төв, орон нутгийн цагдаагийн байгууллагаас улирал, сар тутам тогтмол ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, оюутнуудад бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хохирогч болохгүйн тулд юуг анхаарах ёстой болохыг сурагчдын нас, хөгжлийн онцлогт тохируулан хөгжөөнт тоглоом, уралдаан тэмцээн, лекц, сургалтын кино үзүүлэх зэрэг сонирхолтой арга хэрэгслээр явуулах нь зүйтэй. Мөн тухайн орон нутагт байрлах сургууль тус бүрт өсвөрийн цагдаагийн бүлгэмийг байгуулан ажиллуулж, уг бүлгэмийн үйл ажиллагааг цагдаагийн байгууллага дэмжин мэргэжлийн удирдлагаар ханган нягт хамтран ажиллах шаардлагатай. Цагдаагийн байгууллага сургуулийн захиргаа, нийгмийн ажилтан, сурагчдын зөвлөлийг дээрх ажлуудад татан оролцуулах нь илүү үр дүнтэй бөгөөд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэж өгнө.

Цагдаагийн албан хаагчдыг чадавхжуулахад анхаарах шаардлагатай байна. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нэгэнт үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх арга барил эзэмшүүлэх, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд байнга анхаарч ажиллах, цагдаагийн байгууллагаас албан хаагчдын дунд сургалт, семинарыг тогтмол зохион явуулах, гадаад, дотоодод мэргэжлийн сургалтанд хамруулан мэргэшүүлэх нь зүйтэй. Энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судлан шинжлэх, түүнд шинжлэх ухааны үндэслэлтэй анализ хийх чиг үүрэг бүхий албан хаагчдыг бэлтгэх, гадаадын орнуудад энэ төрлийн гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэж буй тэргүүн туршлагыг судалж, нэвтүүлэх нь үр дүнтэй.

Ашигласан материал

Нэг. Монгол Улсын хууль тогтоомж

1. Цагдаагийн албаны тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2015. №29
2. Гүйцэтгэх ажлын тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1999.№3
3. Гэр бүлийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1999. №30
4. Зар сурталчилгааны тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2002. №23
5. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2012. №8
6. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1998. №3

Гурав. Нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага

3.1 Монгол хэлээр

1. Адъяабазар Д., Төрмандах З. Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэс. УБ., 2005
2. Батзориг Б., Оюунболд Г., Оюунбилэг Д. Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал. УБ., 2010
3. Болдбаатар Б. Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдлын шалтгаан судлалын асуудалд. УБ., 2004
4. Гантулга С. Хүн худалдаалах гэмт хэрэг (нэмж засварласан 2 дахь хэвлэл). УБ., 2013
5. Жанцан Н. Криминологи. УБ., 2004

Судалгааны материалууд

1. Хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн байдал /15 жилээр/ судалгааны тайлан. Нийслэлийн шүүх, Хүний аюулгүй байдлын судалгааны төв. УБ., 2010
2. Монгол улс дахь хүн худалдах гэмт хэрэг: эрсдэл, эмзэг байдал, хор уршиг судалгааны тайлан. Хүйсийн тэгш эрхийн төв. УБ., 2006
3. Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлын хэмжээг тогтоох аргачлал судалгааны тайлан. Хохирогчийн эрхийн судалгааны төв, Хүний аюулгүй байдлын судалгааны төв. УБ., 2010
4. Орон нутагт гарч буй хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шалтгаан, нөхцөлд хийсэн судалгаа судалгааны тайлан. Орон нутгийн санаачлага, Хүний аюулгүй байдлын судалгааны төв.УБ., 2010
5. Цагдаагийн Ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төв. "Монгол улс дахь 2016 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал". УБ., 2015
6. Цагдаагийн Ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төв. "Монгол улсад 2003-2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт". УБ., 2013

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЯЛ ТЭНСЭХ ИНСТИТУТЫН ШИНЭЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ

Ц.Цэлмэг
"Их Засаг" ОУИС-ийн проректор, доктор, дэд профессор

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлд ял тэнсэх институтыг өмнөх хуулиудаас зарчмын өөр агуулгаар хуульчилсан, "хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх" тухай ойлголтыг шүүхийн практикт нэг мөр ойлгож хэвшүүлэх, шинээр Эрүүгийн хуулийг сурталчлах зорилгоор дээрх сэдвийг сонголоо.

Ял тэнсэхийг үг зүйн хувьд авч үзвэл: **Ял**-улсын хуулиар оногдуулах зэмлэл, шийтгэл гэсэн утгатай бол; **Тэнсэх** нь- юмс үзэгдлийн үнэн болон ташаа, сайн болон мууг сорих, үйл хэргийг турших гэсэн утгатай[84] хэмээн тайлбарлажээ.

Ял тэнсэх хоёр үндсэн хэлбэр дэлхийн улс орнуудад түгээмэл хэрэгжиж байгаа бөгөөд хорих болон бусад төрлийн ял оногдуулсаны дараа биелэлтийг нь хойшлуулж, түдгэлзүүлдэг / **Parole/** хэлбэрийг пост-социалист орнууд болон манай улс саяханыг хүртэл хэрэглэж ирсэн.

Хоёрдахь хэлбэр нь /**Probition-пробация/** буюу ял оноохгүйгээр тэнсэж, тодорхой үүрэг хүлээлгэдэг хувилбар нь Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнууд төдийгүй эх газрын эрх зүйн бүлд хамаарах цөөнгүй улсууд хэрэглэгддэг бөгөөд 2015 оны Эрүүгийн хуулиар ял тэнсэх "пробация" хэмээх тогтолцоог сонгож авсан нь дэвшил болсон гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Монгол Улсын шүүхийн тоо баримтаас үзэхэд жилд дунджаар 8000 орчим хүн ял шийтгэгддэгээс 6400 орчим хүнд хорих ял оногдуулдаг, тэдгээрийн тал хувьд нь буюу 3200 шүүгдэгчид оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр тэнсэж хянан харгалзжээ[85].

Он	**Ял шийтгүүлсэн хүн**	**Тэнссэн хүний тоо**	Тэнссэн хугацаанд гэмт хэрэг үйлдсэн хүний тоо
2013	8065	3342	112
2014	8178	3396	188
2015	7696	3197	189
2016	6566	3266	199

Түүхэн уламжлалын хувьд авч үзвэл 1926 оны БНМАУ-ын "Шүүх цаазын бичиг"-ийн 8 дугаар зүйлд "..шүүх газраас тогтоосон ялын хугацаа нь 5 жилээс хэтрэхгүй бол ялыг нь биечлэн эдлүүлэхгүйгээр түдгэлзүүлж болно, уг ялтан зөрчил гаргавал оноосон ялыг биечлэн эдлүүлнэ[86], 9 дүгээр зүйлд "...хэрэв уг ялтан тэнссэн хугацаа дуусахын өмнө дахин хэрэг үйлдвэрлэсэн шинэ хэргийн улмаас оногдуулсан ял дээр түдгэлзүүлсэн ялыг нэмж хамтатган хорих ялаар шийтгэнэ"[87].

Дээрх заалт нь 1929, 1934 оны Шүүх цаазын бичгүүдэд агуулгын хувьд ойролцоо байдлаар тусгагдсан ба дараа нь БНМАУ-ын 1961 оны Эрүүгийн хуулийн "Ял шийтгэл ба ялаас чөлөөлөх тухай" 4 дүгээр бүлгийн 33 дугаар зүйлд[88] "ял тэнсэх" үндэслэл, журмыг хуульчилжээ.

Хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэхээр шийтгэсэн ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж шүүх үзвэл тухайн шалтгааныг тодорхойлон тэнсэхээр тогтоож, 1-5 жилийн хугацаагаар хянан харгалзана гэж 33 дугаар зүйлд заасан бол дараа нь 1986 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын "Ял оногдуулах ба ялаас чөлөөлөх" 4 дүгээр бүлгийн 40 дүгээр зүйлд[89] мөн дээрх агуулгаар хуульчлагдсан байна.

Ял тэнсэх талаар манай олон эрдэмтэн санал бодлоо илэрхийлсэний заримаас дурьдвал: доктор (Sc.D) Б.Содовсүрэн "...шүүх ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн зохих зүйл заалтыг баримтлан хорих болон засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хянан харгалзах тодорхой хугацааны дотор ялыг биечлэн эдлүүлэхээс түдгэлзүүлэхийг хэлнэ[90]" гэсэн бол академич С.Нарангэрэл "...ял тэнсэх нь гэмт этгээдэд оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр ялын хүмүүжүүлэх зорилгод хүрэх, ялыг биечлэн эдлүүлэх болзлыг төр, олон нийтийн хяналт-шалгалт, олон нийтийн нөлөөллөөр төрийн өмнөөс зэмлэл шийтгэсэнээр илэрдэг арга хэмжээ мөн[91] гэжээ.

1926-2002 он хүртэл хорих ялаас гадна засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнсэж болдог, тэнсэгдсэн ялтанд нэмэгдэл ял, тодорхой үүрэг ногдуулдаг байсныг 2002 оны Эрүүгийн хуулиар өөрчилж

---

[84] Я. Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1976 он, 903 дахь тал.
[85] ШЕЗ-с эрхлэн гаргадаг Шүүн таслах ажиллагааны тайлан. 2011-2016 он.
[86] Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011 он, 283 дахь тал
[87] Ж.Болдбаатар. Д.Лүндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997 он, 156 дахь талд.
[88] БНМАУ-ын Хуулиуд. 1 дүгээр боть. УБ., 1980 он, 74 дэх талд
[89] БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 1986 он, 57 дахь талд.
[90] Б.Содовсүрэн. БНМАУ-ын Эрүүгийн эрх. УБ., 1969 он, 138 дахь талд
[91] С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий анги/. 1996 он, 340 дэх тал

зөвхөн хүндэвтэр гэмт хэрэгт 1-5 жилийн хугацаатай хорих ял оногдуулсан тохиолдолд уг ялыг нь биечлэн эдлүүлэхгүйгээр тэнсэж хянан харгалздаг, тэнсэгдсэн ялтанд үүрэг ногдуулдаггүй байхаар тогтоожээ.

2002 оны Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлд "...анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, хохирлоо нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан этгээдэд оногдуулсан хорих ялыг тэнсэж 1-5 жил хүртэл хугацаагаар хянан харгалзана[92] гэж заасан нь тэнсэх институтын харьцангуй хумигдмал хэлбэр байсан.

2002 оны Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийг хүчин төгөлдөр болсон Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйл заалттай харьцуулан судлахад дараах нөхцөл байдлууд өөрчлөгдөж, шинэчлэгдсэн байна. Үүнд:

Нэг. 2002 оны Эрүүгийн хуульд хорих ял оногдуулаад тэнсдэг байсантай холбоотойгоор "тэнсэгдсэн ялтан" гэж нэрлэж байсан, шинэ Эрүүгийн хуулиар хорих ял оногдуулахгүй тэнсдэг болсон учир цаашид "тэнсэгдсэн этгээд" гэж нэрлэж хэвших нь зүйтэй.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.1 дүгээр зүйлд "... эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, **хохирлыг нөхөн төлүүлэх,** гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг **дахин нийгэмшүүлэхэд** оршино" гэжээ. 2002 оны Эрүүгийн хуулийн 45 дугаар зүйлийн 45.3-д заасан эрүүгийн хариуцлагын зорилгоос "гэмт хэрэг үйлдсэн хүнийг **хүмүүжүүлэх**" зорилго хасагдсаныг дашрамд дурьдах нь зүйтэй.

Мөн хууль тогтоогч 2002 оны Эрүүгийн хуульд "хянан харгалзах хугацаа" гэсэн ойлголтыг хэрэглэж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар дээрх ойлголтыг халсан болно.

Хоёр. Тэнсэх журмыг өмнө нь хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээдэд л хэрэглэдэг байсныг шинэ Эрүүгийн хуулиар "хөнгөн гэмт хэрэг[93]" үйлдсэн этгээдэд хэрэглэх бөгөөд 2002 оны Эрүүгийн хуульд байсан "анх удаа гэмт хэрэг үйлдсэн" гэх шинжийг хассан.

Тэнсэхгүй байх хязгаарлалтыг тогтоохдоо "..Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хоёр, түүнээс дээш гэмт хэргийг санаатай үйлдсэн, эсхүл хорих ялын дээд хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн гэмт хэрэг үйлдсэн бол тэнсэхгүй" гэж тодорхойлсоноос үзэхэд хөнгөн ангилалд багтах хоёр төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тэнсэхгүй бөгөөд ялыг нь биечлэн эдлүүлнэ.

2002 оны Эрүүгийн хуульд тусгай ангийн өөр зүйл хэсэгт заасан 2 ба түүнээс дээш тооны хүндэвтэр гэмт хэргийг үйлдсэн байхад ялыг нэмж нэгтгэх буюу багтааж тухайн этгээд урьд нь гэмт хэрэгт холбогдож байгаагүй, хохирол төлсөн байхад тэнсэх боломж нээлттэй байсан бол шинэ Эрүүгийн хуулиар хаалттай болж байна.

Түүнчлэн зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн нь хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн, хохирол төлсөн ч тэнсэх боломжгүй, хүнд ангилалд хамаарах гэмт хэрэг буюу 5 жилээс дээш хорих ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тэнсэх журмыг хэрэглэхгүй бөгөөд ялыг оногдуулна.

Гурав. Өмнө нь хохирлыг бүрэн төлсөн, гэмт хорыг арилгасан тохиолдолд л хорих ялыг тэнсэх боломжтой байсныг шинэ хуулиар өөрчилж хохирол төлсөнөөс гадна хохирлыг нөхөн төлөхөө илэрхийлсэн байхад тэнсэх боломжийг шүүхэд олгосон. Гэм хор хэмээх ойлголтыг 2015 оны Эрүүгийн хуульд хэрэглээгүй, зөвхөн хохирол, хор уршиг гэх ойлголтыг хэрэглэхээр тусгасан болно.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хорих ялын дээд хэмжээг 3 жил болон түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэгт ялаас чөлөөлөх эсхүл 3 жил хүртэл хугацаагаар тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх сонголт байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасны дагуу хөнгөн гэмт хэрэг үйлдэж хохирлоо нөхөн төлсөн ч ялаас чөлөөлөхгүй бөгөөд харин тэнсэх сонголт байгааг анхаарах нь зүйтэй.

Дөрөв. **Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн этгээдэд л тэнсэх журам үйлчлэхээр 2015 оны Эрүүгийн хуульд заажээ. Өөрөөр хэлбэл хөнгөн гэмт хэрэг үйлдсэн боловч гэм буруугаа хүлээн зөвшөөрөөгүй, мэтгэлцэж байгаа хүн хохирлоо нөхөн төлсөн ч тэнсэх журмыг хэрэглэхгүй. Жишээ нь зам тээврийн ослын улмаас хүний амь нас үрэгдсэн хэрэгт ихэнх жолооч нар буруугаа хүлээдэггүй, гэм буруугийн талаар мэтгэлцдэг ба төрийн энэрэнгүй ёсны илрэл болсон тэнсэх зохицуулалтыг зөвхөн гэм буруугаа хүлээсэн этгээд хохирлоо нөхөн төлсөн буюу хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн тохиолдолд хөнгөлөлт эдлэхээр хууль тогтоогч тогтоожээ.**

Тав. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шүүхэд шилжсэн хэргийг нэг удаагийн шүүх хуралдаанаар гэм буруутай эсэх болон оногдуулах ял шийтгэлийн төрөл, хэмжээний талаар хамтатган хэлэлцэж шийдвэр гаргадаг байсан. Энэ нь шүүх хурлын өмнө гэм буруугаа хүлээн зөвшөөрөхгүй мэтгэлцэж байгаа шүүгдэгч талыг "хохирлоо төлөх үү болих уу" гэсэн эргэлзээнд хүргэж, улмаар хохирол төлөхгүй шүүх хуралдаанд оролцсоноор шүүхээс шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож хорих ял оноож шууд цагдан хорьсоноор тэнсэгдэх боломжоо алдах тохиолдол цөөнгүй гарсан.

Тэгвэл 2017 онд батлагдсан "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуулиар анхан шатны шүүх хуралдааныг гэм бурууг тогтоох болон ял оногдуулах хурал гэсэн 2үе шатанд хуваасанаар шүүгдэгч нь гэм бурууг тогтоох шүүх хурлын дараа ажлын 5 хоног хүртэл завсарлага авах эрхтэй болж энэ хугацаанд хохирлоо төлөх бололцоогоор хангагдаж дараа нь ял оногдуулах шүүх хуралд оролцож, улмаар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэгдэх боломжтой болсон нь олон улсын жишигт нийцэж байна.

Зургаа. 2002 оны Эрүүгийн хуулиар тэнсэгдсэн ялтанд шүүхээс үүрэг ногдуулдаггүй байсан нь учир дутагдалтай байсан бөгөөд шинэ Эрүүгийн хуулиар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэхийн хамт үүрэг ногдуулах болон эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг давхар хэрэглэхээр хуульчилсан.

---

[92] Төрийн мэдээлэл сэтгүүл. УБ., 2002 он, №5. Эрүүгийн хууль.

[93] ЭХТА-д хорих ялын дээд хэмжээг 5 жил түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ. ЭХЕА-н 2.6 дугаар зүйл.

Тэнсэгдсэн этгээд шүүхээс оногдуулсан үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг зөрчвөл шүүх прокурорын саналаар тэнссэн шийдвэрийг цуцлаж хорих ял оногдуулна. Өөрөөр хэлбэл тэнсэх нь дангаараа албадлагын арга хэмжээ болохгүй учраас Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлд заасан үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээтэй хамт оногдуулна.

Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлд заасан 5 төрлийн үүргээс дангаар нь сонгох болон давхардуулан оногдуулах эрхийг шүүхэд олгожээ. Үүрэг хүлээлгэх арга хэмжээний төрлүүдийг дурьдвал:

- гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах;
- зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах;
- нийтэд тустай тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх
- оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх зэрэг болно.

Түүнчлэн шүүхээс тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтуурулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох гэсэн 4 төрлийн эрхийн хязгаарлалтыг хэрэглэх эрхтэй.

Шүүхээс авсан дээрх арга хэмжээнд хяналт тавих, зөрчсөн тохиолдолд дахин шүүхээр хэлэлцүүлж ял оногдуулахаар санал гаргах арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, прокуророос хэрэгжүүлэх шаардлага бий болно.[94]

Энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд цахим гав, техникийн хяналтын арга хэрэгслүүд болон зарим тохиолдолд биечилсэн хяналт тавих арга хэмжээг шийдвэрлэх шаардлагатай.[95]

Долоо. Тэнсэх тохиолдолд шүүхээс шийтгэх тогтоол гаргана. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "..Монгол Улсын нэрийн өмнөөс гаргах шүүхийн шийдвэр нь шийтгэх, эсхүл цагаатгах хэлбэртэй байна", мөн зүйлийн 4 дэх хэсэгт "...Шүүх хуралдааны үед шүүгдэгч гэм буруутай болох нь нотлогдсон бол шүүх шийтгэх тогтоол гаргана" гэснээс үзэхэд шүүгдэгчийг хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай болохыг шүүхээс тогтоож шүүхийн шийтгэх тогтоол гаргана. Ингээд Эрүүгийн хуулийн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан болзол шаардлагыг хангасан, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн шүүгдэгчийг тэнсэх шийдвэр гаргана гэсэн үг юм.

Найм. Цагдаагийн байгууллага тэнсэгдсэн ялтанд хяналт тавина гэж 2002 оны Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлд хуульчилжээ. Судалгаагаар цагдаагийн байгууллагыг төлөөлж тэнсэгдсэн ялтанд тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа хэсгийн байцаагч нартай уулзаж ярилцахад тэдний олонх нь ажлын ачаалал ихтэйгээс хяналтыг хэлбэрийн төдий хэрэгжүүлж тэнсэгдсэн ялтныг хааяа дуудаж бүртгэдэг, заримтай нь утсаар ярьдаг, зарим нь сүүлийн 2-3 сарын хугацаанд ялтантай уулзаагүй, хаана юу хийж яваг нь мэдэхгүй байдалтай байна.

Өмнө нь тэнсэгдсэн ялтанд хяналт тавих харилцааг Улсын ерөнхий прокурор, ЦЕГ-ын даргын хамтарсан 2016.01.18-ны А/05, А/09 тушаалын хавсралтаар батлагдсан "Тэнсэгдсэн этгээдэд хяналт тавих журам"-аар зохицуулж байсан бол шинэ Эрүүгийн хууль батлагдсанаар энэ журам хүчингүй болсон бөгөөд шинэ Эрүүгийн хуулиар тэнсэгдсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавих болсоноор хяналт сайжрах байх гэсэн хүлээлттэй байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 20 дугаар бүлэгт **"Албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх" ажиллагааны талаар хуульчилсан бөгөөд шийдвэр гүйцэтгэгч тэнсэгдсэн ялтанд хувийн хэрэг нээж тодорхой хяналтын ажиллагаа явуулахаар хуульчилсан боловч өндөр хөгжилтэй орнуудын** Пробацийн албанаас явуулдаг бодитой, үр дүнтэй хяналтын хэлбэрүүдийг хуульд тусгаж чадаагүй л байна.

2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 186 дугаар зүйлд "...**Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон шийдвэрийг биелүүлэх" талаарх харилцааг зохицуулсан.**

Тухайлбал, Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон ялтны бүртгэлийг түүний оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, нэгдсэн тоо бүртгэлийг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлнө.

Гадаадын эрх зүй хөгжсөн орнуудын туршлагаас харж байхад "Пробацийн алба" нэртэй төрийн тусгай алба тэнсэгдсэн этгээдэд хяналт тавьдаг бөгөөд хяналтын үйл ажиллагааны хэлбэр нь манайх шиг зөвхөн бүртгэл хийж идэвхигүй хяналт тавьж оромдох бус ажиглалт хийх, гэр орон, ажлын байранд нь очиж уулзах, архидан согтуурах, мансуурах донтой этгээдийг сар бүр тестерээр шалгах, гэнэтийн шалгалт хийх, хөршүүдээс нь лавлагаа, камер, GPS зэрэг техникийн дэвшлийг ашиглаж хяналтыг явуулдаг байна.

Хэрэв тэнсэгдсэн этгээд шүүхээс оногдуулсан үүргийг зөрчсөн бол пробацийн албанаас зөрчлийн шинж байдлаас хамаарч шүүхэд хандаж тэнссэн шийдвэрийг хүчингүй болгох, эсвэл хуульд заасан ялыг оногдуулах санал гаргах эрхтэйгээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Манай улсад хорих ялыг тэнссэн ялтны 13 хувь нь тэнссэн хугацаанд дахин гэмт хэрэг үйлдсэн байхад АНУ, Их Британи, ХБНГУ, Франц зэрэг улсад тэнсэгдсэн этгээдийн 2-3 хувь нь дахин гэмт хэрэгт холбогдсон нь дээрх орнуудын "Пробацийн алба" тэнсэгдсэн этгээдэд тавих хяналтыг илүү бодитой хэрэгжүүлдэг байх нь.

Дэвшүүлэх санал:

Нэг. Шинэ Эрүүгийн хуульд зөвхөн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн этгээдэд "хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх" журмыг хэрэглэх болсон.

---

[94] Г.Оюунболд. Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай. Шүүх эрх мэдэл сэтгүүл. 2016 он, №01. 131 дэх тал

[95] Мөн тэнд үзэх

2002 оны Эрүүгийн хуульд дээрх шаардлага тавигддаггүй байсан учир шүүгдэгч гэм буруугийн талаар мэтгэлцээд гэм буруугаа хүлээн зөвшөөрөөгүй байсан ч шүүхээс хохирлоо нөхөн төлсөн, анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн бол оногдуулсан хорих ялыг тэнсдэг байсан жишиг уламжлалыг хадгалах нь зүйтэй болов уу.

Хоёр. Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгчид оногдуулах ялыг тэнсэх тухай зохицуулалт нь хамрах хүрээ, ач холбогдол багатай учир 8 жил хүртэл хорих ялтай хэргийг шүүгч дангаараа хянан шийдвэрлэх болсон жишгийг харгалзан 8 жил хүртэл хорих ялтай гэмт хэрэгт ял тэнсэх боломжийг нээж өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Гурав. Тэнсэгдсэн этгээдэд Англи, АНУ-д "Пробацийн алба" гэдэг тусгай алба хяналт тавьдаг, Герман болон Францад тусгай төлөөлөгч хяналт тавьдаг жишгийг харгалзан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд Пробацийн албыг тусад нь байгуулах. Шүүхийн тоо баримтаас харахад 1 жилд 3200 орчим хүн тэнсэгдэж байгаа, хугацаа нь 1-5 жил гэж бодоход пробацийн албаны хяналтанд 5000 орчим хүн байх нь тодорхой учраас ач холбогдол өгөх шаардлагатай.

Дөрөв. Тэнсэгдсэн этгээдэд тавих хяналтыг боловсронгуй болгохын тулд тухайн этгээдийн зан үйлд хяналт тавих ажиллагааг боловсронгуй болгож Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ёстой. Тухайлбал, дээр дурьдсанаар АНУ, Их Британи зэрэг улсад пробацийн алба нь тэнсэгдсэн этгээдийг ажлын байранд зуучлах, эрх зүйн албан бус сургалтанд хамруулах, ажлын газар болон гэрт нь гэнэт очиж шалгах, ажиглалт хийх, сар бүр мансууруулах бодис, архидан согтуурсан эсэхийг шалгах тестер хийх, хөршийн хяналт, камер, GPS зэрэг техникийн дэвшлийг ашиглах зэрэг олон ажиллагаа явуулдаг туршлагыг нэвтрүүлж хяналтыг хэлбэрийн төдий бус бодит ажил болгоход анхаарах шаардлагатай.

Тав. Тэнсэх институтыг зөвхөн хорих ялаар хязгаарлахгүй цаашид зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ялын төрлүүд дээр ч хэрэглэх боломжийг судлаж Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь олон улсын жишигт нийцнэ гэж судлаачийн зүгээс үзэж байна.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН АКТЫН СИСТЕМЧЛЭЛИЙН ТАЛААР СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Д.Эрдэнэбаатар
Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн захирал,
цагдаагийн хурандаа

Хураангуй: Энэ өгүүллээр эрх зүйн актын системчлэл, захиргааны дотогш чиглэсэн үйл ажиллагааг зохицуулсан дотоод эрх зүйн актыг системчлэх техникийн талаар судлагдсан байдлын тойм судалгаа хийсэн тухай танилцуулна.

Түлхүүр үг: Бүтээлийн тойм, эрх зүйн актын системчлэл, кодификаци, цагдаагийн байгууллага, үйл ажиллагааны журам

Оршил

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд захиргааны үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэх ажлыг эхлүүлж, үүний үр дүнд өнөөдөр захиргааны эрх зүйн салбарт хамаарах 250 гаруй хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж буйн дотор "Цагдаагийн байгууллагын тухай" (1993), улмаар "Цагдаагийн албаны тухай" (2013), "Цагдаагийн албаны тухай" (Шинэчилсэн найруулга) (2017) хуулиуд батлагдсанаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндэс бүрдэж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлд бодит ахиц гарсаар байна.

2008 оны байдлаар цагдаагийн төв байгууллагын дарга дангаараа болон төрийн захиргааны бусад байгууллагын даргатай хамтран баталж мөрдүүлсэн, хэм хэмжээ тогтоосон 450 орчим эрх зүйн акт (журам) үйлчилж байсан бөгөөд эдгээр нь хууль зүйн техникийн хувьд төгс бус, эрх зүйн хийдэл, давхардал, зөрчил агуулсан, хэрэгжүүлэх механизм нь хангалтгүй, эх сурвалж нь тодорхой бус, зарим тохиолдолд хүчинтэй эсэх нь эргэлзээтэй зэргээс үүдэлтэйгээр цагдаагийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөөр байв. Үүний зэрэгцээ цагдаагийн байгууллага, алба хаагчдад эрх олгож, үүрэг хүлээлгэсэн 90 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж, энэ эрх, үүргийг хэрэгжүүлэх бүтцийн нэгж, ажилтан томилогдоогүй, эдгээр харилцааг зохицуулах дүрэм, журам, зааврыг боловсруулаагүй явж ирсэн нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байв.

Түүнчлэн эрх зүйн актуудыг янз бүрийн цаг хугацаанд, өөр өөр байгууллага, албан тушаалтан батлан гаргасан, нэмэлт, өөрчлөлт оруулсан нь тодорхой бус, мэдээлэл дутмаг, олон жилийн туршид мөрдөж ирсэн зарим дүрэм, журам, заавар илтэд хуучирч шинэ тутам бий болсон эрх зүйн харилцааг зохицуулж чадахгүй болсон зэрэг нэн даруй шийдвэрлэвэл зохих тулгамдсан олон асуудал нь цагдаагийн байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн эрх зүйн актуудыг системчлэх, нэгдсэн стандартыг бий болгож мөрдүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгов.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж цагдаагийн байгууллагын олон талт үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хэлбэрэлтгүй явуулах үүднээс "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам" (ЦБҮАЖ) (2011) гэх системчилсэн нэгдмэл актыг тодорхой судалгаануудад түшиглэн, гадаадын зарим орны жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлж эхлээд цөөн жил болж байна.

ЦБҮАЖ хэрэгжсэн цөөн жилийн практикт судлаачийн хувьд дүн шинжилгээ хийж үзэхэд системчилсэн зарим журмын онолын үндэслэл бүрхэг, үзэл баримтлал нь тодорхой бус, боловсруулалт нь дутмаг байгаагаас үүдэн эрх зүйн зохицуулалтад зарим нэгэн сул талууд ажиглагдах болсон. Өөрөөр хэлбэл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, түүний системчлэлийг улам боловсронгуй болгохын тулд түүнийг захиргааны эрх зүйн шинжлэх ухааны өнцөгөөс танин мэдэх, үзэл баримтлалыг нь тодорхойлох, онолын ойлголт, ухагдахуунуудыг тайлбарлах, эрх зүйн зарим нэгэн шинэ санааг дэвшүүлэх, практикт дүн шинжилгээ хийх замаар зөрчил, хийдлийг нь арилгах, алдааг нь залруулах шаардлага үүсэжд байна.

Судлагдсан байдлын тойм судалгааг хийхдээ дээр тодорхойлсон асуултуудад хариулт олоход туслахуйц эрдэмтэн, судлаачдын хуримтлуулсан мэдлэг, мэдээллийг олж задлан шинжлэх, тэднээс суралцах, цаашид өөрсдийн судалгааны шинжлэх ухааны ач холбогдлыг таниулах, судалгаануудын үр дүнг энэхүү мэдлэгийн хөгжлийн орчинд зохицуулан нэгтгэж логик уялдаагаар холбох арга замыг эрэлхийлэхийг зорилго болголоо.

Судалгааны асуултад хариулт эрж олсноор цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээний актуудыг системчлэх онол, арга зүйн үндсийг тодорхойлох нь бидний судалгааны зорилго бөгөөд энэ талаарх танин мэдэхүйн өнөөгийн байдал, түүний талаарх мэдлэг хуримтлуулах болон энэ талаар судалсан судлаачдын судалгаатай хэрхэн холбогдох, тэдгээр судалгааны үргэлжлэл болгох, улмаар судалгааны шинэлэг талыг харуулахыг зорьж байгаа тул контекст болон нэгдмэл тойм хийх судалгааны хэлбэрийг сонгосон болно[96].

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, түүний системчлэлийн талаарх мэдлэгийн түүхэн хөгжил, өнөөгийн байдал зэргийн талаар мэдээлэл олж авахын тулд 1) эрх зүйн ерөнхий онол болон эрх зүйн салбаруудын хүрээнд; 2) байгууллагын зохион байгуулалтын удирдлагын үйл ажиллагааг зохицуулж байгаагийнх нь хувьд үр нөлөөтэй удирдлага, зохион байгуулалтын талаарх онолын хүрээнд; тус тус судалсан

[96] Баатартогтох Ц. Нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй. УБ.,2012. 34 дэх тал.

эрдэмтдийн а) эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлүүд; б) хууль зүйн шинжлэх ухааны ном, сурах бичиг, гарын авлага; в) эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, нийтлэл; г) баримт бичиг, хууль тогтоомж, эрх зүйн актын эмхтгэл; д) судалгааны тайлангуудыг судлаж эрэн сурвалжлав. Судлах бүтээлийн эрэмбэ, жагсаалтыг гаргахад эрх зүйн системчлэлийн дагуу хийгдсэн гарын авлагыг ашиглалаа[97].

Бүтээлийн тойм судалгаа

Эрх зүйн дэд акт болохынх нь хувьд:

Судалгааны энэ сэдэв захиргааны эрх зүй, цагдаагийн эрх зүй, харьцуулсан эрх зүй, эрх зүйн онол, эрх зүйн түүх, эрх зүйн философи, криминологи, криминалистик зэрэг мэдлэгийн салбарын уулзварт оршиж буй харилцан шүтэлцээ бүхий хэд хэдэн асуудлыг хөндөж байгаа бөгөөд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь цагдаагийн эрх зүйн эх сурвалж болохын хувьд түүний ойлголт, мөн чанар, үүсэл хөгжлийн үйл явцыг, хууль зүйн техник талаас нь түүнийг бүтээх ажиллагаа, системчлэлийн асуудлыг, түүнчлэн тоо бүртгэл, тогтолцоо, төрийн байгууллагын засаглалын үйл ажиллагааны элемент гэдэг утгаар нь гадаад, дотоодын цөөн бус эрдэмтэн, мэргэжилтэнүүд судалсан байдаг.

Доктор (Ph.D) Б.Чимид[98] хууль зүйн дэд эрдэмтний зэрэг горилсон "БНМАУ-ын Захиргааны эрх зүйн ерөнхий ангийн үндсэн асуудал" бүтээл (1973)-дээ төрийн захиргааны байгууллагаас батлан гаргах эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актын, академич Ж.Амарсанаа[99] "Эрх зүйн хэм хэмжээ тогтоох процессийн асуудлууд" сэдвээр хууль зүйн дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээлдээ хууль тогтоомжийн хэл, хууль зүйн нэр томьёоны асуудлыг, доктор (Sc.D) Ж.Долгорсүрэн цагдан сэргийлэх байгууллагаас согтууралтай хийх захиргааны эрхийн тэмцэл, захиргааны эрх зүйн албадлагын онолын үндэслэл, Монгол Улсад хэрэглэж буй өнөөгийн байдал, түүний зохицуулалтыг тус тус судалсан байна.

Оросын судлаач Елеонский В.О.[100] хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон дотоод хэргийн байгууллагын эрх зүйн хэм хэмжээг бүтээх тухай бүтээлдээ эрх зүйн хэм хэмжээний актыг бүтээх нь дотоод хэргийн байгууллагын үйл ажиллагааны хэлбэр болох тухай, эрх бүтээх үйл ажиллагааг хууль зүйн техникийн арга зүйтэй холбон авч үзэх хандлага руу шилжих хувьсан өөрчлөгдөх процесс явагдаж байгаа гэсэн нь бидний судалж буй сэдэвтэй шууд холбогдож байна. Учир нь бид судалгааны таамаглал болгож цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь алба хаагчийн үүргийн гүйцэтгэл, түүний чанарт нөлөөлөх хамаарлын асуудлыг авч үзэхээр тодорхойлсон билээ.

Оросын судлаач Воронина Т.Н.[101] хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон дотоод хэргийн байгууллагын үйл ажиллагааны захиргааны эрх зүйн зохицуулалтын тогтолцоо дахь ОХУ-ын Дотоод хэргийн яамны эрх зүйн хэм хэмжээний актуудын талаарх бүтээлдээ дотоод хэргийн байгууллагын үйл ажиллагааны захиргааны эрх зүйн хэм хэмжээний актуудын ойлголт, шинж чанар ба үүрэг, төрөл, эрэмбэ, түүнийг бүтээх үйл явц, үйлчлэх хүрээ, тавигдах шаардлага зэргийн талаар авч үзэж зарим санал, дүгнэлт дэвшүүлсний дотор "сүүлийн үед эрх зүйн онолд байгууллагуудын хүрээнд гаргах эрх зүйн актын нэг төрөл болох локаль актууд буюу зөвхөн тус газар, байгууллагын хүрээнд үйлчлэх дотоодын дүрэм, журам, заавар чухал ач холбогдолтой болж байгаа" тухай дурдсан нь бидний судалж байгаа сэдэвтэй шууд холбогдож байна.

Мөн тэрээр хэм хэмжээний актад тавигдах шаардлагыг нийтлэг шаардлага, тусгай буюу нэмэлт шаардлага, зохион байгуулалт – техникийн шаардлага зэргээр ангилж, эрх зүйн хэм хэмжээг байгууллагын дотоод дүрэм, журам, зааврааp нарийвчлан зохицуулах асуудал, түүнийгээ эрх зүйн тайлбараас ялгах шинжийг онолын үндэслэлтэйгээр тодорхойлжээ.

Оросын зарим судлаачид ОХУ-ын дотоод хэргийн удирдлагын болон цагдан сэргийлэх, цагдаагийн байгууллагаас тогтоох эрх зүйн хэмжээний актыг захиргааны байгууллага, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний ойлголт, нийгмийн шилжилтийн үйл явцад тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, ангилалт, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох талаас нь судалжээ. Тухайлбал, Соловей Ю.П.[102] "ОХУ-ын цагдан сэргийлэх байгууллагын эрх зүйн зохицуулалт", Адиньяев С.И.[103] "ОХУ-ын хууль сахиулах тогтолцоон дахь цагдаагийн байгууллага" бүтээлээр хууль сахиулах тогтолцоонд цагдаагийн байгууллагын үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын байдалд дүн шинжилгээ хийсэн, түүнчлэн Числов В.И.[104] "Дотоод хэргийн байгууллагаас хүн амд үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны стандартчлалын эрх зүйн ба зохион байгуулалтын асуудлууд" бүтээлээр дотоод хэргийн байгууллагаас хүн амд үзүүлэх төрийн үүргүүдийг хооронд нь салган тодорхойлж, дотоод хэргийн байгууллагаас иргэдэд үйлчлэх үйлчилгээний жагсаалт боловсруулснаар тэдгээр үйл ажиллагаанд мөрдөх журам, заавар боловсруулах боломж нээгдэх юм гэж дүгнэжээ.

---

[97] Амарсанаа Ж. Баярсайхан.Б. Монгол Улсын Хууль зүйн шинжлэх ухааны ном зүйн бүртгэл, гарын авлага. УБ.,2014.

[98] Чимид Б. БНМАУ-ын Захиргааны эрх зүйн ерөнхий ангийн үндсэн асуудал. УБ.,1973.

[99] Амарсанаа Ж. Эрх зүй-нийгмийн харилцааг тохируулагч. УБ.,1988. 64-68 дахь тал.

[100] Елеонский В.О. "Делопроизводство в органах внутренних дел". Диссертация на соискание ученой степени доктора юридических наук. М.,1992.

[101] Воронина Т.Н. "Нормативно-правовые акты МВД России в механизме административно-правового регулирования деятельности органов внутренних дел" Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. М.2001.

[102] Соловей Ю.П. "Правовое регулирование деятельности милиции в РФ" Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. М.,1993.

[103] Адиньяев С.И. "Регламентирующая деятельность полиции и определяющая ее статус в системе правоохранительных органов" Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. М.,2013.

[104] Числов В.И. "Правовые и организационные вопросы стандартизации деятельности органов внутренних дел по оказанию услуг населению" Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. М.,2010.

Доктор (Sc.D) Н.Лүндэндорж "Jurisprudence – эрх зүй судлал, философи, онол" бүтээлдээ эрх зүйн гол шинжийг тодорхойлоод[105] эрх зүй судлалын үзэл хандлага, эрх зүйн онолууд, улс төр-эрх зүйн онолуудын талаар авч үзсэн байна. Тухайлбал, жам ёсны эрх зүйн сэтгэлгээний томоохон төлөөлөгч Лон Фуллер "эрх зүйн тогтолцооны хамгийн гол зорилгыг хүмүүсийн зан үйлийг горим журмаар удирдах үйл явдал мөн, хүмүүсийн зан үйлийг удирдах явдал нь үр нөлөөтэй байхын тулд зөв зарчмаар эмхлэгдсэн байх гэж үзсэн тухай[106], шинэ позитив онолын үндэслэгч Х.Кельзен, Л.Харт нар эрх зүйн хэм хэмжээг дээд, доод буюу анхдагч, хоёрдогч гэж эрэмбэлж, эрх бол эдгээрийн хэлбэршсэн логик тогтолцоо болох тухай, төрийн албан хаагчид нь зан үйлийн журамдаа нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг байх ёстой[107] гэж номлосон тухай өгүүлжээ.

Доктор (Sc.D) Д.Лүндээжанцан нар "Эрх зүйн философи" бүтээлдээ эрх зүй нь төрийн үйл ажиллагааг легитимчлэн хууль хяналт, албадлагын байгууллагын эрх хэмжээг тогтоодог, эрх зүйн тусламжтайгаар төрийн үйл ажиллагаа хуулийн шаардлагын хүрээнд орж хууль зүйн шинж чанартай болдог гэж эрх зүйн үүрэг талаас нь авч үзсэн байна.

Доктор (Ph.D) С.Жалан-Аажав[108] хууль тогтоомжийн тоо бүртгэл, системчлэлийн талаар, доктор (Ph.D) Д.Баярсайхан[109] хууль тогтоомжийн төрөлжүүлэлтийн талаар, доктор (Ph.D) Ч.Нямсүрэн[110] хууль зүйн техникийн ойлголт, төрөл, эрх зүйн актыг системчлэх техник, хууль тогтоомжийн тоо бүртгэл, хууль тогтоомжийн тогтолцооны асуудлыг тус тус судалж өөрсдийн бүтээлүүддээ тусгасан байна.

Ерөнхий эрх зүй судлал нь эрх зүйн бүхий л тогтолцооны нийтлэг ойлголт, зарчмыг судалдаг тул[111], харин цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь процедурын хэм хэмжээ тогтоож байгаа хэлбэр учраас энэ талаар эрх зүйн ерөнхий онолын бүтээлүүдэд хэрхэн тусгагдсныг авч үзэхэд доктор (Ph.D) Ч.Нямсүрэн "Эрх зүйн ерөнхий онол, үндсэн ойлголт, тулгамдсан асуудал" бүтээлдээ эрх зүйн хэм хэмжээнүүдийн хэрэгжих хэлбэр, холбогдох этгээдүүдээс эдгээр хэм хэмжээг биелүүлэх, хэрэглэх ажиллагааг зохицуулах шаардлагын үүднээс эрх зүйн онцгой хэм хэмжээнүүдээс бүтсэн процессийн эрх зүйн салбарууд бий болдог, үйл ажиллагааны эрх зүйн үүрэг бол хэрэглээний эрх зүйн хэрэгжилтэд туслах явдал бөгөөд үйл ажиллагааны эрх зүйн онцлог нь хэрэглээний эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн технологи, зохион байгуулалт болох талаас судалж үүнийг зохион байгуулах ажиллагааны эрх зүй гэж үзжээ.

Эрх зүйн философийн хувьд байгууллагын үйл ажиллагааны журмын талаар хууль зүйн позитивизмын үзэл баримтлалын урсгалыг үндэслэгчид тайлбарласан байна. Тухайлбал, О.Конт, Ж.Милл, Г.Спенсер нарын позитив эрх зүйн фиолософийн үзэл баримтлал нь юм үзэгдлийн мөн чанар нь танигдашгүй тул шинжлэх ухааны танин мэдэхүй нь туршлагын аргад үндэслэн үйл явц, юм үзэгдлийн дэс дараалыг тогтоохоор хязгаарлагдах ёстой гэж үзсэн.

Тэд эрх зүйн онолын зорилгыг "эрх зүйн хэм хэмжээг энгийнээр системчлэн тэдгээрт хэлбэр логикийн дүн шинжилгээ хийх" гэж үзжээ. Мөн позитивист үзэл баримтлал баримтлагчид эрх зүйн хэм хэмжээ нь хөдлөшгүй зүйл, хуульчдын зорилго бол хууль зүйн олон акт, түүнд агуулагдаж буй хэм хэмжээг системчлэх, хийсвэр ойлголтын тогтолцоог бүрдүүлэхэд оршино гэж үзжээ[112].

Австрийн хуульч, философич, эрх зүйн позитивизмын онолын төлөөлөгч Ханс Кельзены "Хэм хэмжээний тухай ерөнхий онол[113]" бүтээлээр хүмүүний зан үйлийн нөхцөл байдал ба үр нөлөө нь хэм хэмжээний агуулга болох, өөрөөр хэлбэл, хэм хэмжээний зүйл нь хүмүүний зан үйл мөн гэж үзээд энэ нь хүмүүний зан үйлийг хэм хэмжээгээр үүрэг болгон тогтоож байна гэсэн үг хэмээн тайлбарлажээ.

Тэр эрх зүйн хэм хэмжээ нь нь тодорхой нөхцөл байдалд хүмүүсийн биеэ авч явах хэм хэмжээг тогтоодог тул хэм хэмжээ нь өөрөө хүний зан үйлийн нөхцөл байдал болдог, зан үйлийнхээ үр дагавар нь ч болдог гээд хэм хэмжээний нэгэн онцгой хэлбэр нь тодорхой зан үйлийг захирамжлах буюу журамлах хэлбэр байдаг гэжээ. Аливаа зүйлийн бодит байдлын тухай мэдээлэхийн тулд тайлбарладаг бол харин аливаа зүйлийг ямар байх ёстойг илэрхийлэхийн тулд журам тогтоодог гэсэн нь бидний судалгааны сэдвийн онолын тайлбар юм. Учир нь хуулиар тогтоосон цагдаагийн алба хаагчийн үүрэг нь хэм хэмжээний нөхцөл байдал буюу болзол, түүнийг зөрчвөл хүлээлгэх хариуцлагыг тогтоосон хэм хэмжээ нь мөн л нөхцөл байдал буюу үр дагавар юм бол хүлээсэн үүргээ биелүүлэх зан үйлийг хэрхэн үйлдэх, гүйцэтгэл нь ямар байх ёстойг илэрхийлсэн эрх зүйн хэм хэмжээг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам гэж тайлбарлаж болно.

Жишгийн эрх зүйн онолчид бидний судалж буй сэдвийн талаар хэрхэн авч үздэг талаар судлах зорилгоор эх хэл дээрээ орчуулагдсан бүтээл болох АНУ-ын Үндсэн хууль судлаач, философич, хуульч Рональд Майлес Дворкины Хуулийн эзэнт гүрэн[114] бүтээлийг судалж үзэхэд тэрээр эрх зүйн семантик онолууд гэх нэрийн дор бусад эрх зүйн онол, үзэл баримтлалыг авч үзэж өөрийн дэвшүүлсэн онолтой харьцуулсан бөгөөд дээр дурьдсан хандлагыг позитивист онол болон түүний өөрийн боловсруулсан цэвэр эрх зүйн онол харилцан дэмждэг гэжээ.

Хөдөлмөрийн эрх зүйн судлаачид аливаа байгууллага хөдөлмөрийн сахилгын хүрээнд ажилтан болон ажил олгогчийн гүйцэтгэх үүрэг, хэрэгжүүлэх журам буюу хөдөлмөрийн дотоод журамтай байх, үүргээ сахин

---

[105] Лүндэндорж Н. Jurisprudence – эрх зүй судлал, философи, онол. УБ., 2011. 17 дахь тал.
[106] Лүндэндорж Н. Дурьдсан бүтээл. 58-61 дэх тал.
[107] Мөн тэнд. 71-76 дахь тал.
[108] Жалан-Аажав С. Төр эрх зүйн онол. Лекцүүд. УБ., 2000. 160 дахь тал.
[109] Баярсайхан Д. Эрх зүйн онол. УБ.:Экимто, 2010. 3 дахь хэвлэлт.
[110] Нямсүрэн Ч. Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2010. 223-244 дэх тал.
[111] Лүндэндорж Н. Дурьдсан бүтээл. 10 дахь тал.
[112] Лүндээжанцан Д. Жалбажав Н. Сэлэнгэ Х. Отгонтуяа Д. Эрх зүйн философи. УБ.,2014. 264-268 дахь тал.
[113] Ханс Кельзен. Хэм хэмжээний тухай ерөнхий онол. М.,1979. Орчуулга. /ред.Амарсанаа Ж. Сарантуяа Ц. орч.Хатанбаатар.УБ.,2013.
[114] Рональд Дворкин. Хуулийн эзэнт гүрэн. Harvard University Press. /Орч. Очирсүх Я. УБ.: ХЗҮХ, 2015.

биелүүлээгүй бол хүлээлгэх сахилгын арга хэмжээ зэргийг тодорхойлсон эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц гэж тайлбарласан байдаг.

Тухайлбал, доктор (Sc.D) Л.Баасангийн "Монгол Улсын хөдөлмөрийн эрх зүй"[115], "Монгол Улсын хөдөлмөрийн эрх зүй (тусгай анги)"[116], доктор (Ph.D) Б.Уранцэцэгийн "Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуулийн онол, арга зүйн тайлбар"[117] бүтээлүүдийг дурьдаж болно.

Эдгээр судлаачид ажилтны үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын талаар зөвхөн хамтын хөдөлмөрийн процесст оролцогчдын хувьд хамаатай гэж тайлбарласан боловч дотоод журамд тавигдах шаардлага буюу ажилтнуудын оролцоог хангах, хуулиар зохицуулаагүй үлдсэн харилцааг нэгдсэн журамд оруулах, процессын шинжтэй байх зэрэг хууль зүйн шаардлага зэргийг нэг мөр тодорхойлон өгчээ.

Доктор (Sc.D) Ж.Долгорсүрэн[118], доктор (Ph.D) Д.Дашцэдэн[119], Доктор (Sc.D) О.Амархүү[120], доктор (Ph.D) Ш.Цогтоо[121], доктор (Ph.D) П.Одгэрэл[122] нарын эрдэмтэд Захиргааны эрх зүйн ерөнхий ба тусгай ангийн, А.Думбурай[123], Ж.Долгорсүрэн[124] нар цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаа, цагдаагийн эрх зүйн, доктор (Ph.D) Б.Чимид нар хамтын бүтээлээр[125] болон Ж.Долгорсүрэн[126], доктор (Ph.D) А.Эрдэнэцогт[127] нар захиргааны процессын эрх зүй, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар бүтээлүүд туурвисан байгаагаас заримыг онцолбол, проф. Б.Чимид нь П.Одгэрэлийн "Захиргааны эрх зүйн ерөнхий анги" бүтээлийг урьд өмнө нийтлэгдсэн ном зохиолоос бүтцийн төдийгүй агуулгын хувьд тод ялгаатай, бидний урьд өмнө нийтлүүлж ирсэн сурах бичиг сэлтийг тойруулж мөлжсөн байдлаас тасарч ром-германы эрх зүйн бүлийн үзэл онолыг түшиглэн боловсруулсан бүтээл гэж дүгнэсэн байна[128].

П.Одгэрэл энэхүү бүтээлээрээ захиргааны дотоод журмыг хэдийгээр гадагш чиглэсэн нөлөөлөл нь шууд бус байдаг боловч захиргааны эрх зүйн эх сурвалж мөн болох тодорхой үндэслэлүүдийг манай улсад анх удаа гаргаж тавьсан байна[129].

Мөн бидний судалж буй сэдэвтэй шууд хамааралтай бөгөөд онцлон дурдвал зохих бүтээл бол доктор (Ph.D) Ш.Цогтоогийн "Захиргааны эрх зүйн тусгай анги" болон доктор (Sc.D) Ж.Долгорсүрэнгийн "Монгол Улсын цагдаагийн эрх зүй" болон "Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс" бүтээлүүд бөгөөд Ш.Цогтоо урьд нь захиргааны эрх зүйн ерөнхий ангийн хүрээнд авч үздэг байсан салбарын удирдлагын асуудал нь захиргааны эрх зүйн тусгай ангийн судлагдахуун мөн гэсэн онол практикийн үндэслэлийг тавьсан төдийгүй, гүйцэтгэх эрх мэдэл буюу салбарын удирдлагын зохион байгуулалтын хэлбэр болох захиргаа – улс төрийн салбарын удирдлагын зохион байгуулалт – эрх зүйн үндэс гэсэн хэлбэрт дотоод хэргийн салбарын удирдлагын харьяалалд цагдаагийн байгууллагын чиг үүргийг авч үзсэн нь бүтээл туурвих цаг үеийн засгийн газрын зохион байгуулалтын бүтцийн дагуу салбарын удирдлагын зохион байгуулалтыг тодорхойлдог байснаас огт өөрөөр, бүтээгчийн өөрийнх нь бичсэнээр орчин үеийн чиг хандлага, цаашдын төлөв байдал, онол арга зүйн үндэслэлийг тусгаж өгсөн бүтээл болжээ.

Мөн Ж.Долгорсүрэн, Д.Булган нарын хамтын бүтээл Монгол Улсын Цагдаагийн эрх зүйн курс бүтээлээр цагдаагийн захиргааны үйл ажиллагаанд байнгын хэрэглэгддэг эрх зүйн актад цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам багтдаг тухай дурдаад цагдаагийн эрх зүйн эх сурвалжид хамааруулж үзжээ[130].

Эрх зүйн актын системчлэлийн хүрээнд:

Манай улсад эрх зүйн шинжлэх ухааны бие даан хөгжих суурь тавигдаж эхэлсэн 1960-аад оны[131] бүтээл болох Б.Жамьянгийн "БНМАУ-д эрхийн хэм хэмжээ тогтоосон актуудыг ангилах ба эмхлэн цэгцлэх тухай зарим асуудалд[132]" бүтээлд эрхийн хэм хэмжээ тогтоосон актуудыг ангилан системчлэх, түүний ойлголт, системчлэлийн хэлбэрүүд, индекс буюу таних тэмдэг, эрхийн хэм хэмжээ тогтоосон актуудад шинжлэл судалгаа хийх ба эмхлэн цэгцлэх аргууд болох кодификаци, инкорпораци, консолидаци, классификаци хийх, эрхийн актуудаар хийх лавлагааны чанартай аппарат, хэрэгслийг бий болгох, эрхийн актуудын төсөл боловсруулах техник ажиллагаа зэрэг асуудлыг онол, практикийн үүднээс авч судалсан анхны бүтээл болжээ.

Энэ бүтээлд байгууллагын дотоодод үйлчлэх, хэм хэмжээ тогтоосон байнга үйлчлэх шинжтэй эрх зүйн хэм хэмжээний актын талаар тухайлан авч үзээгүй боловч эрх зүйн актуудыг системчлэх арга хэлбэрийн талаар тусгайлан судалсан бүтээл болсон байна.

---

[115] Баасан Л. Монгол Улсын хөдөлмөрийн эрх зүй. /Отгонтэнгэр их сургууль. 3 дахь хэвлэл. УБ., 2010.
[116] Баасан Л. Монгол Улсын хөдөлмөрийн эрх зүй (тусгай анги). 2 дахь хэвлэл. УБ., 2000.
[117] Уранцэцэг Б. Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль (онол, арга зүйн тайлбар). УБ., 2001.
[118] Долгорсүрэн Ж. Монгол Улсын захиргааны эрх зүй. УБ., 2000.
[119] Дашцэдэн Д. Монгол Улсын захиргааны эрх зүй 1,2 дэвтэр, УБ.: Их засаг их сургууль, 2002, 2003.
[120] Амархүү О. Төрийн захиргааны дээд байгууллага. УБ.,1986.
[121] Цогтоо Ш. Нийтийн захиргааны удирдлага – эрх зүйн онол, практик, УБ., 2012., Захиргааны эрх зүй (тусгай анги) УБ., 2015.
[122] Одгэрэл П. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. 3 дахь хэвлэлт. УБ., 2016.
[123] Думбурай А. БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын захиргааны үйл ажиллагаа. УБ.,1979.
[124] Долгорсүрэн Ж. БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын захиргааны үйл ажиллагаа. УБ.,1990.
[125] Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн. /ред. Чимид Б. УБ.: Хууль зүйн үндэсний төв, 2004.; Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. /ред. Чимид Б. УБ., 2009.
[126] Долгорсүрэн Ж. Монгол Улсын захиргааны процессын эрх зүй. УБ., 2001.
[127] Эрдэнэцогт А. Монгол Улсын захиргааны процессын эрх зүй. 2 дахь хэвлэлт. УБ., 2014.
[128] Одгэрэл П. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. 3 дахь хэвлэлт. УБ.,2016. 3 дахь тал.
[129] Мөн тэнд. 65 дахь тал.
[130] Долгорсүрэн Ж., Булган Д. Монгол Улсын Цагдаагийн эрх зүйн курс. УБ.,2014. 17-18 дахь тал.
[131] Ганболд Б. Эрх зүй судлал. УБ., 2011. 19 дэх тал.
[132] Жамьян Б. БНМАУ-д эрхийн хэм хэмжээ тогтоосон актуудыг ангилах ба эмхлэн цэгцлэх тухай зарим асуудалд. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хуулийн хороо. УБ.,1967.

О.Амархүү[133], Д.Лүндээжанцан[134] нар хууль зүйн техник, түүн дотроо хууль тогтоомжийн системчлэл гэсэн томьёолол, эрх зүйн актын системчлэлийн ойлголт, төрөл, арга хэлбэр болон манай улсад эрх зүйн актын системчлэлийн ажил 1950-аад оноос эхэлсэн түүх болон энэ ажил өнөөгийн нөхцөлд нэлээд хоцрогдонгуй байгааг анхааруулж бичжээ.

ОХУ-ын эрдэмтэн Кашанина Т.В[135] эрх зүйн мэдлэгийн салбар болох хууль зүйн техникийн салбар нь эрх зүйн онолын нэг хэсэг болж хөгжиж ирсэн боловч орчин үед практик зорилтыг шийдвэрлэхэд чиглэсэн хууль зүйн шинжлэх ухааны бие даасан салбар болж байгааг батлаад хууль зүйн арга хэрэгслээ эзэмшээгүй хуульч бол жирийн иргэнээс ялгах үнэлэмжгүй болох тул үүний ач холбогдлыг ойлгож мэдрэх шаардлага байгааг тодорхойлсон төдийгүй хууль зүйн техникийн хичээлийг Москвагийн хууль зүй академи, ОХУ-ын шүүхийн академид арваад жил туршаад амжилттай болсон тул бакалавр, магистрын сургалтад заавал үзэх хичээл болгож Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд "Хууль боловсруулах техник", Эрх зүйн туслалцааны хүрээнд "Хувийн эрх зүй дэх хууль зүйн техник", Эрх зүйн хамгаллын хүрээнд "Шүүхийн актын хууль зүйн техник" гэх мэтээр нарийвчлан судлах болжээ.

Тэр ийнхүү хууль зүйн техникийн ач холбогдлыг судлаачдад ойлгуулахаас гадна дурдсан бүтээлээрээ хууль зүйн техникийн ухаан нь ерөнхий ба тусгай ангитай, ерөнхий ангид хууль зүйн техникийн төр эрх зүйн онолын бүтцэд эзлэх байр суурь, үзэл санааны хөгжил, судлагдахуун, судалгааны арга зүй, ойлголт, төрөл, хууль зүйн техникийн ерөнхий дүрэм, түүний ач холбогдлын талаар, тусгай анги эрх зүйг бүтээх техник, хэвлэн нийтлэх техник, системчлэх техник, тайлбарлах техник, хэрэгжүүлэх техник, эрх зүйн хэрэглээний техникийг тус тус авч үзсэн байна. Судалж байгаа сэдвийн хүрээнд авч үзвэл хууль зүйн техникийн тусгай ангийн эрх зүйг бүтээх техникийн хүрээнд байгууллагын (корпоратив) эрх зүйн хэм хэмжээний актын ойлголт, шинж, зарчим, философийн үндэс, онцлог болон эрх зүйн актыг системчлэх, системчлэлийн ойлголт, обьект, зүйл, субьект, үе шат, шалтгаан, ач холбогдол, зарчим, төрлүүд, тэдгээрийн онцлогыг авч үзжээ.

Кэмбрижийн их сургуулийн эрдэмтэн Петер Штайны бүтээл "Европын түүхэн дэх Ромын эрх зүй[136]" хэмээх бүтээлээс үзэхэд гурван мянган жилийн тэртээгээс анх Грек, Ромд үүссэн Ромын эрх зүйн түүх бүхэлдээ хууль зүйн техникийн, түүн дотроо хууль зүйн системчлэлийн түүхийг өгүүлсэн гэж судлаачийн зүгээс дүгнэв.

Уг бүтээлд Ромын эрх зүйн эхлэлийг тавьсан арван хоёр хавтангийн хууль ч тэр, түүнээс хойшхи хуульчдын хийж ирсэн зүйл бол алив хууль, дүрэм, журмыг эмхэлж цэгцлэх зорилготой байсан ба хамгийн түрүүнд чулуун хавтан дээр сийлж үзэж, нийтээрээ уншиж болохуйц бичмэл хууль буюу lex-ийг гаргаснаар нийтээрээ дагаж мөрдөх хүчин чадалтай болгож, тэдгээрийг тайлбарлах, эмхэлж цэгцлэх, эрэмблэхийн тулд хуульчид гэж бий болсон, анх хуулийн гарчигуудыг эмхэлж схемчилж коджуулж хэвлүүлж байсан нь бидэнд уламжлан ирснээр, нийгмийн харилцаа хөгжихийн хэрээр шинэ шинэ зорилтуудыг, түүнийг хэрэгжүүлэх арга, хэрэгслүүдийг дэвшүүлсээр эрх зүйн өнөөгийн хөгжилд хүргэсэн тухай дурьджээ.

Түүнчлэн төрөлжүүлэн нэгтгэх хөдөлгөөн Европ даяар өрнөж хуулийг ойлгомжтой, цэгц дараалалтайгаар бичих төдийгөөс биш хуучирсан дүрэм журмыг тухайн цаг үеийн шаардлагад нийцүүлэн орчин цагийн дүрэм журмаар өөрчлөх зорилготой болсон төдийгүй бүх газар нутагтаа нэгдсэн нэг хуультай болох нь улс орноо буюу газар нутгаа нэгтгэх арга зам гэж үзэж байсныг бидний судалж байгаа сэдвийн хүрээнд авч үзвэл системчлэгдсэн үйл ажиллагааны журам нь байгууллагыг нэгдсэн удирдлага, нэгдсэн стандартад оруулах аргын үндэс гэж ойлгогдож байна.

Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаатай холбоотой гадаад орны судлаачдын бүтээлүүд цөөнгүй байгаагаас Чарлес Свансон, Леонард Террито, Роберт Тайлор нарын "Цагдаагийн захиргааны үйл ажиллагаа: бүтэц, үйл явц, зан үйл"[137], П.Ж.Ортмаер, Жозеп Давис нарын "Цагдаагийн захиргааны үйл ажиллагаа: манлайллын хандлага"[138] бүтээлүүдийг дурьдаж болох бөгөөд эдгээрт цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаа, захиргааны эрх зүйн зохицуулалтын талаар бусад салбар шинжлэх ухааны хүрээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц онолын үндэслэлтэйгээр туурвижээ.

Түүнчлэн цагдаагийн талаарх үндсэн ойлголт, эрүүгийн болон хууль сахиулах тогтолцоонд эзлэх байр суурь, гарал үүслийн талаар гүнзгий ойлголт өгөхүйц бүтээл бол Роналд Акерс, Кристин Селлерс нарын "Криминологийн онолууд – удиртгал, хөгжил, хэрэглээ"[139], Фреда Адлер, Жерард Мюллер, Вильяам Лауфер нарын "Кримонологи"[140], Жоел Самаагийн[141] "Эрүүгийн тогтолцоо"[142], Самуел Валкер, Чарлес Катц нарын "Америкийн цагдаагийн удиртгал"[143] бүтээлүүдийг дурьдаж болно.

---

[133] Амархүү О. Эрх зүйн онолын арван таван сэдэв. УБ., 2008. 59-61 дэх тал.
[134] Лүндээжанцан Д. Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник. УБ.,2016. 116-132 дахь тал.
[135] Кашанина Т.В. Хууль зүйн техник. Орч.Гэрэлмаа С нар. УБ., 2016.
[136] Петер Штайн. Европын түүхэн дэх ромын эрх зүй. Кэмбрижийн их сургууль.,1999. /орч. Янжмаа Р., ред.Өнөрбаяр Ч. УБ., 2016.
[137] Chiles R.Swanson. Leonard Termite and Robert W.Taylor. Police administration: structure, processes and behavior, 8th edition, US., Saint Leo University. 2011.
[138] P.J.Ortmeier Joseph J.Davis. Police Administration: A Leadership Approach. US., Administration of Justice Grossmont College. 2010.
[139] Ronald L Akers, Christine S. Sellers, Criminological Theories – introduction, Evaluation and Application. 5th edition. US.,2009.
[140] Freda Adler. Gerhard Mueller and William Laufer., Criminology. 6th edition. US.,2007.
[141] Joel Samaha. Criminal Justice 4th edition, US.,1994.
[142] Criminal Justice System гэснийг Хууль сахиулагчийн эрх зүйн байдал, Цагдаагийн алба, мөрдөх алба, маршалын албаны тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулсан тухай тайланд Эрүүгийн тогтолцоо гэж томьёолсноор авсан болно. Хууль сахиулахын их сургууль., 2013.
[143] Samuel Walker, Charles M. Katz., The Police in America An Introduction, 5th edition, 2004.

Доктор (Ph.D) Б.Энхболд нарын "Монгол Улс дахь цагдаа судлалын өнөөгийн байдал[144]" судалгаанаас үзэхэд цагдаа судлалын хүрээнд сүүлийн 50 орчим жилийн хугацаанд буюу 1970-2015 оны хооронд нийт 242 эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл бичигдсэнээс агуулгаараа "цагдаагийн байгууллагын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, системчлэх" сэдвээр хамгийн их буюу 98 илтгэл, өгүүлэл бичигдсэн байгаа нь бидний судалж буй сэдэвтэй шууд хамааралтай мэт боловч "хууль тогтоомж" гэсэн ойлголтыг өргөн утгаар нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох бүхий л эрх зүйн актуудыг хамруулж үзсэн учраас бүгд бидний судалгааны сэдэвтэй шууд холбогдохгүй юм.

Эдгээрийн дийлэнх нь тодорхой ажиллагааны, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх талаарх, эсхүл тодорхой гэмт хэрэг илрүүлэх, эсхүл тодорхой ажлын байрны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын, эсхүл алба хаагчийн эрх зүйн байдлын асуудлыг нарийвчлан үзсэн бол цөөн хэдэн бүтээл бидний судалж буй сэдэвтэй холбоотой байлаа.

Тухайлбал, судлаач Ж.Ганбаатар Цагдаагийн байгууллагын эрх зүйн бодлого, цаашдын чиг хандлага[145] өгүүллээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь эрх зүйд захирагдах ёс (Rule of Law)-ны нэг хэсэг гэж дүгнэснээс гадна цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг боловсруулах, системчлэх хэрэгцээ, шаардлага, үндэслэл, боловсруулсан арга зүй, системчилсний ач холбогдлын талаар 2008 оноос хойш тасралтгүй бичиж иржээ.

Үүнд, "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартын ойлголт, боловсруулах арга зүйн зарим асуудал"[146], мөн "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийн системчлэл, боловсронгуй болгох асуудал"[147], "Гадаадын зарим орны цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт"[148], "Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн ажил, хөдөлмөрийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийн системчлэл, боловсронгуй болгох асуудал"[149], "Төрийн албанд стандарт-үйл ажиллагааны журмыг хөгжүүлэх нь"[150] эрдэм шинжилгээний өгүүллээрээ Монгол Улсын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх журамд нийцүүлэн цагдаагийн төв байгууллагаас гаргасан үйл ажиллагааны журам нь төрийн байгууллагууд болон цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэх чухал ач холбогдолтой эрх зүйн акт учраас тэдгээрийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд үүнийг боловсруулсан тухай болон хэм хэмжээ тогтоосон актуудын нэр томьёо үндэсний хэмжээнд жигдрээгүй, янз бүрээр нэрлэж байгааг дурджээ. Түүнчлэн цагдаагийн байгууллагын гадагш чиглэсэн болон дотогш чиглэсэн актуудыг үе шаттайгаар системчилж, тэдгээрийг бүтээх арга зүйг тогтоон хэвшүүлснээр цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, алба хаагчдын өөрсдийн хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах гол хүчин зүйл гэж үзснээрээ онцлог байна.

Мөн энэ сэдвээр судлаач Д.Эрдэнэбаатар "Гадаадын зарим орны цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандарт журмын системчлэлийн туршлага", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн актын системчлэл, түүнийг боловсронгуй болгох асуудал"[151] эрдэм шинжилгээний өгүүллүүдээр гадаад орнуудад хэрхэн үздэг, эх сурвалж нь юу болох тухай, тэдний туршлагыг эх орондоо нэвтрүүлж хэрэгжүүлэх талаар бичиж байсан бол, Ц.Чойжамц цагдаагийн эрх зүйн тогтолцоонд шинжилгээ хийж хэлбэрийн болон агуулгын системчлэлийг төгөлдөршүүлэх шаардлагатай байгаа тухай, агуулгын хувьд нэг асуудлыг тухайлан жижиглэж олон эрх зүйн баримт бичиг болгон баталгаажуулж байгаа нь хэрэгжүүлэгч субъектүүдэд хүндрэлтэй тул нэгтгэн нийлүүлж хэм хэмжээний зөрчилгүй болгож системчлэх санал дэвшүүлсэн[152] өгүүлэл хэвлүүлж байжээ.

Доктор (Sc.D) Ж.Долгорсүрэн "Цагдаагийн эрх зүйн тогтолцоог тодорхойлох нь"[153] эрдэм шинжилгээний өгүүллээр цагдаагийн эрх зүй нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд өдөр тутмын ажиллагаанд хамаардаг бөгөөд цагдаагийн эрх зүйн тогтолцооны оновчтой хувилбар боловсруулахад судлаачдыг анхаарлаа хандуулахыг, мөн "Монгол Улсын цагдаагийн эрх зүйн үүсэл хөгжлийн явцад хийсэн дүн

---

[144] Цагдаа судлалын өнөөгийн байдал" судалгааны тайлан., УБ.: ХСИС, 2017. 18 дахь тал.

[145] Ганбаатар Ж. "Цагдаагийн байгууллагын эрх зүйн бодлого, цаашдын чиг хандлага", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үүсэл, хөгжил" эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ.: Цагдаагийн ерөнхий газар, 2011. 42-49 дэх тал.

[146] Ганбаатар Ж. "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартын ойлголт, боловсруулах арга зүйн зарим асуудал". //Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2008, №1 (23). 40-48 дахь тал.

[147] Ганбаатар Ж. "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийн системчлэл, боловсронгуй болгох асуудал". //Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2010, №1 (31). 30-35 дахь тал.

[148] Ганбаатар Ж. Гадаадын зарим орны цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, //Цагдаа судлал. 2011. №1. 24-29 дэх тал.

[149] Ганбаатар Ж. "Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн ажил, хөдөлмөрийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийн системчлэл, боловсронгуй болгох асуудал" Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын гарын авлага эмхтгэл, УБ, Цагдаагийн ерөнхий газар. 4-11 дэх тал.

[150] Ганбаатар Ж., "Төрийн албанд стандарт-үйл ажиллагааны журмыг хөгжүүлэх нь", Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын менежментэд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам онол практикийн хурлын эмхтгэл. МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хууль зүйн яам, Хууль сахиулахын их сургууль. УБ., 2016, 1-11 дэх тал.

[151] Эрдэнэбаатар Д. "Гадаадын зарим орны цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандарт журмын системчлэлийн туршлага". //Цагдаа сэтгүүл. 2010 №1/105, 15-16 дугаар тал; "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн актын системчлэл, түүнийг боловсронгуй болгох асуудал" //Хууль сахиулахуй. 2015, №2, 248-254 дэх тал.

[152] Чойжамц Ц. "Цагдаагийн байгууллагын эрх зүйн бодлого, цаашдын чиг хандлагад шинжилгээ хийх нь". Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үүсэл, хөгжил эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ.,2011. 137-142 дахь тал.

[153] Долгорсүрэн Ж. "Цагдаагийн эрх зүйн тогтолцоог тодорхойлох нь" //Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үүсэл, хөгжил эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2011. 13-19 дэх тал.

шинжилгээ”[154] өгүүллээр цагдаагийн эрх зүйн түүхэн хөгжлийг олон улсын хэмжээнд болон өөрийн улсын хэмжээнд авч үзээд цаашид цагдаагийн эрх зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, шинэтгэл хийхэд бодитой хувь нэмрээ оруулахыг тус тус уриалж байсан бөгөөд цагдаагийн эрх зүйн сэдвээр судалгаа хийж, бүтээл туурвих явдал нэг хоёроос хэтрэхгүй хангалтгүй байгааг онцолж чамласантай санал нийлж байна.

Судалгааны сэдвийн хүрээнд хөндөгдөж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга зам нь төрийн бодлогын баримт бичгүүдэд мөн тусгалаа олсон байна. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого[155]”-ын 7.1 Эрх зүйн шинэтгэлийн бүх үе шатанд буюу 2007-2021 онд хэрэгжүүлэх стратегийн нэгдүгээр зорилтод төрийн институцүүдийг чадавхжуулж, төрийн үйлчилгээг ил тод, хүртээмжтэй болгох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцооны үнэт зүйл, эрх зүйн соёл, шинэ, дэвшилтэт, түгээмэл ач холбогдол бүхий зохицуулалтын аргыг судалж нэвтрүүлэх; төрийн захиргааны байгууллагаас гаргах эрх зүйн актын боловсруулалтыг шинжилгээ судалгааны үндэстэй, системтэй болгох;хууль тогтоомжийн хоорондын уялдааг сайжруулах, зүйл заалтуудын зөрчлийг арилгах, *кодчилох* ажлыг богино хугацаанд дэс дараатай хийж дуусгах; хууль тогтоомжийг чанд баримталж хэрэгжүүлдэг тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авахаар тусгасан байна.

Түүнчлэн судалгааны хүрээнд дүн шинжилгээ хийгдэх эрх зүйн зарим харилцаа, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоомжид мөн тусгасан байна. Тухайлбал, **Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн[156] 10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх хэсэгт “**Агентлагийн хэмжээнд агентлагийн даргын хууль тогтоомжид нийцүүлэн баталсан хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөнө. Хөдөлмөрийн дотоод журамд 1) агентлагийн ажлыг төлөвлөх, тайлагнах журам; 2) албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх, халах; 3) захиргаа, албан хаагчийн эрх, үүрэг; 4) зохион байгуулалтын нэгж, ажилтны үйл ажиллагааны үр дүнг тооцож, дүгнэх арга хэлбэр; 5) дотоодын хяналт, шалгалт хийх, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах; 6) дотоод журамд тусгахаар хууль тогтоомжид заасан бусад зүйл” гэсэн үндсэн зүйлүүдийг тусгахаар заасан байна.

Судалгааг эхлэх үед Максима судалгааны төвөөс 2007 онд хийсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, менежментийн үр нөлөөг сайжруулах, олон нийт болон цагдаагийн байгууллагын харилцааг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах судалгаа[157], Америкийн нэгдсэн улсын хөгжлийн агентлаг (USAID)-аас Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чадавхийн үнэлгээ[158], Цагдаагийн академиас “Монгол Улс дахь цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн төлөв байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” судалгаа[159], Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн 2008 оны цагдаагийн байгууллагад итгэх итгэл, цагдаагийн ажилтны нэр хүнд, үйл ажиллагааны талаарх үнэлгээ, байгууллагын болон ажилтны үйл ажиллагаанд илэрч буй дутагдал, байгууллагын ажилд нөлөөлж буй хүчин зүйл, цаашид сайжруулах арга замыг олон нийт хэрхэн үзэж байгааг тодруулах судалгаа[160], Соросын сангаас 1999-2005 онд хэрэгжүүлсэн Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагаа хөтөлбөрийн тайлан[161], 2008 онд Их Британи улсын Элчин сайдын яам, “Транспэрэнси Интэрнэшнл –Монгол” олон улсын байгууллагын захиалгаар Англи улсын “Ethics in Policing” төрийн бус байгууллагаас Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар хийсэн судалгаа[162], тэдгээрийн үр дүн нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээг системчилэх шаардлагатайг харуулж байсан.

Хүний эрхийг хангах үндэсий хөтөлбөрийн хороо, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс 2011 онд явуулсан “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ” тайланд “Цагдаагийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдолтой 80 гаруй хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тухай дурьдсан.

“Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл” бүтээлд дурьдсанаар 2008 оны байдлаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй 24 гол хууль, Ерөнхийлөгчийн зарлиг 7, Засгийн газрын тогтоол 33, Улсын дээд шүүхийн тогтоол 18, Төрийн албаны зөвлөлийн тогтоол 3, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал 18, Улсын ерөнхий прокурорын тушаал 1, Нийслэлийн засаг даргын захирамж 1, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал 146 мөрдөгдөж байна” гэсэн бол Цагдаагийн ерөнхий газраас хийсэн эрх зүйн орчны шинжилгээгээр[163] өдөр тутам барьж ажилладаг Цагдаагийн байгууллагын тухай, Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Захиргааны хариуцлагын тухай хууль зэрэг

---

[154] Долгорсүрэн Ж. Монгол Улсын цагдаагийн эрх зүйн үүсэл хөгжлийн явцад хийсэн дүн шинжилгээ. //Хууль сахиулахуй онол, арга зүйн сэтгүүл. 2014. №2, 8-13 дахь тал.

[155] Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол. (Энэ тогтоолыг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон)

[156] Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, //Төрийн мэдээлэл . 2004. №16 (349) дүгээрт нийтлэгдсэн.

[157] Максима судалгааны төв, цагдаагийн байгууллага, алба хаагчийн талаарх Улаанбаатар хотын иргэдийн санал бодлыг судлах судалгааны тайлан. УБ.,2007.

[158] Америкийн нэгдсэн улсын хөгжлийн агентлаг (USAID)-аас Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чадавхийн үнэлгээ хийсэн тухай тайлан. УБ.,2007.

[159] Цагдаагийн Академиас хийсэн “Монгол Улс дахь цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн төлөв байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт судалгааны тайлан. УБ., 2007.

[160] Философи, социологи, эрхийн хүрээлэн. “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдал, боловсронгуй болгох чиглэл” сэдэвт судалгааны тайлан. УБ.,2008.

[161] Нээлттэй нийгэм хүрээлэн, Унгар дахь Үндсэн хууль, эрх зүйн хүрээлэн, Эрх зүйн санаачлага нээлттэй нийгэмлэг. “Цагдаа, олон нийтийн хамтын ажиллагаа хөтөлбөрийн үр дүн, цаашдын чиг хандлага”. УБ.,2005

[162] Kevin W. Pitt Director of Ethics in Policing, Mongolian National Police Agency UK Study Visit Advisory Development Report., UK, 2008.

[163] Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн тасгийн танилцуулга, УБ., 2008. Горилогчийн хувийн архив.

хуулиудыг оруулж тооцохгүйгээр 90 гаруй хуулийн 166 зүйл, хэсэг, заалт, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой буюу гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд хамааралтай 450 дүрэм, журам, заавар үйлчилж байна гэсэн тооцоо гаргаж байжээ.

Энэ мэтээр судалгаа эхлэх үед нийт хэдэн акт хүчин төгөлдөр үйлчилж байгаа нь эргэлзээтэй, бүртгэл лавламжийн арга зүй хангалтгүй байжээ. Мөн дурьдсан тайланд "... Харин Цагдаагийн ерөнхий газрын даргын 2009 оны 528 дугаар тушаалын дагуу цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн баримт бичгийг системчлэх, үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулсанаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд багтах 9 бүлэг, 243 журмыг шинэчлэн баталж мөрдүүлээд байна. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг системчилснээр цагдаагийн байгууллага, алба хаагчийн хэрэглэх хууль тогтоомж, эрх зүйн актын нэгдсэн сан бий болж, алба хаагч бүр үйл ажиллагааныхаа эрх зүйн үндэслэлийг нэг дороос шуурхай олж авах, судлах, зөв ойлгон хэрэглэх нөхцөл бүрдэж, цагдаагийн байгууллага, албан хаагчаас хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэхэд дэвшил гарна гэж үзэж байгаа юм"[164] гэж дүгнээд цагдаагийн байгууллага, алба хаагчаас хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр баримталж хэрэгжүүлбэл зохих зарим үйл ажиллагааг гаруй журмын нэрийг кодны хамт дурьдсан байна.

БНСУ болон Монгол Улсад оршин суугаа монголчуудын цагдаад итгэх хандлагын харьцуулсан судалгаа: инструментал болон экспрессив загвараар шалгах нь[165] судалгаагаар ардчилсан орны цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн эрх чөлөө, шударга ёс, зохих ёсны процедурыг хангаж байгаа эсэхээр үнэлэх бөгөөд үүний тулд олон нийтийн итгэлийн түвшинг хэмждэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн загваруудыг ашиглаж хийжээ.

Иргэдийн итгэлийн түвшин нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны маш чухал шалгуур болохын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн загварын дагуу судалсан дүнг үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх, үйл ажиллагааныхаа журам процедурыг боловсронгуй болгоход ашигласнаар иргэдийн эрх чөлөөний хэрэгжилт, шударга ёс, зохих ёсны процедурын зарчмыг хангахад ихээхэн үр нөлөөтэй юм. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг түүний чанарыг буюу иргэдийн цагдаагийн байгууллагад үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн түвшинг зөв тодорхойлсноор үйл ажиллагаагаа үр дүнтэй зохион байгуулахын тулд бий болгосон хэм хэмжээний актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх боломжтой болох юм.

Судалгааны явцад 2013 оны Цагдаагийн албаны тухай хуулийг батлаж Цагдаагийн ерөнхий газарт Судалгааны төв, дотоод аудит хийх бүтцийн нэгж, Хууль сахиулахын их сургуульд Цагдаа судлалын төв тус тус байгуулагдсантай холбоотойгоор эдгээр байгууллага цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд цөөнгүй судалгааг хийсэн. Эдгээрээс судалгааны сэдэвтэй холбоотой заримыг дурьдвал, доктор (Sc.D) С.Жанцан нарын "Цагдаагийн алба хаагчийн ёс, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл" судалгаа[166], "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байх зарчим" судалгаа[167], "Цагдаагийн алба хаагчдын ажил, албандаа хандах өөрчлөлтийн талаар[168]", "Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дотоод хамтын ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал"-д хийсэн судалгаа[169], "Гэмт хэрэг зөрчлийн улмаас хохирсон цагдаагийн алба хаагчдын өнөөгийн байдал"[170], "Цагдаагийн алба хаагчид болон энгийн хүмүүсийн нийгмийн оюун ухаан болон дотоод баримжааг судалсан нь" судалгаа[171], "Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал" судалгаа[172] болон АТГ, ЦЕГ-ын хамтарсан "Цагдаагийн байгууллагын авилга, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй ажлын байр, албан тушаал, удирдах алба хаагчдын хандлагыг тодорхойлох" судалгаа[173], IRIM хараат бус судалгааны хүрээлэнгээс "Цагдаагийн байгууллагаас иргэдэд хүргэдэг үйлчилгээний мониторинг"[174], жил бүр цагдаагийн байгууллагын захиалгаар хийгддэг "Хэрэглэгчийн үнэлгээний судалгаанууд"[175], Хууль зүйн яамнаас хийсэн "Хүний нөөцийн томилолт, чөлөөлөлттэй холбоотой материалыг шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дотоод аудитын ажлын тайлан"[176] зэрэг судалгаанууд хийгдсэнийг бид ашигласан болно. Эдгээрээс үзэхэд

---

[164] "Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц" хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хороо, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр. УБ., 2011. 25-27 дахь тал.

[165] Enkhbold B. Comparative study of the Confidence in the Police among Mongolian Koreans and Native Mongolian: A test of instrumental and Expressive Models, dissertation for degree of doctor. Kyonggi University, Seoul, South Korea., 2015.

[166] Жанцан С нарын "Цагдаагийн алба хаагчийн ёс, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл" судалгаа. УБ.,2013.

[167] Нямдорж Ц, Жанцан С нар. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байх зарчим" судалгаа. УБ.,2013.

[168] ЦЕГ-ын Судалгааны төв. "Цагдаагийн алба хаагчдын ажил, албандаа хандах өөрчлөлтийн судалгаа". УБ., 2016.

[169] ЦЕГ-ын Судалгааны төв. "Цагдаагийн байгууллаганы гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дотоод хамтын ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал". УБ.,2016.

[170] ЦЕГ-ын Судалгааны төв. "Гэмт хэрэг зөрчлийн улмаас хохирсон цагдаагийн алба хаагчдын өнөөгийн байдал" судалгаа. УБ.,2016.

[171] ЦЕГ-ын Судалгааны төв. "Цагдаагийн алба хаагчид болон энгийн хүмүүсийн нийгмийн оюун ухаан болон дотоод баримжааг судалсан нь". УБ.,2016.

[172] ЦЕГ, ДХАБГ, СШТ. "Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал" судалгаа. УБ.,2015.

[173] АТГ, ЦЕГ-ын хамтарсан "Цагдаагийн байгууллагын авилга, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй ажлын байр, албан тушаал, удирдах алба хаагчдын хандлагыг тодорхойлох" судалгаа

[174] IRIM хараат бус судалгааны хүрээлэн., "Цагдаагийн байгууллагаас иргэдэд хүргэдэг үйлчилгээний мониторинг" УБ., 2014.

[175] ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, кримнологийн сектор. "Цагдаагийн байгууллагын 2011, 2013 оны үйл ажиллагаанд хэрэглэгчээс өгсөн үнэлгээ" судалгаа УБ.,2012, 2014. "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ" судалгаа. УБ.,2015.

[176] Хууль зүйн яам., "Хүний нөөцийн томилолт, чөлөөлөлттэй холбоотой материалыг шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дотоод аудитын ажлын тайлан" УБ.,2015.

шинээр батлагдсан хуулийг хэрэгжүүлэх талаар дотоод журам тогтоох ажлыг цаг алдалгүй хийж байх, үйл ажиллагааны журмыг удирдах болон бусад албан тушаалтануд зөрчихгүй мөрдөж байх ёстой тухай зэрэг дүгнэлт, саналууд нь бидний судалгааны ажилд ач холбогдолтой байв.

Дүгнэлт

Эцэст нь судлагдсан байдлын тоймд дараах дүгнэлт хийв: 1) Сонгож авсан сэдвийн хүрээнд, өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн нэгдмэл актын системчлэлийг, ялангуяа, түүний онол, практикын асуудлыг иж бүрнээр тусгайлан судалсан дорвитой бүтээл өнөөг хүртэл гараагүй байна; 2) Эрх зүйн актын системчлэлийг хийхэд ашигладаг кодификаци, инкорпораци, консолидаци, классификацийн аргын тухай, хууль бүтээх техникийн талаар монгол судлаачийн бүтээл 1960-аад онд туурвигдсан байх атлаа эрх зүйн хөгжил дэвшилд хөтлөгдсөн удаах он жилүүдэд энэ сэдвээр бүтээл гараагүй нь анхаарал татаж байна; 3) Гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачдын захиргааны ба цагдаагийн эрх зүй, эрх зүйн онол, эрх зүйн философи зэрэг мэдлэгийн салбарт туурвисан бүтээлүүд нь бидний судалгааны онолын үндэслэлийг, практик үйл ажиллагаанд хийсэн судалгааны материалууд нь практик судлалын үндэслэлийг хангалттай бүрдүүлж чадахуйц байна; 4) Гадаад орны судлаачдын дурьдсан бүтээлүүдээс дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцооны үнэт зүйл, эрх зүйн соёл, шинэ, дэвшилтэт, түгээмэл ач холбогдол бүхий зохицуулалтын аргыг судлаж нэвтрүүлэх замаар харьцуулсан эрх зүйн хөгжилд бодит алхам хийх боломж байна; 5) Дурьдсан болон ном зүйд тусгасан бусад бүтээлүүдэд дүн шинжилгээ, боловсруулалт, харьцуулалт хийж, тодорхой гаргалгаа, дүгнэлтүүдэд хүрсэн нь бидний судалгааны ажлыг шинэлэг байхад нөлөөлж байна.

Ашигласан эх сурвалж

- Амарсанаа Ж. Баярсайхан.Б. Монгол Улсын Хууль зүйн шинжлэх ухааны ном зүйн бүртгэл, гарын авлага. УБ.,2014.
- Амарсанаа Ж. Эрх зүй-нийгмийн харилцааг тохируулагч. УБ.,1988.
- Амархүү О. Төрийн захиргааны дээд байгууллага. УБ.,1986.
- Амархүү О. Эрх зүйн онолын арван таван сэдэв. УБ.,2008.
- Баасан Л. Монгол Улсын хөдөлмөрийн эрх зүй (тусгай анги). 2 дахь хэвлэл. УБ., 2000.
- Баасан Л. Монгол Улсын хөдөлмөрийн эрх зүй. /Отгонтэнгэр их сургууль. 3 дахь хэвлэл. УБ., 2010.
- Баатартогтох Ц. Нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй. УБ.,2012.
- Баярсайхан Д. Эрх зүйн онол. 3 дахь хэвлэлт. УБ.,2010.
- Ганбаатар Ж. "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийн системчлэл, боловсронгуй болгох асуудал". //Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2010, №1 (31).
- Ганбаатар Ж. "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартын ойлголт, боловсруулах арга зүйн зарим асуудал". //Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2008, №1 (23).
- Ганбаатар Ж. "Цагдаагийн байгууллагын эрх зүйн бодлого, цаашдын чиг хандлага", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үүсэл, хөгжил" эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ.: Цагдаагийн ерөнхий газар, 2011.
- Ганбаатар Ж. Гадаадын зарим орны цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, //"Цагдаа судлал" сэтгүүл. 2011. №1.
- Ганбаатар Ж., "Төрийн албанд стандарт-үйл ажиллагааны журмыг хөгжүүлэх нь", Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын менежментэд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам онол практикийн хурлын эмхтгэл. МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хууль зүйн яам, Хууль сахиулахын их сургууль. УБ.,2016.
- Ганболд Б. Эрх зүй судлал. УБ.,2011.
- Дашцэдэн Д. Монгол Улсын захиргааны эрх зүй 1,2 дэвтэр, УБ.: Их засаг их сургууль, 2002, 2003.
- Долгорсүрэн Ж. "Цагдаагийн эрх зүйн тогтолцоог тодорхойлох нь" //Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үүсэл, хөгжил эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ.,2011.
- Долгорсүрэн Ж. БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын захиргааны үйл ажиллагаа. УБ.,1990.
- Долгорсүрэн Ж. Монгол Улсын захиргааны процессын эрх зүй. УБ.,2001.
- Долгорсүрэн Ж. Монгол Улсын захиргааны эрх зүй. УБ.,2000.
- Долгорсүрэн Ж. Монгол Улсын цагдаагийн эрх зүйн үүсэл хөгжлийн явцад хийсэн дүн шинжилгээ. //Хууль сахиулахуй онол, арга зүйн сэтгүүл. 2014. №2.
- Долгорсүрэн Ж., Булган Д. Монгол Улсын Цагдаагийн эрх зүйн курс. УБ., 2014.
- Думбурай А. БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын захиргааны үйл ажиллагаа. УБ.,1979.
- Жалан-Аажав С. Төр эрх зүйн онол. Лекцүүд. УБ.,2000.
- Жамьян Б. БНМАУ-д эрхийн хэм хэмжээ тогтоосон актуудыг ангилах ба эмхлэн цэгцлэх тухай зарим асуудалд. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хуулийн хороо. УБ.,1967.
- Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн. /ред. Чимид Б. УБ.: Хууль зүйн үндэсний төв, 2004.; Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. /ред. Чимид Б. УБ., 2009.
- Лүндэндорж Н. Jurisprudence – эрх зүй судлал, философи, онол. УБ.,2011.
- Лүндээжанцан Д. Жалбажав Н. Сэлэнгэ Х. Отгонтуяа Д. Эрх зүйн философи. УБ.,2014.
- Лүндээжанцан Д. Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник. УБ.,2016.

- Нямсүрэн Ч. Эрх зүйн ерөнхий онол. УБ.,2010.
- Одгэрэл П. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. 3 дахь хэвлэлт. УБ.,2016.
- Одгэрэл П. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. 3 дахь хэвлэлт. УБ.,2016.
- Петер Штайн. Европын түүхэн дэх ромын эрх зүй. 1999. /орч. Янжмаа Р., ред.Өнөрбаяр Ч. УБ., 2016.
- Рональд Дворкин. Хуулийн эзэнт гүрэн. Harvard University Press. /Орч. Очирсүх Я. УБ.: ХЗҮХ, 2015.
- Уранцэцэг Б. Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль (онол, арга зүйн тайлбар). УБ., 2001.
- Ханс Кельзен. Хэм хэмжээний тухай ерөнхий онол. М.,1979. Орчуулга. /ред.Амарсанаа Ж. Сарантуяа Ц. орч. Хатанбаатар.УБ.,2013.
- Цогтоо Ш. Нийтийн захиргааны удирдлага – эрх зүйн онол, практик, УБ., 2012., Захиргааны эрх зүй (тусгай анги) УБ.,2015.
- Чимид Б. БНМАУ-ын Захиргааны эрх зүйн ерөнхий ангийн үндсэн асуудал. УБ.,1973.
- Чойжамц Ц. "Цагдаагийн байгууллагын эрх зүйн бодлого, цаашдын чиг хандлагад шинжилгээ хийх нь". Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үүсэл, хөгжил эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл, УБ.,2011.
- Эрдэнэбаатар Д. "Гадаадын зарим орны цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандарт журмын системчлэлийн туршлага". //Цагдаа. 2010 №1/105, "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн актын системчлэл, түүнийг боловсронгуй болгох асуудал" //Хууль сахиулахуй. 2015. №2.
- Эрдэнэцогт А. Монгол Улсын захиргааны процессын эрх зүй. 2 дахь хэвлэлт. УБ.,2014.

Судалгааны тайлан

- Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хороо, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр. УБ., 2011
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ. УБ.,2015.
- Цагдаагийн байгууллагаас иргэдэд хүргэдэг үйлчилгээний мониторинг. IRIM хараат бус судалгааны хүрээлэн., УБ., 2014.
- Kevin W. Pitt Director of Ethics in Policing, Mongolian National Police Agency UK Study Visit Advisory Development Report., UK, 2008.
- Америкийн нэгдсэн улсын хөгжлийн агентлаг (USAID)-аас Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чадавхийн үнэлгээ хийсэн тухай тайлан. УБ.,2007.
- АТГ, ЦЕГ-ын хамтарсан "Цагдаагийн байгууллагын авилга, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй ажлын байр, албан тушаал, удирдах алба хаагчдын хандлагыг тодорхойлох" судалгаа
- Жанцан С нарын "Цагдаагийн алба хаагчийн ёс, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл" судалгаа. УБ.,2013.
- Максима судалгааны төв, цагдаагийн байгууллага, алба хаагчийн талаарх Улаанбаатар хотын иргэдийн санал бодлыг судлах судалгааны тайлан. УБ.,2007.
- Нээлттэй нийгэм хүрээлэн, Унгар дахь Үндсэн хууль, эрх зүйн хүрээлэн, Эрх зүйн санаачлага нээлттэй нийгэмлэг. "Цагдаа, олон нийтийн хамтын ажиллагаа хөтөлбөрийн үр дүн, цаашдын чиг хандлага". УБ.,2005
- Нямдорж Ц, Жанцан С нар. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байх зарчим" судалгаа. УБ.,2013.
- Философи, социологи, эрхийн хүрээлэн. "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдал, боловсронгуй болгох чиглэл" сэдэвт судалгааны тайлан. УБ.,2008.
- ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, кримнологийн сектор. "Цагдаагийн байгууллагын 2011, 2013 оны үйл ажиллагаанд хэрэглэгчээс өгсөн үнэлгээ" судалгаа УБ.,2012, 2014.
- Хууль зүйн яам., "Хүний нөөцийн томилолт, чөлөөлөлттэй холбоотой материалыг шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дотоод аудитын ажлын тайлан" УБ.,2015.
- Цагдаа судлалын өнөөгийн байдал судалгааны тайлан., УБ.: ХСИС, 2017.
- Монгол Улс дахь цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн төлөв байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам сэдэвт судалгааны тайлан. УБ., 2007.
- ЦЕГ, ДХАБГ, СШТ. "Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал" судалгаа. УБ.,2015.
- ЦЕГ-ын Судалгааны төв. "Гэмт хэрэг зөрчлийн улмаас хохирсон цагдаагийн алба хаагчдын өнөөгийн байдал" судалгаа. УБ.,2016. "Цагдаагийн алба хаагчдын ажил, албандаа хандах өөрчлөлтийн судалгаа". УБ., 2016. "Цагдаагийн алба хаагчид болон энгийн хүмүүсийн нийгмийн оюун ухаан болон дотоод баримжааг судалсан нь". УБ.,2016. "Цагдаагийн байгууллаганы гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дотоод хамтын ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал". УБ.,2016.

Гадаад хэл дээрх эх сурвалж

- Chiles R.Swanson. Leonard Termite and Robert W.Taylor. Police administration: structure, processes and behavior, 8th edition, US., Saint Leo University. 2011.
- Enkhbold B. Comparative study of the Confidence in the Police among Mongolian Koreans and Native Mongolian: A test of instrumental and Expressive Models, dissertation for degree of doctor. Kyonggi University, Seoul, South Korea., 2015.
- Freda Adler. Gerhard Mueller and William Laufer., Criminology, 6th edition, US., 2007.
- Joel Samaha. Criminal Justice 4th edition, US.,1994

- P.J.Ortmeier Joseph J.Davis. Police Administration: A Leadership Approach. US., Administration of Justice Grossmont College.2010.
- Ronald L Akers, Christine S. Sellers, Criminological Theories – introduction, Evaluation and Application, 5th edition, US.,2009.
- Samuel Walker, Charles M. Katz., The Police in America An Introduction, 5th edition, 2004.
- Адиньяев С.И. "Регламентирующая деятельность полиции и определяющая ее статус в системе правоохранительных органов" Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. М.,2013.
- Воронина Т.Н. "Нормативно-правовые акты МВД России в механизме административно-правового регулирования деятельности органов внутренних дел" Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. М.2001.
- Елеонский В.О. "Делопроизводство в органах внутренних дел". Диссертация на соискание ученой степени доктора юридических наук. М.,1992.
- Соловей Ю.П. "Правовое регулирование деятельности милиции в РФ" Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. М.,1993.
- Числов В.И. "Правовые и организационные вопросы стандартизации деятельности органов внутренних дел по оказанию услуг населению" Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук. М.,2010.

ЦАГДААГИЙН ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН АЖЛЫН АЧААЛАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ

Б.Баянмөнх
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн дэд профессор,
цагдаагийн хошууч

Хураангуй: Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг, тэр дундаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг засаг захиргааны анхан шатны нэгж болох хорооны иргэдийн дунд зохион байгуулах, түүнийхээ хэрэгжилтэнд хяналт тавих үүрэг бүхий цагдаагийн анхан шатны нэгжийн ажилтан бол хэсгийн байцаагч билээ.

Гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцсан нутаг дэвсгэр дээрээ олон нийтэд түшиглэн сайн зохион байгуулж, түүний хэрэгжилтэнд хяналт сайн тавьж чадваас гэмт хэрэг, зөрчил буурах нэг нөхцөл бүрдэнэ.

Тиймээс цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн орчин, ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйл, түүний шалтгаан нөхцөл, түүний арилгах арга замын талаар энэхүү өгүүлэлд товч авч үзсэн болно.

Түлхүүр үг: Хэсгийн байцаагч, урьдчилан сэргийлэх ажил, ажлын ачаалал, эрх зүйн зохицуулалт, ажлын заавар

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн байгууллагаас зонхилон хэрэгжүүлж, зохион байгуулж байгаа алба бол Нийгмийн хэв журам хамгаалах алба юм.

Цагдаагийн байгууллагын Нийгмийн хэв журам хамгаалах алба нь, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг амьдралд хэрэгжүүлэх, нийгмийн хэв журам, хууль ёсыг бэхжүүлэх үйл хэрэгт захиргааны үйл ажиллагааны бусад төрөлтэй харьцуулбал тэргүүлэх байр эзэлж, хуулиар хүлээсэн олон үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ үлэмж хэмжээний хүч хэрэгслиийг өөртөө нэгтгэсэн байдгаараа ихээхэн онцлогтой юм.

Тус алба нь, нийгмийн хэв журам сахиулах, өмч хөрөнгө, иргэдийн эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүнчлэн гэмт хэргийг илрүүлэхэд идэвхитэй оролцох ажлыг харилцан хамтран хэрэгжүүлэх, цагдаагийн төрөл мэргэжлийн албад, тэдгээрийн хүч хэрэгслийн нийлбэр, цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны бие даасан нэг төрөл бөгөөд энэхүү алба нь гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж удирдах үүрэг бүхий, цагдаагийн байгууллагын мэргэжлийн алба юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүргийг иргэдтэй хамгийн ойр ажилладаг, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын анхдагч нэгж нь цагдаагийн хэсэг юм. Иргэд хэсгийн байцаагчийн ажлын ур чадвар, үр дүнгээр нь цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааг бүхэлд нь үнэлж дүгнэх нь цөөнгүй байдаг бөгөөд нөгөө талаар тэдгээр нь хүн ам, хамт олон, иргэдийг цагдаагийн байгууллагатай холбогч гол албан тушаалтан болдог.

Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцэд зөвхөн нийслэлд төдийгүй, ихэнхи аймаг, сумдад цагдаагийн хэсгийг байгуулж, улсын хэмжээний нэгдмэл тогтолцоог бий болгожээ.[177]

Хууль хамгаалах байгууллагуудын нэг чухал зорилт бол гэмт хэрэг нэг бүрийг илрүүлж, гэм буруутай этгээдэд зохих хариуцлагыг шударгаар оногдуулахын хамт гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгааныг илрүүлж, цаг тухайд нь арилгуулах замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бүх аргаар зохиоход оршино.[178]

1923 онд Засгийн газрын хуралдаанаар олон түмэнд зориулсан анхны "Ухуулга бичиг"-ийг гаргаж, "Нийслэл хүрээний газар аливаа хүн архи уух, мөрийцөн наадах, хэрүүл шуугиан өдүүлэх, шөнийн цагаар чимээ гаргах, гал усны аюул болох, хулгайлах, булаах зэрэг бүхий л гашуун самууныг цагдан байцаалгах"-ыг олон түмэнд сануулж, "....цаазалсаныг зөрчвөөс цээрлэн шийтгэх" журмыг зөвшин батлан явуулсан байна

Уг журамд "Яамнаас зохих газруудад хүргүүлэн тушаасныг өөр өөрийн харъяат газруудаас олон дор зарлах тул....аливаа ухамсарлан мэдэж, хичээнгүйлэн дагаж явбаас зохимой" гэсэн заалт нь хэрэг явдлаас урьдчилан сэргийлэх, түүгээр ч барахгүй төр, захиргаанаас эхлээд нийт байгууллага, иргэдийн эрхэм үүрэг нь гэж тодотгож өгсөн чухал баримт болсон юм.[179]

Тэр үеэс эхлэн хууль ёсыг сахин биелүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон түмнийг татан оруулах талаар тухайн үеийн нам, төрийн байгууллагуудаас олон чухал арга хэмжээ авч ирсэн байна.

"Цагдаагийн байгууллагын тухай хуулиар даалгасан гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам хамгаалах урьдчилан сэргийлэх үүргийг хэрэгжүүлэхээр тодорхой нутаг дэвсгэрийн нэгжийг хариуцсан Цагдаагийн төв байгууллагаас томилсон цагдаагийн алба хаагчийг хэсгийн байцаагч[180]" гэж заасан байна.

Хэсгийн байцаагч нь Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий цагдаагийн байгууллагын анхан шатны нэгжийн ажилтан бөгөөд иргэдийн дунд ажиллах үндсэн албан тушаал юм.

---

[177] Ж.Долгорсүрэн., Д.Булган. Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс. УБ.2014. 107 дахь тал
[178] Ж. Авхиа. Гэмт явдал, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал. УБ. 1997. 159 дэх тал
[179] Л. Билгээ "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй" УБ. 2005. 11-12 дахь хуудас
[180] Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 229 дүгээр тушаалаар батлагдсан "Хэсгийн байцаагчийн ажлын заавар"-ын 1.2

Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны хамгийн гол барих ёстой чиглэл бол урьдчилан сэргийлэх ажил юм. Учир нь гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцсан нутаг дэвсгэр дээр сайн зохион байгуулж, түүний хэрэгжилтэнд хяналт сайн тавьсанаар, гэмт хэрэг, зөрчил буурах нэг нөхцөл бүрдэнэ.

Өнөөдөр, хэсгийн байцаагч нар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий уриа лоозон тавих, хурал, цуглаан, сургалт, семинар явуулахаас биш тодорхой хүн рүү чиглэсэн, нэг бүрчилсэн ажил зохиох нь илүү үр дүнд хүрдэгийг практик харуулж байна.

Цагдаагийнүйл ажиллагаандаа хэсгийн байцаагч нь Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Садар самуунтай тэмцэх тухай хууль зэрэг 13 гол хуульболон аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн баталсан нийтээр дагаж мөрдөх тогтоол, захирамж, шийдвэр, бусад эрхийн актуудын хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх үүргийг гүйцэтгэж байна.

Түүнчлэн Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлан мөрдөж буй Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд хамааралтай нийтдээ 35 орчим журмыг баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Цагдаагийн хэсгийн байцаагч нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 229 дүгээр тушаалаар баталсан "Хэсгийн байцаагчийн ажлын заавар", 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталгаажуулсан "Хэсгийн байцаагчийн ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт"-ыг үндэслэн ажлаа төлөвлөн, зохион байгуулж байна.

Үүний зэрэгцээ цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын зааварт дараах судалгаатай байхаар зохицуулалт орсон байна. Тухайлбал:

1. Сум, баг, хорооны зураглал,
2. Хүн амын судалгаа, өрхийн дэлгэрэнгүй бүртгэл,
3. Тухайн нутаг дэвсгэрт байрлах албан газар, байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн эдийн засгийн чадавх,
4. Гарсан гэмт хэрэг, зөрчил, түүний нөхцөл, шалтгааны талаарх судалгаа,
5. Тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдээд гэмт этгээд нь тогтоогдоогүй хэргийн судалгаа,
6. Гэмт хэрэг, зөрчилд холбогдогчийн судалгаа,
7. Гэмт хэрэг үйлдээд даалтанд байгаа, гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй сэжигтэй хүмүүсийн бүртгэл,
8. Эрэн сурвалжлагдаж буй оргодол, этгээдүүдийн судалгаа,
9. Хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй, ял хойшлогдсон хүмүүсийн судалгаа,
10. Гэр бүл, орчиндоо байнга тааламжгүй байдал гаргадаг хүмүүсийн судалгаа,
11. Тухайн нутаг дэвсгэрт түр оршин суух гадаадын болон харъяалалгүй иргэдийн судалгаа,
12. Автомашин, бууны бүртгэл,
13. Насанд хүрээгүй хүмүүсийг уруу татагчдын судалгаа,
14. Тамга, тэмдэг, олшруулагчийн бүртгэл судалгаа,
15. Туслах хүчний судалгаа[181] зэрэг объект, субьектын судалгаа хийж, баяжуулахаар заасан байна.

Мөн уг зааварт сум, дүүрэг, баг, хорооны Иргэдийн төлөөлөгчдийн болон нийтийн хурал, тухайн шатны Засаг дарга хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудлаар хэсгийн байцаагчийг удирдана гэж заажээ.

Үүний зэрэгцээ Иргэдийн төлөөлөгчдийн болон нийтийн хурал, тухайн шатны Засаг дарга нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэсгийн байцаагчтай хамтран ажиллах төлөвлөгөө гаргах, мөн хэв журам хамгаалах чиглэлээр олон нийтийн эргүүл, жижүүр ажиллуулах тухай захирамж гаргах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгт хяналтын камер суурилуулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлох, үнэлгээ гаргах, хөршийн хяналт хөтөлбөр гэх мэт ажлыг хэрэгжүүлж байна.

Өнөөдөр цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа зарим хүчин зүйлийн талаар 2016 онд ЦЕГ-ын Дотоод хяналт шалгалт, аудитын хэлтэс, Нийтийн хэв журам хамгаалах алба, Улаанбаатар хотын цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын хамтарсан ажлын хэсгийн хийсэн судалгаанаас дараах нөхцөл байдал тогтоогдсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны "Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай" 153 дугаар тогтоолоор 4000 хүн ам тутамд 1 хэсгийн байцаагч ажиллахаар жишиг нормативыг баталж, хүн ам, аж ахуйн нэгжийн нягтаршил ихтэй хороодод 3, бусад хороодод 2, нийт Улаанбаатар хотын хэмжээнд 271, орон нутагт 121, улсын хэмжээнд нийт 392 хэсгийн байцаагч нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг гүйцэтгэж байсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн "Улаанбаатар хотын цагдаагийн газар, харьяа нэгж, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн бүтцийн зураглал, орон тоо батлах тухай" Б/284 дүгээр тушаалаар хороонд 1 хэсгийн байцаагч ажиллуулж эхэлсэн бөгөөд нийслэлийн 152 хороонд 154, орон нутагт 122, нийт улсын хэмжээнд 276 хэсгийн байцаагчийн орон тоог баталсан.

---

[181] Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 229 дүгээр тушаалаар батлагдсан "Хэсгийн байцаагчийн ажлын заавар"-ын 5 дугаар зүйл

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 284 дүгээр тушаалаар баталсан бүтэц орон тоогоор Улаанбаатар хотын төвийн 14 дүүргийн цагдаагийн хэлтсийн нийтийн хэв журам хамгаалах тасагт дэд хэсгийн ахлагч 25, хэсгийн байцаагч 138, хороо хариуцсан цагдаа 138 нийт 201 алба хаагч хороо хариуцан ажиллаж байна.[182]

Дүүргүүд	БГД-1	БГД-2	БЗД-1	БЗД-2	БЗД-3	СБД-1	СБД-2	СХД-1	СХД-2	СХД-3	ХУД-1	ХУД-2	ЧД-1	ЧД-2	Бүгд
Дэд хэсгийн ахлах байцаагч	2	2	1	2	2	3	3	3			1	1	3	2	25
Хэсгийн байцаагч	13	10	8	11	9	8	12	13	9	10	5	11	9	10	138
Хороо хариуцсан цагдаа	13	10	8	11	9	8	12	13	9	10	5	11	9	10	138

2016 оны 4-р сарын байдлаар нийслэлд 147, орон нутагт 116, нийт 263 хэсгийн байцаагч ажиллаж байна. Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст 2, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэст тус бүр 1, Төв аймаг дах цагдаагийн газарт 3, Хэнтий аймгийн дахь цагдаагийн газарт 2, Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газарт 1, нийт 13 хэсгийн байцаагчийн орон тоо дутуу байна.

2017 оны 7 сарын байдлаар нийслэлд 1 401.2 мянган хүн болж байнга өсөн нэмэгдэж, 1 хороонд дунджаар 9218 хүн амьдарч байнга оршин сууж байна гэсэн судалгаа байна. Улаанбаатар хотод сүүлчийн 5 жилд бусад аймгаас 185.5 мянга, сүүлчийн нэг жилийн дотор 61.3 мянган хүн шилжин суурьшжээ.[183]

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор баталсан жишиг нормативын дагуу Улаанбаатар хотод 271, орон нутаг 121, улсын хэмжээнд нийт 392 хэсгийн байцаагч ажиллаж байсан бол өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод 154, орон нутагт 122, нийт 276 болж, 116 хэсгийн байцаагчийн орон тоо хасагдаж, 138 хороо хариуцсан цагдаагийн орон тоо нэмэгдсэн байна.

Гэтэл томилсон цагдаа нар нь тухайн дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлаас шалтгаалан хороон дээр нь ажлуулахгүй, албадан саатуулах, явган болон машинт эргүүл, жижүүрийн албан хаагч өвчтэй, чөлөөтэй, шилжсэн тохиолдолд уг орон тоог нөхөх байдлаар үүрэг гүйцэтгүүлж хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд туслалцаа, дэмжлэг үзүүлж чадахгүй болсон нь ажлын ачааллыг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болсон байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2011 оны "Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай" 153 дугаар тогтоолын хавсралтаар 4000 хүн ам тутамд 1 хэсгийн байцаагч ажиллахаар тогтоосон жишиг нормативыг мөрдөж ажиллаагүйгээс цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн буурах, алба хаагчдын ажлын ачаалал нэмэгдэх бас нэг хүчин зүйл болж байна.

Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, иргэдийг чирэгдэл, бухимдалгүй нэг цэгээс үйлчлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор иргэдэд нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн барилгыг үе шаттайгаар барих ажлыг эхлүүлсэн билээ. Өнөөдрийн байдлаар нийслэлийн 104 хэсгийн байцаагч цогцолбор байранд, 42 хэсгийн байцаагч цогцолбор байрны хонгилд, 4 хэсгийн байцаагч коридорт тусгаарласан өрөөнд, 8 хэсгийн байцаагч орон сууцны 1 дүгээр давхар буюу дэд хэсгийн байранд үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын цагдаагийн газрын даргын 2013 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн "Жишиг хэмжээг тогтоох тухай" 138 дугаар тушаалаар хэсгийн байцаагч нарт сард 125 ширхэг бичгийн цаас, 3000 төгрөгийн ярианы карт олгодог байна.

Судалгаа бүртгэлээ шинэчилж, үзэмжтэй хийхийн тулд өнгөт цаас, хавтас, хальсан уут авах, материалжуулах, хариуцсан хорооны нутаг дэвсгэрт байгаа ААНБ бүрт мэдэгдэл, зөвлөмж өгөх иргэдэд хандсан санамж, сэрэмжлүүлэг бэлтгэн орц, дэлгүүр, ААНБ бүрт байрлуулах, тусгай болон нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж материалжуулах, өргөдөл гомдлын материал бүрдүүлэх зэрэг ажлын зардлыг хувиасаа гаргаж байна.

Улаанбаатар хотын цагдаагийн газраас дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн хороодын байршил, хоорондох зайг километрээр тооцож судалгаа хийсэн байна. Судалгаанаас үндэслэн хэлтсийнхээ төв байрнаас хол хороодыг авч үзвэл: Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо 14.5 км, 15 дугаар хороо 20 км, 18, 20 дугаар хороо 13.5 км, 21, 23 дүгээр хороо 10.1 км, 28 дугаар хороо 11.1 км, Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо 19.6 км, Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо 14 км, 21 дүгээр хороо 60 км, 27 дугаар хороо 25 км, Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо16 км, Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо 29 км, 13 дугаар хороо 39 км, 14 дүгээр хороо 18 км зайтай байна гэсэн судалгаа гарсан байна.

Хэсгийн байцаагчийн өдөр тутмын гүйцэтгэж байгаа үндсэн үүргийн нэг бол "Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн заавар"-ын дагуу холбогдох бүртгэл судалгааг хөтөлж, санд оруулах, баяжилт хөдөлгөөн хийх ажил байдаг.[184]

---

[182] Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/284 дүгээр тушаалаар батлагдсан дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн бүтэц орон тооны жагсаалтаас авсан.

[183] Нийслэлийн статистикийн газраас гаргасан 2017 оны статистик тоо мэдээ

[184] Хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан. УБ.2016.

Хэсгийн байцаагчийн ажлын зааврaар хэсгийн байцаагч 15 төрлийн судалгаа хийхээр заасан бол Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх /код 703/ журмаар 41 бүртгэлийг хөтөлж мэдээллийн санд оруулахаар, захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй өргөдөл гомдол шалгасан тохиолдолд Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код 701/ журмаар 21 төрлийн маягтыг бөглөж санд оруулахаар байна.

Өнөөдөр нэг хэсгийн байцаагч нийт 77 төрлийн бүртгэл, судалгаа хөтлөхөөр зохицуулсан байдал харагдаж байна. Хэсгийн байцаагчийн өдөр тутмын гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй уялдуулан ажлын байрны тодорхойлолт, ажил дүгнэх үзүүлэлт, хэсгийн байцаагчийн ажлын зааврыг шинэчлэн боловсруулж, өөрчлөхгүй бол хэсгийн байцаагчийн өөрийн хариуцсан нутаг дэвсгэртэй урьдчилан сэргийлэх ажлыг бодитой зохион байгуулах, олон нийт, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг хангаж идэвжүүлэх, иргэдэд үзүүлэх цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд эрсдэл үүсэхээр байна.

Хэсгийн байцаагчийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, ажил дүгнэх шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тогтоох, ажлын ачааллыг бууруулах, урамшуулалын шинэлэг /*албан тушаалын зэрэглэлийг 1 шатаар нэмэгдүүлэх*/ арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй бол алба хаагчдын ажилдаа хандах хандлага сулрах, хэсгийн байцаагчаар ажиллах хүсэл сонирхолтой алба хаагчдын тоо цөөрөх үр дагавар үүсэхээр байна.[185]

Дээр өгүүлсэн нөхцөл байдлуудыг авч нэгтгэн авч үзвэл цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд дараах зарим хүчин зүйлүүд нөлөөлсөн байна гэж үзэж болохоор байна. Тухайлбал:

1. Цагдаагийн албаны тухай хууль хэрэгжсэнээр 2012 онд хэсгийн байцаагчийн үндсэн үйл ажиллагаанд мөрдөж байсан 17 эрх зүйн акт, өнөөдрийн байдлаар 30 болж өссөн;.
2. Урьдчилан сэргийлэх чиглэлээр хэсгийн байцаагчийн хийж гүйцэтгэх ажлыг тодорхой зааж өгөөгүйгээс энэ чиглэлийн бүх ажил, түүний үр дүн, хүлээх хариуцлага нь хэсгийн байцаагчид ногдох болсон;
3. Ажлын байрны тодорхойлолтод хэсгийн байцаагчийн гүйцэтгэх ажил үүргийг нарийн зааглаагүйгээс олон чиглэлийн ажил руу ордог, эргээд хийгдсэн ажлын гүйцэтгэл нь үнэлэгдэхгүй, хэрхэн яаж үнэлэх, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойгүй;
4. Хэсгийн байцаагчийн ажлын зааврaар хэсгийн байцаагч 15 төрлийн судалгаа хийхээр заасан боловч "Судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөх журам" /код 703/-аар 41 бүртгэлийг хөтөлж мэдээллийн санд оруулахаар тусгасан;
5. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй өргөдөл гомдол шалгасан тохиолдолд Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх журам /код 701/-аар 21 төрлийн маягтыг бөглөж санд оруулахаар зохицуулсан;

Дүгнэлт

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад засаг захиргааны анхан шатны нэгж болох хорооны хэсгийн байцаагч голлох үүрэгтэйгээр оролцдог юм байна.

Гэвч өнөөдрийг хүртэл цагдаагийн хэсгийн байцаагчийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах ажилд удирдлага, зохион байгуулалтын тодорхой шинэчлэл хийгдээгүй, гол эрх зүйн зохицуулалт /хэсгийн байцаагчийн ажлын заавар/ нь цаг үеийн шаардлага хангахаа байсан, үйл ажиллагааны арга, хэлбэр нэгэн хэвийн байдлаар явагдаж иржээ.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын заавар батлагдан хэрэгжээд 13 жил өнгөрсөн бөгөөд хууль, эрх зүйн орчин шинэчлэгдсэн, хэсгийн байцаагчийн ажлын чиг үүрэгт өөрчлөлт орсноор зарим заалт нь бодит байдалтай нийцэхгүй болсон байна.

Хэсгийн байцаагчийн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулахдаа зорилго, зорилтыг нарийвчлан тодорхойлоогүй, гүйцэтгэх ажлын цар хүрээ, хэмжээ хязгаарыг оновчтой тогтоогоогүй,бусад ажлын байртай давхардсан ажил үүргийг арилгаагүй байна.

Хэсгийн байцаагч нарын ажлыг тоон үзүүлэлтээр бус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааны үнэлэмжийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнг гол үзүүлэлт болгож, үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт, аргачлалыг оновчтой, ойлгомжтой байдлаар боловсруулах шаардлага бий болсон байна.

Санал

Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын ачааллыг бууруулах, гүйцэтгэх ажлын хамрах хүрээг нарийвчлан тодорхойлох замаар ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг бодитой болгох үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг, ажлын хамрах хүрээг нарийвчлан тодорхойлж, ажлын зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;
2. Хэсгийн байцаагчийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтэд түшиглэсэн хамтын ажиллагааны бодит үр дүн, чанарыг ажлын гол үзүүлэлт болгон ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулах;
3. Хэсгийн байцаагчийн ажлын талаархи буруу зөрүү ойлголтыг цагдаагийн нийт алба хаагчдад үнэн зөв сурталчилах замаар албан тушаалын үнэлэмжийг бий болгох;
4. Хэсгийн байцаагчаар ажиллах хүсэл сонирхолтой алба хаагчдын тоо нэмэгдүүлэх үүднээс албан тушаалын зэрэглэлийг 1 шатаар нэмэгдүүлэх;

---

[185] Энэхүү өгүүлэлд 2016 онд ЦЕГ-ын Дотоод хяналт шалгалт, аудитын хэлтэс, Нийтийн хэв журам хамгаалах алба, Улаанбаатар хотын цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын хамтарсан ажлын хэсгийн хийсэн судалгааны материал, зарим үр дүнг ашигласан болно.

5. Хэсгийн байцаагчийн ажлын байрыг цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбож, сүлжээний хурдыг нэмэгдүүлэх ажлыг Мэдээлэл, технологийн төвтэй хамтран хэрэгжүүлэх;

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН САНГААС ИРГЭДЭД НЭЭЛТТЭЙ БОЛГОХ МЭДЭЭЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ: СУДАЛГААНЫ ҮР ДҮН[186]

Б.Мөнхдорж, Д.Сумъяацэрэн, Б.Мөнхсэргэлэн
Цагдаа судлалын төв, Эрдэм шинжилгээ, хөгжлийн
хүрээлэн, Хууль сахиулахын их сургууль

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17-д "Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй..." гэж заасан хүний суурь эрхийг баталгаажуулж төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Монгол Улсын Их хурлаас 2016 оны 06 дугаар сарын 16-ний өдөр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг батлан мөрдөж байна.

Тус хууль нь Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай, Хувь хүний нууцын тухай, Цагдаагийн албаны тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гүйцэтгэх ажлын тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Байгууллагын нууцын тухай хууль тогтоомжид нийцэж гарсан бөгөөд хуульд хориглосноос бусад мэдээлэл авах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн. Энэ хуулиар иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг авч болохоор тодорхойлсон бөгөөд мэдээлэл авах хэлбэр, төрлийн нарийвчлан зохицуулсан. Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглосон дараах нөхцөлийг хуульчилсан байна. Үүнд:

- тухайн мэдээллийг нийтэд ил болгосноор Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодитой үндэслэл байгаа бол;
- тухайн мэдээлэл нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, өрсөлдөөний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хянан шалгагдаж байгаа асуудалтай холбоотой бол;
- хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол;
- тухайн мэдээлэл нь олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах явцтай холбоотой бол гэж тус тус заажээ.

Түүнчлэн, тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "Оюуны өмчтэй холбоотой мэдээллийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулах", 20 дугаар зүйлд "Хуульд өөрөөр заагаагүй бол хувь хүн бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээллийг бусдад задруулах", 21 дүгээр зүйлд "Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээдийн (гүйцэтгэх удирдлага буюу түүнээс эрх олгосон бусад этгээд) бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг тус тус хориглосон байна. Иймд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагаас мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа нь энэ хуулиар зохицуулагдах боловч хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны явцад нууцалвал зохих мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэг хүлээхгүй юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 12 дугаар зүйлд Иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууцыг хуулиар хамгаалах ба энэхүү эрхийг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно гэж заасан нь байцаан шийтгэх ажиллгаанд оролцогч бүр хэргийн талаар бүх мэдээллийг шаардан авах эрх эдлэхгүй гэдгийг тодорхойлж байна. "Хүснэгт 1"-т үзүүлснээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллгааны явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхмжлэгч, иргэний хариуцагчийн мэдээлэл авах хүрээ, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын мэдээлэл өгөх үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт-1

ЭБША-нд оролцогч	Мэдээлэл авах эрх	Мэдээлэл өгөх үүрэг
Сэжигтэн	"...ямар хэрэгт сэрдэгдэж байгаагаа мэдэх"; "Өөртэй нь холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэсэн, баривчилсан буюу таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах".	...Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ямар хэрэгт сэрдэгдэж байгааг сэжигтэнд тэр даруй, түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн эсхүл өмгөөлөгчид нь 48 цагийн дотор мэдэгдэнэ.
Яллагдагч	...ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх; ...яллагдагчаар татсан болон таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах; ...өөрт холбогдсон хэргийн материалтай танилцах;	

[186] АНУ-ын Азийн сан, Улсын Ерөнхий прокурорын газрын захиалгаар ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн 2017 онд гүйцэтгэсэн "Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас иргэдэд нээлттэй болгох мэдээллийн хэрэгцээг тодорхойлох" (гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн талаар)" судалгааны үр дүнгээс тоймлон авав.

	...шинжээч томилсон тогтоол болон шинжээчийн дүгнэлттэй танилцах.	...Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын бүх ажиллагааг хийж дуусан, хэргийг шийдвэрлэх хангалттай нотлох баримт цугларсан гэж үзвэл энэ тухай яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгч, төлөөлөгчид мэдэгдэж, тэмдэглэл үйлдэнэ. ...Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дуусаныг мэдэгдэх, хэргийн материал танилцуулах
Өмгөөлөгч	...өмгөөлж байгаа үйлчлүүлэгчийнхээ болон өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байлцаж...; ...өөрийн байлцсан байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцах...; ...хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дуусаны дараа хатаст хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад үл хамаарах нотлох баримтыг өөрийн зардлаар хувилах, хуулбарлан авах;	
Хохирогч	...Хохирогч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дуусаны дараа хавтаст хэргийн бүх материалтай танилцах.	
Иргэний нэхэмжлэгч, хариуцагч	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дуусан үед хэргийн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгтэй танилцах.	
Хөндлөнгийн гэрч	...Хөндлөнгийн гэрч нь өөрийнхөө оролцсон байцаан шийтгэх ажиллагааны талаар гомдол гаргах, байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцах...	

Дээрх мэдээлэл авах эрх зүйн зохицуулалтанд дүн шинжилгээ хийж үзвэл <u>эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хэргийн өөрт холбогдох мэдээллийг авах эрхтэй байдаг</u> бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дуусмагц хэргийн материалтай бүхэлд нь танилцуулах үүрэгтэй байна.

Шүүх, хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан мэдээллийн давхардлыг арилгах, гомдол мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хянан шалгах, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны менежментийг сайжруулан хялбаршуулах, цахим мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгоор хэрэгжүүлж буй "Хууль зүйн цахим нэгтгэл" төсөл нь 2014 оноос өнгөрсөн он буюу 2016 он хүртэлх хугацаанд Төрийн холбооны газар, ТЕГ-ын Кибер аюулгүй байдлын газар, Үндэсний дата төв, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг байгууллагуудтай хамтран Шүүх, Прокурор, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын гэмт хэргийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгон хэрэгжиж төгсгөлийн шатандаа яваа төсөл юм. Тус төслийн хүрээнд нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, нэгдсэн сүлжээний орчин үүсгэх, эрх зүйн орчин бүрдүүлэх, бүртгэлийн системийг шинээр болон шинэчлэх, шүүх, хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн тайлан, иргэд хандах боломжтой портал сайтыг хөгжүүлэх зэрэг тогтолцоо бий болох юм.

Бидний судалгааны зорилго хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, иргэдэд хэрэгцээтэй мэдээллийг тодорхойлох явдал байсан бөгөөд энэ үүднээс тусгайлан боловсруулсан асуултаар хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаар үйлчлүүлж байсан 99 иргэний дунд судалгаа явуулж, дүгнэлт хийв. Судалгаанд оролцогчдын нийгэм, хүн ам зүйн ерөнхий шинжийг авч үзвэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллгаанд ямар нэгэн байдлаар оролцож байсан талаар өөрийн байр суурийг бүрэн илэрхийлэх боломжтой иргэд гэж дүгнэв.

Судалгаанд оролцогчдын 66.7% нь эрэгтэй, 18-40 насны 70 орчим хувь, дээд боловсролтой иргэн 50 орчим хувийг эзэлж байгаа нь эрэгтэй, дээд боловсролтой, дундаж насыхан шүүх, хууль сахиулах байгууллагтай холбогдох нь түгээмэл байна.

<u>Асуулт-1. "Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас олж авахад хамгийн хүндрэлтэй, хаалттай ямар мэдээлэл байдаг бэ?"</u>

Судалгааны ажлын үндсэн зорилтын нэг нь шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын зүгээс иргэдэд нээлттэй болгох мэдээ, мэдээлэл, түүний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох явдал байсан. Тиймээс судалгаанд оролцогчдоос *"<u>Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас олж авахад хамгийн хүндрэлтэй, хаалттай ямар мэдээлэл байдаг бэ?</u>"* гэсэн асуултыг нээлттэй тавьж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үе шат тус бүрээр тодорхой санал бичүүлж авсаныг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт -2. Иргэдэд нээлттэй болгох шаардлагатай мэдээллийн жагсаалт

№	*Байцаан шийтгэх ажиллагааны үе шат*	*Хариулт*
1	*Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд*	-Хэрэг хэзээ шийдэх талаар хэлдэггүй; -Хохирогчийн талаар мэдээлэл өгдөггүй; -Хавтаст хэрэгтэй сайн танилцуулдаггүй; -Хэргийг шалган шийдвэрлэх явц байдал; -Өөрийн хэргийн талаар мэдээлэл авахад тааруу; -Хохирогч санал гомдолтой эсэх; -Хэргийг бүрэн эхээр нь хуулбарлаж авах боломжоор хангах;

		-Холбогдогч этгээдийн талаарх мэдээлэл; -Эрх, үүргийн талаар тодорхой ойлголт өгдөггүй; -Хэргийн газрын нөхцөл байдал; -Хэргийн талаар хангалттай хэлдэггүй, тодорхой бус байдаг; -Ажиллагааны нууцлал гэсэн шалтгаанаар бүгд мэдээлэл өгөх дургүй, хүссэн мэдээллээ авахад хүндрэлтэй байдаг; - гэх мэт
2	*Прокурорын хяналтын шатанд*	-Хэзээ дуудахаа хэлдэггүй; -Мэдээлэл огт өгдөггүй, тухайлбал хэргийг хэзээ шүүхэд шилжүүлэх; -Хяналтын хугацаа; -Эцэслэн шийдвэрлэх хугацаа -Шүүхэд шилжүүлсэн эсэх; -Хэргийг бүрэн эхээр нь хуулбарлаж авах боломжоор хангах; -гэх мэт
3	*Шүүх*	-Хэргийн явц, оногдуулах ял; -Шүүх хуралдааны тов; -Хэргийн талаар тодорхой мэдээлэл огт өгдөггүй; -гэх мэт
4	*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд*	-Үйлчлүүлэгчийг хаана ямар хорих ангид шилжихийг хэлдэггүй; -Хэн гэдэг шийдвэр гүйцэтгэгч хариуцаж байгаа талаарх мэдээлэл; -Шийдвэр биелүүлэх хугацаа; -Шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгааны талаарх мэдээлэл; -Мэдээлэл авах гэж маш их хугацаа алддаг; -Тогтоол гүйцэтгэлийг хангах үйл явц болох нэхэмжлэлийг барагдуулах ажиллагааны талаар, хугацаа болон нуугдмал орлогын талаар асуусан асуудал; -гэх мэт

Дээр дурдсан шаардлагатай гэж үзэж багаа мэдээлэл нь зарим тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлалд хамаарах баримт мэдээлэл хамаарч байна. Зарим талаар иргэдэд нээлттэй хүргэж байгаа мэдээллийг хэрхэн хүсэлт гаргаж, хаанаас олж авах талаар тодорхой мэдээлэл байдаггүй бөгөөд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдаас нэхдэг хүндрэл учирч байна. Түүнчлэн, эрүүгийн байцаан шийтгэх ажиллгааны явцад хэргийн материалтай танилцах тодорхой эрх нь тухайн ажиллагаанд оролцогч субьект болон өмгөөлөгчид олгогдсон байдаг. Энэ нөхцөл байдлаас шалтгаалан гэр бүлийн гишүүд зарим тохиолдолд хэргийн материалтай танилцах хүсэлт гаргадаг боловч хүсэлтийг нь хангах боломж байдаггүй байна. Тухайлбал, хорих ангид ял эдэлж байгаа ялтан өөрийн талаарх мэдээллээ гэр бүлийнхэндээ өгдөггүй тохиолдол гардаг, нөгөө талаас алба хаагчид шаардлагатай мэдээллийг зөвхөн ялтанд өгдөг байна.

Асуулт-2. Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх ямар мэдээ, мэдээллийг хувь хүн Танд нээлттэй болгох шаардлагатай гэж үзэж байна вэ?

Хүснэгт 3-т үзүүлснээр оролцогчдын хамгийн өндөр санал өгсөн мэдээлэл нь *цагдаагийн байгууллагын хувьд иргэд гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн мэдээлэл 91.3%, прокурорын байгууллагын хувьд хяналтын прокурорын шийдвэр 84.0%, шүүхийн байгууллагаас шүүхийн шийдвэр 98.4%, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шүүхийн шийдвэр хэрэгжиж эхэлсэн байдал 81.5%* гэж тус тус хариулсан байна.

Хүснэгт-3. Иргэнд нээлттэй болгох шаардлагатай мэдээлэл

	Байгууллага	**Шаардлагатай**		**Шаардлагагүй**		**Мэдэхгүй**		**Дүн**
	Цагдаагийн байгууллагаас	тоо	(%)	тоо	(%)	тоо	(%)	
1.	Гомдол, мэдээлэл, хэргийг шалгаж буй алба хаагч	59	75.6	16	20.5	3	3.8	78
2.	Хэрэгсэхгүй болгох санал гаргасан байдал	54	75.0	13	18.0	5	6.9	72
3.	Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт	63	91.3	3	4.3	3	4.3	69
	Прокуророос							
4.	Эрүүгийн хэргийг хүлээн авсан огноо	50	73.5	12	17.6	6	8.8	68
5.	Эрүүгийн хэрэгт хяналт тавьж буй прокурорын нэр	51	75.0	10	14.7	7	10.2	68
6.	Хяналтын прокурорын шийдвэр	58	84.0	5	7.2	6	8.6	69
7.	Прокурорт яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар явуулсан санал, шийдвэр	54	81.8	8	12.1	4	6.0	66
8.	Гомдол хүсэлт гаргах журам,	50	78.1	7	10.9	7	10.9	64

	заавар							
	Шүүхээс							
9.	Шүүх хүлээн авсан огноо	38	64.4	16	27.1	5	8.4	59
10.	Хянан шийдвэрлэх шүүгчийн нэр	47	72.3	13	20.0	5	7.6	65
11.	Шүүхийн шийдвэр	65	98.4	0	0.0	1	1.5	66
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас							
12.	Шүүхийн шийдвэр хэрэгжиж эхэлсэн байдал	53	81.5	5	7.6	7	10.7	65
13.	Давж заалдах гомдол гаргах хуулийн заалт	48	72.7	10	15.1	8	12.1	66
14.	Бусад	38	86.3	2	4.5	4	9.0	44

Судалгааны дүнгээс үзэхэд, иргэд тухайн байгууллагаас гардаг шийдвэрийн талаар мэдэхийг хамгийн их хүсдэг байна. Гэвч дээрх байгууллагууд ямар нэгэн шийдвэр гаргахдаа заавал холбогдох хүмүүст мэддэг хуулийн болон зохион байгуулалтын зохицуулалттай байдаг. Гагцхүү гэр бүлийн гишүүд эсхүл тодорхой шийдвэр гарахын өмнө урьдчилсан байдлаар хэргийн явц байдлын талаар танилцахыг хүсч мэдээлэл хайдаг нөхцөл байдал дээрх хариултад мөн нөлөөлөх талтай.

Асуулт-3. "Цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэргийн талаарх мэдээллийг Танд ямар арга замаар нээлттэй болговол зүйтэй вэ?"

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллаганд оролцогч болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаар үйлчлүүлэгчид хурдан шуурхай хүргэж байх нь мэдээллийн ил тод байдлын агуулгыг илэрхийлдэг. Тиймээс бид судалгаанд оролцогчид *"Цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гэмт хэргийн талаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, гэмт хэргийн талаарх мэдээллийг Танд ямар арга замаар нээлттэй болговол зүйтэй вэ?"* гэсэн асуулт тавьж хариулт авлаа.

Судалгаанд оролцгчдын 32 буюу 32.3% цахим шуудангийн хаягаар хүргүүлдэг байх, 47 буюу 47.5% нь тусгайлан цахим хуудсанд нэвтэрч, нэр, нууц үгээр ашиглан мэдээлэл авдаг байх, 35 буюу 35.4% нь гар утсанд захидал очдог байх, 11 буюу 11.1% нь амаар, 20 буюу 20.2% нь бичгээр, 1 буюу 1% нь бусад хэлбэрээр гэж тус тус хариулсан байна. Дүнг "хүснэгт 4"-т үзүүлэв.

Хүснэгт-4. Мэдээлэл нээлттэй болгох хэлбэр

№	Үзүүлэлт	**Тоо**	%
1	Цахим шуудангийн (мэйл) хаягаар хүргүүлдэг байх	**32**	32,3
2	Тусгайлан сайтад нэвтэрч, нэр, нууц үгээр ашиглан мэдээлэл авдаг байх	**47**	47,5
3	Гар утсанд захидал очдог байх	**35**	35,4
4	Амаар	**11**	11,1
5	Бичгээр	**20**	20,2
6	Бусад	**1**	1,0

Судалгаанд оролцогчдын хариултыг нэгтгэн үзвэл өөртэй нь холбогдсон мэдээлэл, хүсэлт, гомдлын хариуг аль болох амаар авах хэлбэрээс татгалзах хандлагатай байгаа бол цахим сүлжээ ашиглан шаардлагатай мэдээлэл, өргөдөл гомдлын хариу авах боломжийг бүрдүүлэхийг хүсч байна. Судалгааны явцад гэмт хэрэг, зөрчил, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийг цахим сүлжээ ашиглан иргэдэд хүргэж байгаа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллага байгаа эсэх талаар судалгаа хийж үзсэн болно.

Монгол Улсын анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдийг олон нийтэд ил тод болгосон, мөн шүүх хуралдааны товч, зар мэдээллийг иргэдэд нээлттэй байдлаар хүргэсэн http://www.shuukh.mn цахим хуудас ажиллаж байна. Уг сайтад өнөөгийн байдлаар 53148 хэргийн 69881 шийдвэр байна. Мөн эрүүгийн хэргийн шүүхийн тогтоолуудыг байршуулснаас хэргийн эцсийн шийдвэрлэлтийг харах боломж бүрдэнэ. Харин шүүхэд "иргэн-2014" гэсэн програмыг ашигладаг бөгөөд иргэний хэрэг, маргаан нь аль шатны шүүх дээр ямар шатанд байгаа талаарх мэдээллийг иргэд авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагад http://www.service.police.gov.mn/ цахим хуудас 2015 оны 08-р сараас эхлэн ажиллуулж байна. Цагдаагийн байгууллагад хандаж иргэдээс амаар, бичгээр, утсаар, цахимаар гаргасан өргөдөл, гомдлыг аль газар, хэлтэс, нэгжийн ямар албан тушаалтан шалгаж, ямар шийдвэр гаргасан талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй болгожээ. Ингэхдээ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 202 код журамд заасны дагуу "Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авсан тухай тэмдэглэл"-г хөтөлж, иргэдэд бүртгэлийн дугаар бүхий хяналтын хуудас өгдөг байна. Өргөдөл, гомдол гаргасан иргэн нь бүртгэлийн дугаар, регистрийн дугаараараа http://www.service.police.gov.mn/ бүртгүүлж, шийдвэрлэлтийг харах боломжийг бүрдүүлжээ. Ингэснээр цагдаагийн байгууллага болон алба хаагчтай холбоотой мэдээ мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол өгөх, бүртгүүлсэн эрхээрээ нэвтрэн орж өгсөн өргөдөл, гомдлын явц болон шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл, тэмдэглэл зэргийг дэлгэрэнгүйгээр хүлээн авах боломжтой болжээ.



Асуулт-4. "Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг та хэрхэн үнэлэх вэ?"

Мэдээллийн ил тод байдлыг хэмжих өөр нэг аргачлал нь шүүх, хууль сахиулах байгууллагуудад мэдээллийн и тод байдлын талаарх иргэдийн хандлага юм. Учир нь мэдээлэл ил тод байх нь иргэдийн хандлагад эерэгээр нөөлдөг бол мэдээлэл хааалттай байх нь сөргөөр нөлөөлдөг гэж үздэг. Тиймээс гэсэн асуултыг оролцогчдод тавьж үр дүнг байгууллага тус бүрээр гаргав. "График 1"-т үзүүлснээр цагдаагийн байгууллагын мэдээлийн ил тод байдлыг маш сайн буюу сайн гэж судалгаанд оролцогчдын 44.7% нь үзсэн бол прокурорын байгууллагын мэдээллийн ил тод байдлыг маш сайн буюу сайн гэж 39.8%, шүүхийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг маш сайн буюу сайн гэж 49.4% нь, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллийн ил тод байдалд маш сайн буюу сайн гэж 36.5% нь тус тус үнэлсэн байна.

График -1. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлын талаарх иргэдийн төсөөлөл



Судалгаанд оролцогчдын 55.3% нь цагдаад, 60.2% нь прокурорт, 50.6% нь шүүхэд, 63.5 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад дунд-муу-маш муу гэсэн үнэлгээг сонгож үнэлсэн байна. Эндээс үзвэл, иргэд шүүхийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг бусад байгууллагатай харьцуулахад харьцангуй өндөр гэж дүгнэсэн бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангалтгүй гэж үзсэн байна. Цагдаагийн болон прокурорын багууллагын мэдээллийн ил тод байдал дундаж түвшинд байна. Түүнчлэн, иргэд байгууллагын мэдээллийн ил тод байдлыг үнэлэхдээ алба хаагчдын харилцааны соёл, хандлагаар дүгнэдэг. АНУ-ын Мичиганы Их сургуулийн социологийн тэнхимээс 2012 онд 4000 иргэний дунд явуулсан "нийгмийн үнэт зүйлсийн судалгаа"-ны үр дүнгээр төрийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ур чадвар нь иргэдийн мэдээлэл олж авах эрхэд шууд нөлөөлдөг гэж дүгнэжээ. Өөрөөр хэлбэл, харилцааны соёл ур чадвар муутай алба хаагчидтай байгууллагаас мэдээлэл авахад хүндрэлтэй, хаалттай байдаг гэж үзжээ (Hwang 2014).

Энэ дүгнэлтийг шалгах зорилгоор хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ур чадварын талаарх иргэдийн хандлагыг тодорхойлох оролдлого хийсэн. Судалгаанд оролцогчдоос *"Дараах байгууллагуудын алба хаагчдын иргэдтэй харилцах хандлага, төлөвшлийг та хэрхэн үнэлэх вэ?"* гэсэн асуулт тавиад хариултыг байгууллага тус бүрээр нь гаргаж, өмнөх асуулгын үр дүнтэй харьцуулан дүгнэлт хийсэн болно.

"График 2"-д үзүүлснээр шүүхийн алба хаагчдын харилцааны соёл, хандалгад судалгаанд оролцогчдын 59.2% нь сайн буюу маш сайн гэсэн үнэлэлт өгсөн нь бусад байгууллагын алба хаагчтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байсан бол муу буюу маш муу гэж 8.5% нь үнэлсэн нь мөн хамгийн бага үзүүлэлт болж байна. Түүнчлэн, иргэдийн 52.2% нь цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, төлөвшлийг

маш сайн буюу сайн гэж дүгнэсэн бол энэ үзүүлэлт прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд 50 хувьд хүрэхгүй байна.

График-2. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудын харилцааны соёл, хандлага



Дээрх судалгааны дүнгээс үзвэл, иргэд шүүх, цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, төлөвшил, мэдээллийн ил тод байдал бусад байгууллагатай харьцуулахад өндөр байгаа нь Мичиганы их сургуулийн эрдэмтдийн дүгнэлтийг баталж байна. Түүнчлэн, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, алба хаагчдын харицааны соёл, төлөвшлийн талаарх иргэдийн хандлагын судалгааны үр дүнгийн үнэлгээ дээрх 2 асуултын хувьд ижилхэн гарч байгаа нь прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээрх асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт

1. Мэдээлэл авах эрх зүйн зохицуулалт бүрдсэн бөгөөд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хэргийн өөрт холбогдох мэдээллийг авах эрхтэй байдаг бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дуусмагц хэргийн материалтай бүхэлд нь танилцуулах үүрэгтэй байна.

2. Иргэд гэмт хэрэг, зөрчилд хобогдсон гэсэн шалтгаанаар хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагатай хамгийн их холбогддог бөгөөд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл хамгийн ихээр авдаг бол гомдол, мэдээлэл шалгаж буй алба хаагчдын талаарх мэдээлэл, хэрэгсэхгүй болгосон санал гаргасан байдал, байцаан шийтгэх ажиллагааны явц байдлын талаар мөн мэдээлэл авдаг байна. Харин эрүүгийн хэрэгт хамааралтай бусад хүмүүсийн талаарх мэдээлэл авдаг гэсэн хариулт хамгийн бага буюу нийт оролцогчдын 5 хувь нь хариулж байгаа нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллгааны явцад зөвхөн өөртэй нь холбоотой мэдээллийг танилцуулдагтай холбоотой. Мөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын зүгээс хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хувийн байдалтай холбоотой мэдээлэл авах сонирхол ихтэй байдаг байна. Тухайлбал гэрийн хаяг, төрсөн газар, найз нөхөд гэх мэт.

3. Судалгаанд оролцогчдын 69 буюу 69.7 хувь нь 1-2 удаа, 15 буюу 15.2 хувь нь 3-4 удаа, 8 буюу 8.1 хувь нь 5-6 удаа, 5 буюу 5.1 хувь нь 6-аас дээш удаа мэдээлэл авч байсан гэж тус тус хариулж байгаа нь иргэдийн мэдээлэл авах хэрэгцээ шаардлага өндөр байгааг харуулж байгаа юм. Харин хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас авч буй мэдээлэлийн нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа талаар харилцан адилгүй санал илэрхийлсэн байна. Энэ нь тухайн иргэн ямар төрлийн мэдээлэл шаардаж байгаагаас хамааран сэтгэл ханамжийн байдал өөр өөр гарч байна.

4. Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагаас олж авахад хамгийн хүндрэлтэй, хаалттай мэдээлэл маш их байдаг талаар судалгаанд оролцогчид санал илрэхийлж байна. ялангуяа ар гэрийнхний хувьд мэдээлэл маш хаалттай байдаг гэж дүгнэж байна. Судалгаанд оролцогчдын хариултыг нэгтгэн үзвэл өөртэй нь холбогдсон мэдээлэл, хүсэлт, гомдлын хариуг аль болох амаар авах хэлбэрээс татгалзах хандлагатай байгаа бол цахим сүлжээ ашиглан шаардлагатай мэдээлэл, өргөдөл гомдлын хариу авах боломжийг бүрдүүлэхийг хүсч байгаа юм.

5. Судалгаанд оролцогчдын 55.3% нь цагдаад, 60.2% нь прокурорт, 50.6% нь шүүхэд, 63.5 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад, дунджаар 57.5% нь хуулийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдалд дунд-муу-маш муу гэсэн үнэлгээг сонгож үнэлсэн байна. Судалгааны дүнгээс үзвэл, иргэд шүүхийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг бусад байгууллагатай харьцуулахад харьцангуй өндөр гэж дүгнэсэн бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангалтгүй гэж үзсэн байна. Цагдаагийн болон прокурорын багуллагын мэдээллийн ил тод байдал дундаж түвшинд байгаа бөгөөд тус байгууллагуудын алба хаагчдын харилцааны соёл, ур чадвар нь иргэдийн мэдээлэл олж авах эрхэд шууд нөлөөлж байна.

6. Шүүхийн ажилтнуудын харилцааны соёл, хандалгад судалгаанд оролцогчдын **59.2%** нь сайн буюу маш сайн гэсэн үнэлэлт өгсөн нь бусад байгууллагын алба хаагчтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байсан бол муу буюу маш муу гэж 8.5% нь үнэлсэн нь мөн хамгийн бага үзүүлэлт болж байна. Түүнчлэн, иргэдийн 52.2% нь цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, төлөвшлийг маш сайн буюу сайн гэж дүгнэсэн бол энэ үзүүлэлт прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд 50 хувьд хүрэхгүй байна. Эдгээр судалгааны үр дүнгээс үзвэл иргэд шүүх, цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл,

төлөвшил, мэдээллийн ил тод байдал бусад байгууллагатай харьцуулахад өндөр байгаа нь Мичиганы их сургуулийн эрдэмтдийн дүгнэлтийг баталж байна. Түүнчлэн, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, алба хаагчдын харицааны соёл, төлөвшлийн талаарх иргэдийн хандлагын судалгааны үр дүнгийн үнэлгээ дээрх 2 асуултын хувьд ижилхэн гарч байгаа нь прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээрх асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Судалгааны үр дүнг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллаганы үе шатууд дахь хугацаа, түүнийг сунгах, тухайн шатнаас гарах шийдвэрийг танилцуулах ажиллагааг мөрдлөгө болгох;
2. Байцаан шийтгэх ажиллагааны явцад гарсан цагдаагийн санал, шийдвэр, прокурорын шийдвэр, шүүхийн шийдвэр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хугацаа зэргийг иргэдэд нээлттэй болгох;
3. Тодорхой шийдвэрийг гар утсанд захиагаар очдог систем, гэр бүлийн гишүүдэд нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явц байдлыг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтнаас хамааралгүй танилцдаг цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;
4. Хөдөө орон нутаг дахь байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдыг холбогдох мэдээ, мэдээллээр хэрхэн хангах асуудлыг харгалзан үзэх;
5. Энэ талаарх гадны орны туршлагыг харьцуулан судалж үзэх (тухайлбал, Check My crime, Trick my crime[187]), байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын хувийн нууцтай холбоотой мэдээллийн нууцлалыг хангах асуудлыг харгалзан үзэх нь зүйтэй.

[187] https://www.police.wa.gov.au/Police-Direct/Check-my-crime